



**ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ,
ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ
ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2023 он

Австрали-Монголын 50 жилийн ойд зориулсан тэтгэлгийн хүрээнд "Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ"-ийн судалгааны тайланг хийж гүйцэтгэв.

Монгол Улс, Улаанбаатар хот 211238
Шуудангийн хайрцаг-321, Утас/факс: 976-11-311512
Итгэлийн утас: 1800-1903
Нүүр хуудас: Mongolia Gender Equality Center
И-мэйл: gendereqcen@gmail.com
Вэб хуудас: www.stoptrafficking.mn

АГУУЛГА

ЗУРАГ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭ	4
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	8
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР	
Талархал.....	8
Судалгааны хураангуй	12
Судалгааны зорилго, зорилт	15
Судалгааны арга зүй, аргачлал.....	17
Мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл бэрхшээл, даван туулсан байдал, сургамж	18
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	20
1.1. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн нөхцөл байдал, хохирогчид үзүүлж буй туслалцаа дэмжлэг	
1.2. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал /шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ/.....	
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ	32
2.1. Үндэсний эрх зүйн зохицуулалт	66
2.2. Олон улсын эрх зүйн зохицуулалт	74
2.2.1. Нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн тайлан, түүнд өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилт	68
ДҮГНЭЛТ	88
ЗӨВЛӨМЖ.....	91
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	93
ХАВСРАЛТ	94

ЗУРАГ, ХҮСНЭГТ, ШИГТГЭЭ

Зураг 1.	Судалгааны арга зүй	12
Зураг 2.	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх үзүүлэлт	21
Зураг 3	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн байршлын харьцуулалт	22
Зураг 4.	2018-2021 онд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн тоон мэдээлэл	22
Зураг 5.	Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн тоон мэдээлэл	23
Зураг 6.	Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тоон мэдээлэл	23
Зураг 7.	Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн тоон мэдээлэл	24
Зураг 8.	Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн (100) бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүмүүсийн насны харьцуулалт	26
Зураг 9.	14 хүртэлх настай хохирогчдын насны бүлгийн судалгаа	26
Зураг 10.	14-16 хүртэлх насны хохирогч нийт 23 хүүхдийн насны мэдээлэл	27
Зураг 11.	16-18 хүртэлх насны хохирогч нийт 11 хүүхдийн насны мэдээлэл	27
Зураг 12.	Гэмт хэрэг үйлдэгдсэн газар	28
Зураг 13.	Гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч хохирогчийн хамаарал	29
Зураг 14.	Хохирогчийн эрхшээлд нь орсон тухай үзүүлэлт	31
Зураг 15.	Нотлох баримтын төрөл	34
Зураг 16.	2019-2021 онд Шүүх эмнэлэгийн шинжилгээний газарт бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт	35
Зураг 17.	Хүчиндэх, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт хийсэн шинжилгээний тоог нас, хүйсээр харьцуулсан байдал	36
Зураг 18.	Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал	41
Зураг 19.	Хүүхдийн тусламжийн 108 утсанд бэлгийн хүчирхийллийн талаар ирсэн дуудлага, мэдээлэл	42
Зураг 20.	Хүүхдийн тусламжийн 108 дугаарт ирсэн бэлгийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг ангилан авч үзвэл:	43
Зураг 21.	Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлсэн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ /давхардсан тоогоор/	43
Зураг 22.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал	44
Зураг 23.	Шүүхийн статистик мэдээлэл /Хүчиндэх гэмт хэргийн шийдвэрлэлт/	44
Зураг 24.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал	45
Зураг 25.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал	45
Зураг 26.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал	46

Зураг 27.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал	46
Зураг 28.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Зөрчлийн тухай хуулийн 6.18.4, 6.18.7 дахь хэсэгт заасан зөрчлийн статистик мэдээлэл	47
Зураг 29.	Судалгаанд ашигласан 100 хэрэгт хамаарах шүүгдэгчийн тоо	49
Зураг 30.	Гэмт хэргийн үргэлжилсэн хугацааны харьцуулалт	52
Зураг 31.	Гэмт хэрэг үргэлжилсэн давтамж	52
Зураг 32.	Гэмт хэргийн талаарх анхны гомдол, мэдээллийг гаргасан зарим эх сурвалж	53
Зураг 33.	Хохирлоо төлүүлэх талаар Иргэний шүүхэд хандахгүй байгаа хохирогчийн шалтгаан нөхцөл	54
Зураг 34.	Хохирогчийн сэтгэл санааны болон бие эрхтний хохирлоо нотлох баримтаа бүрдүүлэн иргэний шүүхээр жич шийдвэрлүүлэх эрхийг нээлттэй үлдээж шийдвэрлэсэн байдал.	55
Зураг 35.	Хохирогчийн үр хөндүүлсэн байдал	56
Зураг 36.	2021 онд шийдвэрлэгдсэн хэргийн 46 хохирогчийн хүйсийн харьцаа	59
Зураг 37.	Зөрчлийн хууль дахь бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалсан зохицуулалт	67
Зураг 38.	Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ	69
Зураг 39.	Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ	69
Хүснэгт 1.	Ажлын даалгавар дахь судалгааны зорилго, зорилтууд	11
Хүснэгт 2.	Хүчиндэх гэмт хэрэг	14
Хүснэгт 3.	Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг	15
Хүснэгт 4.	Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг	16
Хүснэгт 5.	Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг	16
Хүснэгт 6.	Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг	17
Хүснэгт 7.	Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын харьцуулалт	18
Хүснэгт 8.	2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт	18
Хүснэгт 9.	2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт	19
Хүснэгт 10.	2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт	19
Хүснэгт 11.	2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт	19
Хүснэгт 12.	Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн ангилал	20

Хүснэгт 13.	Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн (100) бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүмүүсийн насны харьцаа	25
Хүснэгт 14.	Шүүхээр шийдвэрлэгдсэн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон насанд хүрээгүй хүмүүсийн тоон мэдээлэл	30
Хүснэгт 15.	Тусгай шинжилгээний газрын ДНХ-ийн лабораторид хийж буй шинжилгээний тоон харьцуулалт	35
Хүснэгт 16.	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчдын насны байдал	49
Хүснэгт 17.	Шүүхээс оногдуулсан ялын хугацааны харьцуулалт	50
Хүснэгт 18.	19...052 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	61
Хүснэгт 19.	Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хяналт шинжилгээ хийх болон үр дагаварт үнэлгээ хийх зорилго	66
Шигтгээ 1.	Цагдаагийн албан хаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс...	24
Шигтгээ 2.	Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	24
Шигтгээ 3.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	27
Шигтгээ 4.	21...569 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	29
Шигтгээ 5.	17...139 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	29
Шигтгээ 6.	20...109 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	30
Шигтгээ 7.	19...489 дугаартай эрүүгийн хэрэгийн шийтгэх тогтоолоос	30
Шигтгээ 8.	20...074 дугаартай эрүүгийн хэрэгийн шийтгэх тогтоолоос	31
Шигтгээ 9.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	32
Шигтгээ 10.	18...175 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос...	53
Шигтгээ 11.	Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	34
Шигтгээ 12.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	34
Шигтгээ 13.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	37
Шигтгээ 14.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	37
Шигтгээ 15.	Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	38
Шигтгээ 16.	Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...	38
Шигтгээ 17.	20...238 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	39
Шигтгээ 18.	21...524 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	39
Шигтгээ 19.	18...397 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	40
Шигтгээ 20.	18...139 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	40
Шигтгээ 21.	...471 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	51
Шигтгээ 22.	19...982 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	51
Шигтгээ 23.	19...914 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	53
Шигтгээ 24.	19...052 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	53
Шигтгээ 25.	19...189 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	57
Шигтгээ 26.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	57
Шигтгээ 27.	19...405 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	57
Шигтгээ 28.	20...231 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	58
Шигтгээ 29.	21...471 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	59

Шигтгээ 30.	19...489 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	60
Шигтгээ 31.	18...129 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	60
Шигтгээ 32.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	60
Шигтгээ 33.	17...139 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	60
Шигтгээ 34.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	61
Шигтгээ 35.	20...528 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	62
Шигтгээ 36.	18...343 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос	62
Шигтгээ 37.	Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс	63

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
ДНХ	Дезоксирибонуклеины хүчил
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ИХШХШтХ	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НЦҮТ	Нэг цэгийн үйлчилгээний төв
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ТАЛАРХАЛ

Хүйсийн тэгш эрх төв төрийн бус байгууллагын захиалгаар хийж гүйцэтгэсэн Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал дүн шинжилгээ хийх судалгааны тайлан нь энэ төрлийн гэмт хэрэгт хамаарах эрх зүйн зохицуулалт, түүнд алдаа, зөрчил, давхардал байгаа эсэхийг тодруулах, үндэсний болон олон улсын эрх зүйн баримт бичгийн нийцлийг тодорхойлох, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдал болон шүүхээр хянан шийдвэрлэж буй байдалд дүн шинжилгээ хийх замаар цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны талаар зөвлөмж хүргүүлэхэд чиглэгдсэн.

Судалгааны ажлыг гүйцэтгэхдээ төрийн эрх бүхий байгууллагын статистик мэдээллээс гадна хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талуудтай ганцаарчилсан ярилцлагыг зохион байгуулж, үр дүнг нэгтгэн авч үзлээ.

Судалгааны багийн зүгээс энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ), Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ), Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ), Шүүхийн шинжилгээний байгууллага, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) болон судалгаанд хамрагдсан мөрдөгч, прокурор, бусад байгууллагын оролцогч, үзэл бодол туршлагаа хуваалцсан нийт хүмүүст талархаж байна.

Ялангуяа судалгааны явцад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Хүйсийн тэгш эрх төв (ХТЭТ) ТББ-ын хамт олонд талархал илэрхийлье.

МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааны тайлангийн дүгнэлт, зөвлөмж нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд Австралийн Засгийн газар, ХТЭТ ТББ-ын болон судалгаанд хамрагдсан бусад оролцогч талуудын байр суурийг илэрхийлэхгүй болно.

СУДАЛГААНЫ БАГ

Г.Амаржаргал

Судалгааны багийн ахлах судлаач, Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн сургалтын арга зүйч

Д.Очмандах

Судалгааны багийн судлаач, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүгч

ЗӨВЛӨХ

Г.Ганбаясгах

ХТЭТ-ийн тэргүүн

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Хүүхэд

18 насанд хүрээгүй хүнийг¹;

Бага насны хүүхэд

Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт зааснаар "бага насны хүүхэд" гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг²;

Биеэ үнэлэх

төлбөртэйгөөр бусадтай бэлгийн харьцаанд орохыг³;

Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах

бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийх зорилгогүйгээр хохирогчийг тохуурхан доромжлох хэлбэрээр дур хүслээ хангасан үйлдлийг⁴;

Бэлгийн мөлжлөг

хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан үйлдлийг⁵;

Бэлгийн халдашгүй байдал

хүний хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдлээс ангид байх явдлыг⁶;

Бэлгийн харьцаа

бэлгийн дур хүслээ хангах зорилгоор хийж буй бэлгийн харьцааны шинжтэй үйлдлийг⁷;

¹ Хүүхдийн эрхийн конвенц, 1990, 1-р зүйл, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1276>

² Эрүүгийн хууль, 10.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №21

³ Зөрчлийн тухай хууль, 6.18 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №41

⁴ Эрүүгийн хууль, 12.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №21

⁵ Эрүүгийн хууль, 12.3 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №21

⁶ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

⁷ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

Бэлгийн харьцаанд орох

Хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бэлэг эрхтнээ оруулсныг⁸;

Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн

Хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн эсхүл өөр зүйл оруулсныг⁹;

Бэлгийн эрх чөлөө

бэлгийн хамтрагчаа чөлөөтэй сонгох боломжийг¹⁰;

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн

гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийг¹¹;

ДНХ-Дезоксирибонуклеины хүчил

ДНХ-ийн шинжилгээ нь хүн бүрийн өвөрмөц генетикийн кодыг шинжлэх процесс юм.

Хүчиндэх

бэлгийн дур хүслээ хангах зорилгоор хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулах аргаар бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийх¹²-ийг тус тус ойлгоно.

⁸ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

⁹ Эрүүгийн хууль, 12.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №21

¹⁰ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 59 дэх тал

¹¹ Эрүүгийн хууль, 10.4 дүгээр зүйлийн тайлбар хэсэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №21

¹² Эрүүгийн хууль, 12.1 дүгээр зүйл, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №21

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

1. Монгол Улсын Засгийн газар хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах, түүний эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар НҮБ-ын чиглэлийн хороодод тайлагнаж, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаж байна.
2. Монгол Улсад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах, хохирогчид үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна. Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-иар анх удаа эрэгтэй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалж, хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь хүйсийн хувьд аль ч хүйсийн хүн байж болохоор зохицуулалттай болсон.
- 3 Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн бусдыг бэлгийн харьцаанд албадан оруулсан гэдэгт Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан арга хэрэглэж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бусадтай бэлгийн харьцаанд оруулах бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийлгэхийг ойлгоно. Харин 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор гэж заасан нь Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн заалттай өрсөлдүүлсэн хэм хэмжээ болсон байна.
4. УИХ-аас 2013 онд төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох зорилгоор Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлан гаргасан . Гэвч төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин байхгүй 10 орчим жил болсны эцэст 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдсанаар энэ асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн.
5. Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлд заасан 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн субъект нь 18 насанд хүрсэн хүн байхаар заажээ. Энэ гэмт хэргийг 18-аас доош насны хүн үйлдвэл хуулийн ямар хариуцлага хүлээлгэх асуудал орхигдсон байна.

6. Цагдаагийн байгууллагад 2018 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн дотор хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1.7 хувийг эзэлж байсан бол 2021 онд 2.1 хувь, 2022 оны эхний 10 сарын байдлаар 1.95 хувь болж өссөн дүнтэй байна.
7. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хамгийн түгээмэл тулгамдаж буй асуудал нь ДНХ-н шинжилгээ хийлгэх ажиллагаа байна.
8. Шүүхийн шинжилгээний байгууллагын Тусгай шинжилгээний газрын ДНХ-н лабораторийн үйл ажиллагааг мэргэжлийн 5 шинжээч хариуцан ажиллах бөгөөд 1 шинжээчид жилд 361 шинжилгээ ногдож байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн 1 шинжилгээнд хамаарах объектын тоо нь 3-4 байгаа нь маш өндөр ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна.
9. Гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хүн хохирох явдал түгээмэл ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь тоон судалгаа болон ганцаарчилсан ярилцлагуудаар тогтоогдож байна. Тодруулбал 2018 онд 9, 2019 онд 22, 2020 онд 29, 2021 онд 46 хүүхэд хохирсон эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна.
10. Судалгааны ажлын хүрээнд шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн дугаар бүхий 100 хэргийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн бөгөөд эдгээр хэрэгт 112 хүн хохирогчоор тогтоогдсоноос 106 нь буюу 94.6 хувь нь насанд хүрээгүй хүн байна. Харин Үндэсний статистикийн хорооны 2020, 2021 оны гэмт хэргийн статистикийн мэдээллээс харвал 2020 онд бүртгэгдсэн 505 гэмт хэрэгт 502 хүн өртөж хохирсноос 333 буюу 66.3 хувь насанд хүрээгүй хүн байсан бол 2021 онд бүртгэгдсэн 540 гэмт хэрэгт 554 хүн өртөж хохирсноос 362 буюу 65.3 хувь насанд хүрээгүй хүн өртөж хохирчээ.
11. Судалгааны хүрээнд авч судалсан нийт 100 хэрэгт хохирогчоор тогтоогдсон насанд хүрээгүй 106 хохирогчийн 67.9 хувь нь 0-14 хүртэл насны, 21.6 хувь нь 14-16 хүртэл насны, 10.3 хувь нь 16-18 хүртэл насны хүн байна. Үндэсний статистикийн хорооны гэмт хэргийн статистикийн 2020 оны мэдээллээр энэ төрлийн гэмт хэрэгт 0-7 хүртэл насны 19, 8-17 хүртэл насны 314 хүүхэд, 2021 оны мэдээллээр 0-7 насны 19, 8-17 насны 343 хүүхэд өртөж нь энэ төрлийн гэмт хэрэгт насанд хүрээгүй хүн өртөж хохирох байдал өсөх хандлагатай байгааг нотолж байна.

12. 2020 онд бүртгэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн 505 гэмт хэргийн 334 буюу 66.1 хувь нь гэр, орон сууцанд, 43 буюу 8.5 хувь нь гудамж талбайд үйлдэгджээ. Харин 2021 онд бүртгэгдсэн 540 гэмт хэргийн 386 буюу 71.5 хувь гэр, орон сууцанд, 41 буюу 7.6 хувь нь гудамж талбайд үйлдэгдэж байгаа нь анхаарал татаж байна.
13. Дийлэнх тохиолдолд хохирогч нь өөрийн амьдардаг гэртээ байх хугацаандаа энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг гэр бүлийн, ойр дотны, найз нөхдийн, хамаатан садны, танилын хүрээнд үйлдэгдэж байгааг харуулж байна. Энэ нь гэмт хэргийн илрүүлэлтэд ч сөргөөр нөлөөлөл үзүүлдэг байна.
14. Энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хамгийн богино хугацаа 1 сар 1 хоног, хамгийн урт хугацаа 19 сар 21 хоног байна.
15. Цагдаагийн байгууллагад 2019 онд бүртгэгдсэн 481 хэрэгт 769, 2020 онд бүртгэгдсэн 401 гэмт хэрэгт 930, 2021 онд бүртгэгдсэн 409 гэмт хэрэгт 990 шинжилгээ хийгдсэн байна. Өөрөөр хэлбэл бүртгэгдсэн нэг хүчиндэх гэмт хэрэгт 2 шинжилгээ хийгдэж байна.
16. Шүүхийн шинжилгээний байгууллага Тусгай шинжилгээний газрын ДНХ-н лабораторийн үйл ажиллагааг мэргэжлийн 5 шинжээч хариуцан ажиллах бөгөөд 1 шинжээчид жилд 361 шинжилгээ ногдож байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн 1 шинжилгээнд хамаарах объектын тоо нь 3-4 байгаа нь маш өндөр ачаалалтай ажиллаж байна.
17. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын тусламж үйлчилгээг ГБХЗХГ-ын хүүхдийн тусламжийн 108 төв болон ТББ-ууд үзүүлж байна. Хохирогчийг хамгаалах байранд хамгаалалтад байлгах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай эмнэлгийн үзлэгийг хийлгэх зэргээр “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв”, “Хөөрхөн зүрх” зэрэг төрийн бус байгууллагууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцжээ.
18. Хүүхдийн тусламжийн 108 утсанд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар ирсэн мэдээллийг авч хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл өсөх хандлагатай гэсэн өмнөх үр дүнгүүдийг баталгаажуулсан үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл 2020 онд 255 дуудлага ирж байсан бол 2021 онд 402 буюу 57.6 хувиар өссөн дуудлага мэдээлэл бүртгэгджээ.

19. Насанд хүрээгүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах байдал харилцан адилгүй байна. Насанд хүрээгүй хохирогчтой эрүүгийн хэргийн 40% орчим хувьд нь тухайн харьяаллын ГБХЗХГ-н мэргэжилтнүүд хууль ёсны төлөөлөгчөөр оролцсон байна

20. Судалгааны хүрээнд авч судалсан нийт 100 хэрэгт хамаарах 119 шүүгдэгчийн 89.0 хувь нь хүчиндэх гэмт хэрэгт, 1.68 хувь нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт, 9.2 хувь нь арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт шүүхээс ял шийтгүүлжээ.

21. Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр 2021 оны эцэст манай улс 3,409,939 хүн амтай байснаас 2,367,635 буюу 69.4 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 1,042,304 буюу 30.5 хувь нь орон нутагт амьдарч байна. Нийт хүн амын 70 орчим хувь нь амьдарч байгаатай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн гаралтын 50 гаруй хувь нь нийслэлд үйлдэгддэг гэж тооцож болохоор байна.

22. Эрүүгийн хуулиар эрэгтэй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах боломжийг бий болгосон. Судалсан 100 хэргийн 2021 онд хамаарах 40 хэрэгт 46 хүн хохирогчоор тогтоогдсоны 6 нь эрэгтэй хүн байна. Үндэсний статистикийн хорооны гэмт хэргийн 2020 оны мэдээлэлд энэ төрлийн гэмт хэрэгт 502 хүн хохирогчоор тогтоогдсоноос 398 буюу 79.3 хувь нь эмэгтэй, 104 буюу 21.6 хувь нь эрэгтэй, 2021 онд 554 хүн хохирогчоор тогтоогдсоноос 536 буюу 96.8 хувь нь эмэгтэй, 18 буюу 3.1 хувь нь эрэгтэй хүн байна.

23. 2020 оны судалгаа хийсэн 30 хэргийн шийдвэрийн 3 нь мессежээр, 2 нь фейсбүүкээр танилцсан хүнийхээ хохирогч болсон бол 2021 оны 40 шийдвэрийн 2 хохирогч нь фейсбүүкээр шүүгдэгчтэй танилцаж, харилцаж байгаад уулзан хохирчээ. Өөрөөр хэлбэл нийгмийн сүлжээ ашиглан бусдыг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болгож байгаа тул урьдчилан сэргийлэх ажлыг энэ чиглэлд хандуулах нь зөв байна.

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх зөвлөх багийн ажлын даалгаварт заасан дараах зорилго, зорилтыг хангахад чиглэгдсэн. Үүнд:

Хүснэгт 1. Ажлын даалгавар дахь судалгааны зорилго, зорилтууд

	Зорилго	Зорилт
Нэг	Эрүүгийн хууль /шинэчлэн найруулсан/-ийн 12 дугаар бүлэгт хамаарах хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн сүүлийн таван жилийн нөхцөл байдал, хуулийн давхцал, хийдэл, зөрчилдөөн бүхий байдлыг судлах	<ul style="list-style-type: none"> ✓ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалахтай холбоотой МУ-ын олон улсын гэрээ, конвенц болон Эрүүгийн хууль дахь эрх зүйн зохицуулалтын хийдэл, нийцлийг тодорхойлох ✓ Цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын 2018-2021 оны хооронд бүртгэгдсэн, хянагдсан, эцэслэн шийдвэрлэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ✓ Шүүх эрх мэдлийн байгууллагаас 2018-2021 онд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хохирогчдод учирсан хохирол, ялын хэмжээ, ялгамжид дүн шинжилгээ хийх ✓ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчид үзүүлж буй туслалцааны өнөөгийн байдал, тэдэнд шаардлагатай дэмжлэг туслалцааг тодорхойлох, зураглал гаргах;
Хоёр	Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, конвенц болон Эрүүгийн хуулийн уялдаа холбоо, нийцлийг судлах	<ul style="list-style-type: none"> ✓ Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалахтай холбоотой үндэсний хууль эрх зүйн орчин, МУ-ын олон улсын гэрээ, конвенц тэдгээрийн зохицуулалт ✓ НҮБ-ын Гэрээний хороодоос МУ-ын Засгийн газарт Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдсэн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирсон ял шийтгэл оногдуулахтай холбоотойгоор өгсөн зөвлөмж болон хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх;
Гурав	Судалгаан дээрээ үндэслэн хүний эрх, тухайлан хүүхдийн эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор шаардлагатай санал зөвлөмж боловсруулж, олон нийтэд нээлттэй танилцуулж, шийдвэр гаргах, бодлого боловсруулагчдад хүргүүлэх	


Дээрх зорилтуудын хүрээнд судалгааны тайланг дараах бүлгийн хүрээнд боловсрууллаа. Үүнд:

1. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нөхцөл байдал
2. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн талаарх эрх зүйн зохицуулалтын талаар авч үзэж, дүгнэлт, зөвлөмж боловсруулав .

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Судалгааны ажлын даалгаварт заасан зорилтуудад хүрэхийн тулд судалгааны баг тоон болон чанарын аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулан дүн шинжилгээ хийв.

Зураг 1. Судалгааны арга зүй



Тоон мэдээлэл: Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ), Цагдаагийн ерөнхий газрын (ЦЕГ) статистик, мэдээллийг нэгтгэн дүгнэх замаар хэргийн нөхцөл байдлыг судлах, хэргийн хөдөлгөөнийг зураглах, мөрдөн шалгах ажиллагаанд болон шүүхийн ажиллагаанд зарцуулж буй хугацааг тодорхойлоход ашигласан. ГБХЗХГ-аас Хүүхдийн тусламжийн 108 төвд 2018-2021 оны хооронд хандаж, үйлчилгээ авсан нийт хүүхдийн тоо, үүнээс хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийн тоон үзүүлэлтүүдийг гаргуулан авч ашиглав.

Дээрх байгууллагуудаас ХТЭТ ТББ-аас албан бичгээр хүсэлт илгээн шаардлагатай мэдээллүүдийг гаргуулан авлаа.

Чанарын судалгаа: Чанарын судалгааны хүрээнд хоёр төрлийн аргаар мэдээлэл цуглуулалтыг хийж гүйцэтгэсэн. Баримт бичгийн судалгааг сэдвийн судлах шаардлагатай олон улсын болон үндэсний эрх зүйн баримт бичиг, холбогдох ижил төстэй судалгаа зэрэг мэдээллүүдийг цуглуулж, нэгтгэн авч үзсэн. Түүнчлэн 2018-2021 оны хооронд шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг шийдвэрлэсэн 100 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийв.

Судалгааны ажлын үр дүнг бататгах зорилгоор, захиалагчийн хүсэлтээр энэ төрлийн гэмт хэргийн талаарх статистик мэдээллийг 2022 оны эхний 10 сар хүртэл нэмэлтээр авч ашигласан.

Түүнчлэн Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх, дүүргүүдийн шүүхийн шүүгч, ЦЕГ-ын Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтэс, Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Дорнод, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын энэ төрлийн гэмт хэрэг дагнан мөрддөг мөрдөгч, эрүүгийн мөрдөгч, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн прокурорын газрын хяналтын прокурор, Шүүхийн шинжилгээний байгууллагын мэргэжилтэн зэрэг албан тушаалтнуудтай тус бүр ганцаарчилсан ярилцлагыг явуулж, дүн шинжилгээ хийсэн.

Ганцаарчилсан ярилцлагын удирдамжийн төслийг захиалагч талд танилцуулан зөвшөөрөл авсны үндсэн дээр судалгаанд ашиглав.

Баримт бичгийн судалгаа: Баримт бичгийн судалгааны хүрээнд дараах үндсэн дөрвөн төрлийн ялгаатай бичиг баримтад шинжилгээ хийсэн.

- ✓ **Эрх зүйн баримт бичиг**-Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр олон улсын болон үндэсний хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, холбогдох журам зэрэг эрх зүйн баримт бичигтэй танилцсан.
- ✓ **Судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл**-Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн дотоодод хийгдсэн судалгааны тайлангуудтай танилцсан.
- ✓ **Эрүүгийн хэргийн материал**-2018-2021 онд шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн 100 хэргийн шийдвэрт дүн шинжилгээ хийв.

Мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл бэрхшээл, даван туулсан байдал, сургамж

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх судалгааны ажлын мэдээлэл цуглуулалтын явцад дараах бэрхшээл тулгарч байсан ч бид тухай бүрд даван туулах бүхий л арга замыг эрэлхийлж шийдвэрлэж ажилласан болно.

- ✓ **Төрийн байгууллагын мэдээллийн ил тод бус байдал:** Судалгааны ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор шүүх, цагдаа, хүүхдийн асуудал эрхэлсэн төрлийн захиргааны байгууллагаас тус тус тоон мэдээлэл цуглуулсан. Шүүх, цагдаагийн байгууллагаас цуглуулсан хэргийн хөдөлгөөний судалгаатай холбоотой мэдээлэл хуулийн хугацаандаа тодорхой гарч, судалгаанд бүрэн ашиглагдсан. Харин Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ)-аас 4 төрлийн тоон мэдээлэл авахаар хандсан боловч хугацаа алдсан, хариуцсан мэргэжилтэн, удирдлагуудын ээлжийн амралт таарсан зэрэг шалтгаанаар хэт задгай 2 төрлийн тоон мэдээллийг авсан. ГБХЗХГ-аас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль ёсны төлөөлөгчөөр ажилласан хүн хүчний тооцоо болон бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлсэн үйлчилгээ, түүний төрөл, тоон үзүүлэлт зэрэг мэдээлэл ирүүлээгүй нь судалгааны чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл байдал болсныг энд зориуд тэмдэглэв.
- ✓ **Цаг үеийн нөхцөл байдлын нөлөө:** Тус судалгааны ажлын мэдээлэл цуглуулалт нь 2022 оны 06 дугаар сарын сүүлч, 07 дугаар сарын эхэн үед зохион байгуулагдсан. Энэ нь төрийн албан хаагчдын ээлжийн амралтын үетэй давхацсан тул олон жил ажилласан, дадлага туршлагатай оролцогчийг сонгон ярилцлага хийх боломжийг хязгаарласан. Түүнчлэн прокурорын байгууллагаас ярилцлагад нэр зааж прокурор оролцуулах боломжгүй талаар мэдэгдэж байв.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлгийн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийх, энэ төрлийн гэмт хэрэгт өртөж, хохирсон хохирогчид үзүүлж буй үйлчилгээ, түүний хүртээмжийн талаар энэ бүлэгт авч үзлээ.

Энэ бүлгийн эхэнд 12 дугаар бүлэгт заасан бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн эрүүгийн хууль дахь зохицуулалтын талаар авч үзэв.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт:

- 12.1 дүгээр зүйл Хүчиндэх
- 12.2 дугаар зүйл Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах
- 12.3 дугаар зүйл Бэлгийн мөлжлөг
- 12.5 дугаар зүйл Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох
- 12.6 дугаар зүйл Биеэ үнэлэхийг зохион байгуулах

Дээрх гэмт хэрэг тус бүрийн үйлдлийн арга, үйлдэл, зорилго, хамаарах тайлбарын талаар дор авч үзлээ.

Хүснэгт 2. Хүчиндэх гэмт хэрэг

12.1 дүгээр зүйл. Хүчиндэх		
Үндсэн шинж	Хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтуурсан, мансуурсан, сэтгэцийн үйл ажиллагаа нь түр сарнисан, бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүнийг хүчиндэж; - бүлэглэж; - гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж; - хохирогчийг жирэмсэн болгож; - хохирогчид бэлгийн замын халдварт өвчин халдааж; - хоёр, түүнээс олон хүнийг хүчиндэж; - урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; - харгис хэрцгий аргаар; - бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовиур үүсгэж; - хохирогчийг тохуурхан доромжилж үйлдсэн 	таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - ураг зулбасан, - арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон; - гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн 	найман жилээс арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн; - энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан 	арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ

Тайлбар: Өмнөх хууль (2002 онд батлагдсан)-иас нэг онцлог зохицуулалт нь энэ гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болохоор зохицуулагдсан байна. Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 12.1.2, 12.1.3, 12.1.4 дэх хэсэгт энэ гэмт хэргийн хүндрүүлэх шинжүүдийг заасан байна.

Түүнчлэн бага насны хүүхэд буюу 14-өөс доош насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.

Хууль тогтоогчоос “Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” гэдэгт хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно” гэж тайлбарласан байна.

Хүчиндэх гэмт хэрэг нь бэлгийн харьцаанд орж эхэлсэн, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийж эхэлснээр төгсөнө. Тухайн гэмт үйлдлийн үргэлжилсэн хугацаа, гэмт этгээд болон хохирогч дур ханасан эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

Энэ гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн тохиолдолд гэмт этгээд бүр хохирогчтой бэлгийн харьцаанд орсон эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн байхыг шаардана. Харин бусад этгээд хохирогчтой бэлгийн харьцаанд ороогүй, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийгээгүй боловч хүн харж өгөх, хохирогчийн эсэргүүцлийг таслан зогсоох зэргээр дэмжлэг үзүүлсэн бол гэмт хэрэг үйлдэхэд хамжигч¹³ аар оролцсонд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ¹⁴.

¹³ Эрүүгийн хууль, 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Урьдчилан амлаж бусдыг санаатай гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн хүнийг гэмт хэргийн хамжигч гэнэ.

¹⁴ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 52 дахь тал

Хүснэгт 3. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг

12.2 дугаар зүйл. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах		
Үндсэн шинж	Хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан нь хүчиндэх гэмт хэргийн шинжгүй бол	зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн	хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
<p>Тайлбар: Энэ гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болно. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэдэгт бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийх зорилгогүйгээр хохирогчийг тохуурхан доромжлох хэлбэрээр дур хүслээ хангасан үйлдлийг хэлнэ. Өөрөөр хэлбэл хохирогчийн өмнө бэлэг эрхтнээ оролдох, гар хангалга хийх зэрэг байдлаар илэрч болно. Харин хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн эсхүл өөр зүйл оруулсан бол хүчиндэх гэмт хэрэг үйлдсэнд тооцно. Мөн хохирогчийн хувцсыг тайлж нүцгэлсэн, дарж авсан, нөхөн үржихүйн эрхтэнд хүрсэн бол хүчиндэх гэмт хэрэг үйлдэхээр завдсан¹⁵ гэж үзнэ.</p>		

¹⁵ Эрүүгийн хууль, 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. Гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг санаатай хийсэн боловч тухайн хүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг төгсөөгүй бол гэмт хэрэг үйлдэхээр завдах гэнэ.

Хүснэгт 4. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг

12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг		
Үндсэн шинж	Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг албадан оруулж; - урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; - хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж; - хохирогчийг жирэмсэн болгож; - хоёр, түүнээс олон хүний эсрэг; - байнга тогтвортой үйлдсэн 	хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - ураг зулбасан; - арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон 	таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - бага насны хүүхдийг албадан оруулж; - зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн 	арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ
<p>Бэлгийн харьцаанд албадан оруулсан гэдэгт Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан арга хэрэглэж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бусадтай бэлгийн харьцаанд оруулах бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийлгэхийг ойлгоно¹⁶.</p> <p>Хэдийгээр Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн үндсэн бүрэлдэхүүнд Хүн худалдаалах гэмт хэргээс ялгах шинжийг “зорчих эрхийг хязгаарлахгүйгээр” гэж томъёолсон боловч 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор гэж заасан нь өрсөлдүүлсэн хэм хэмжээ болж, мөрдөгч, прокурор, шүүхээс мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд төвөгтэй байдал бий болгож байна.</p> <p>Мөн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт “Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход ямар аргаар үйлдсэн байхыг шаардахгүй” гэсэн боловч хүүхдийн эсрэг үйлдэж байгаа бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг гэж байхаар зохицуулсан байгааг анхаарах хэрэгтэй¹⁷.</p>		

¹⁶ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 54 дэх тал

¹⁷ Азийн сангийн захиалгаар Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-аас хийсэн Хүн худалдаалах түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан

Хүснэгт 5. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй
бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг

12.5 дугаар зүйл. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох		
Үндсэн шинж	Арван найман насанд хүрсэн хүн хохирогчийг арван дөрвөн насанд хүрсэн арван зургаан насанд хүрээгүй болохыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсээр байж бэлгийн харьцаанд орсон	дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - хохирогчийг жирэмсэн болгосон; - бэлгийн замын халдварт өвчин халдаасан 	зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
<p>Гэмт этгээд 14 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орсон бол ЭХТА-ийн 12.1 дүгээр зүйлд заасан хүчиндэх гэмт хэрэг үйлдсэнд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Энэ тохиолдолд гэмт этгээд хохирогчийн 14 насанд хүрээгүй болохыг мэдсэн байх, мэдэх боломжтой байсан эсэх нь зүйлчлэлд нөлөөлөхгүй. Энэ гэмт хэрэг нь хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн объект, үйлдлийн арга, гэмт хэрэг үйлдсэн хүний насаар ялгагдана. Бэлгийн харьцаанд орсон гэдэгт хохирогчийн бэлэг эрхтэнд бэлэг эрхтнээ оруулсныг ойлгох бөгөөд хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйлс оруулсныг бэлгийн харьцаанд орсон гэж үзэхгүй¹⁸.</p>		

¹⁸ Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020, 57 дахь тал

Хүснэгт 6. Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг

12.6 дугаар зүйл. Биеэ үнэлэхийг зохион байгуулах		
Үндсэн шинж	Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан	зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
Хүндрүүлэх шинж	<ul style="list-style-type: none"> - Биеэ үнэлэх газар байгуулсан, - санхүүжүүлсэн, - биеэ үнэлэхийг зохион байгуулсан, - биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан 	нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
	<ul style="list-style-type: none"> - Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн 	таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ
<p>2017 оноос үйлчилж эхэлсэн Эрүүгийн хуулиас энэ гэмт хэргийг хасаж, Зөрчлийн тухай хуульд заан оруулж өгсөн ч 2020.01.10-ны өдөр Эрүүгийн хуульд нэмэлт оруулах замаар буцаан гэмт хэрэгт тооцсон. Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан гэдэгт түүнтэй бэлгийн харьцаанд төлбөртэй орох хүнийг олж өгсөн, холбоо тогтоолгосон байхыг ойлгоно. Бусдыг биеэ үнэлэхэд татан оролцуулсан гэдэгт хохирогчийг бусад бэлгийн харьцаанд төлбөртэй оруулсныг ойлгоно. Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шинжид үйлдлийн аргыг зааж өгөөгүй нь бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс ялгагдана.</p> <p>Өөрөөр хэлбэл биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тухайд хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулах шинжгүй бөгөөд хохирогчийн өөрийнх нь зөвшөөрснөөр биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан байдаг. Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үйлдэхдээ 18 насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол ЭХТА-ийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргээр зүйлчилнэ.</p>		

Эдгээр гэмт хэрэгт оногдуулах ял, эрүүгийн хариуцлагын арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинжээс хамаарч харилцан адилгүй байхаар зохицуулагдсан байна.

Хүснэгт 7. Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт оногдуулах ялын харьцуулалт

12.1. Хүчиндэх	12.2. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	12.3. Бэлгийн мөлжлөг	12.5. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	12.6. Биеэ үнэлэхийг зохион байгуулах
1-5 жил хүртэл хугацаагаар хорих	6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих	6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих
5-12 жил хүртэл хугацаагаар хорих	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих	1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих
8-15 жил хүртэл хугацаагаар хорих	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	5-12 жил хүртэл хугацаагаар хорих		5-12 жил хүртэл хугацаагаар хорих
12-20 жил хүртэл эсхүл бүх насаар нь хорих		12-20 жил хүртэл эсхүл бүх насаар нь хорих		

Өмнөх Эрүүгийн хуульд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулж байсан ялын төрөл хэмжээг харьцуулан авч үзвэл:

Хүснэгт 8. 2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд хүчиндэх гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт

Хэсэг	12.1. Хүчиндэх	125. Хүчиндэх
1	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	таван жил хүртэл хугацаагаар хорих
2	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих
3	8-15 жил хүртэл хугацаагаар хорих	арван таваас дээш хорин таван жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл цаазаар авах ял
4	12-20 жил хүртэл эсхүл бүх насаар нь хорих	
<p>Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд заасан хүчиндэх гэмт хэрэгт оногдуулах ялын хэмжээ нь багасаагүй бөгөөд нэмэгдээгүй байна. Харин өмнөх хуульд заасан цаазаар авах ялыг бүх насаар нь хорих ял болгон өөрчилсөн нь манай улс 2012 онд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халах тухай протоколд нэгдэн орсонтой холбоотой үндэсний хууль тогтоомжийг нийцүүлсэн явдал болжээ.</p>		

Хүснэгт 9. 2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт

Хэсэг	12.2. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	125. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах
1	6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих	хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих
2	1-5 жил хүртэл хугацаагаар хорих	таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих
3	2-8 жил хүртэл хугацаагаар хорих	
<p>Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд заасан бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт оногдуулах ялын доод хэмжээ 6 сар болж, дээд хэмжээ нь 8 жил болж багассан байна. Гэхдээ 2002 оны Эрүүгийн хуульд бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт тооцож байсан үйлдлийг одоогийн хуулиар хүчиндэх гэмт хэрэг гэж үздэг болсон.</p>		

**ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ
ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Хүснэгт 10. 2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт

Хэсэг	12.5. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	122. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурьцал үйлдэх
1	450-5400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих	хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хоёр зуун тавин нэгээс гурван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих
2	6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих	
<p>Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд заасан арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт оногдуулах торгох ялын хэмжээ багассан байна. Харин хүндрүүлэх нөхцөл байдлыг шинээр нэмж тусгаж, түүнд оногдуулах ялыг 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял байхаар зохицуулсан нь өмнөх хуулийн 122 дугаар зүйлийн үндсэн бүрэлдэхүүний ялын хэмжээтэй ижил байгаа нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл хүндрүүлж үзэх нөхцөл байдал гэж тодорхойлсон бол түүнд оногдуулах ял нь тухайн үйлдэлд тохирсон байх ёстой билээ.</p>		

Хүснэгт 11. 2002 оны Эрүүгийн хууль болон 2015 оны Эрүүгийн хуульд биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын харьцуулалт

Хэсэг	12.6. Биеэ үнэлэхийг зохион байгуулах	124. Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах
1	6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих	хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах

2	1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5жил хүртэл хугацаагаар хорих	хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурван зуугаас дөрвөн зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих
3	5-12 жил хүртэл хугацаагаар хорих	таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих
Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд заасан биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт ялын төрөл өөрчлөгдөж хорих болон зорчих эрх хязгаарлах ял оногдуулдаг болсон. Түүнчлэн хорих ялын дээд хэмжээ 12 жил болж нэмэгдсэн байна.		

Мөн хуулийн 2.6 дугаар зүйлд “Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг хоёр жил, түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар тогтоосон гэмт хэргийг хүнд гэмт хэрэг”, “Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг таван жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” гэж ангилж өгсөн байдаг. Үүнээс харвал:

Хүснэгт 12. Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийн ангилал

12.1. Хүчиндэх	12.1.1	Хөнгөн
	12.1.2	Хүнд
	12.1.3	Хүнд
	12.1.4	Хүнд
12.2. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	12.2.1	Хөнгөн
	12.2.2	Хөнгөн
	12.2.3	Хүнд
12.3. Бэлгийн мөлжлөг	12.3.1	Хөнгөн
	12.3.2	Хүнд
	12.3.3	Хүнд
	12.3.4	Хүнд

12.5. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	12.5.1	Хөнгөн
	12.5.2	Хөнгөн
12.6. Биеэ үнэлэхийг зохион байгуулах	12.6.1	Хөнгөн
	12.6.2	Хөнгөн
	12.6.3	Хүнд

ЭХТА-д заасан дээрх зүйл, хэсэгт оногдуулах ялыг авч үзвэл оногдуулах ялын хэмжээг тавьж өгөхдөө давхардуулсан байдлаар оруулсан нь хууль хэрэглээний хувьд тодорхой эргэлзээг бий болгохоор байна. Өөрөөр хэлбэл, ЭХТА-ийн 12.1 дүгээр зүйлийн 12.1.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт 5-12 жилийн ял оногдуулахаар, 12.1.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт 8-15 жилийн хорих ял оногдуулахаар заасан байна. Энэ нь шүүхээс 12.1.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт 12 жилийн, 12.1.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт түүнээс бага буюу 8 жилийн хугацаагаа хорих ял оногдуулах боломжийг нээлттэй орхисон байна

Хуулийн дээрх зохицуулалтаас харвал дараах нөхцөл байдлуудыг тодорхойлж болох юм.


1. Монгол Улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн конвенцод 18 насанд хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ гээд аливаа хэлбэрээр ялгаварлагдахгүй байх нөхцөлийг тодорхойлсон. Гэвч ЭХТА-ийн 12 дугаар бүлэгт хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан гэмт хэрэгт ял оногдуулахдаа 14 хүртэл насны хүүхэд, 16 хүртэл насны хүүхэд, 18 насанд хүрээгүй хүн зэрэг нэг томъёог ашиглаж, насны ангиллаар эрүүгийн хариуцлага өөр байхаар зохицуулсан.
2. 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн субъект нь 18 насанд хүрсэн хүн байхаар заажээ. Энэ гэмт хэргийг 18-аас доош насны хүн үйлдвэл хуулийн ямар хариуцлага хүлээлгэх асуудал орхигдсон,
3. ЭХТА-ийн 12.3 дугаар зүйлд заасан бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн бусдыг бэлгийн харьцаанд албадан оруулсан гэдэгт Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд заасан арга хэрэглэж, хохирогчийн хүсэл зоригийн эсрэг бусадтай бэлгийн харьцаанд оруулах бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийлгэхийг ойлгоно. Харин 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор гэж заасан нь ЭХТА-ийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн заалттай өрсөлдүүлсэн хэм хэмжээ болсон байна.

1.1. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт, шийдвэрлэлтийн нөхцөл байдал, хохирогчид үзүүлж буй туслалцаа дэмжлэг

Үр дүн 1. 2018 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн дотор хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1.7 хувийг эзэлж байсан бол 2021 онд 2.1 хувь болж өссөн дүнтэй ажиглагдаж байна.

Цагдаагийн байгууллагын хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн статистикийн мэдээллээс цар тахлын нөхцөл байдлын улмаас бүх нийтийн болон хэсэгчилсэн хөл хориотой байх үе буюу 2020, 2021 оны гэмт хэргийн гаралт буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 2. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн нийт гэмт хэрэгт эзлэх үзүүлэлт



2022 оны эхний 10 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 31320 гэмт хэрэг, үүнээс хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 611 бүртгэгдсэн нь цар тахлын өмнөх цаг үеийн нөхцөл байдалтай ижил хэмжээнд байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл гэмт хэргийн нөхцөл байдал 2020, 2021 онд буурсан үзүүлэлттэй харагдаж байгаа боловч энэ нь цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор улс орон даяар тогтоосон хязгаарлалтын арга хэмжээтэй шууд хамааралтай гэж үзэх үндэслэлтэй байна.

Цагдаагийн байгууллагад 2018 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн дотор хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1.7 хувийг эзэлж байсан бол 2021 онд 2.1 хувь, 2022 оны эхний 10 сарын байдлаар 1.95 хувь болж өссөн дүнтэй ажиглагдаж байна.


Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт Улаанбаатар хот болон орон нутагт үйлдэгдсэн байдлыг харьцуулан үзвэл 2018 онд 50.7 хувь, 2019 онд 40.8 хувь, 2020 онд 50.4 хувь, 2021 онд 49.8 хувь, 2022 оны эхний 10 сарын байдлаар 50.1 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан мэдээллээр 2021 оны эцэст манай улс 3,409,939 хүн амтай байснаас 2,367,635 буюу 69.4 хувь нь нийслэл

Улаанбаатар хотод, 1,042,304 буюу 30.5 хувь нь орон нутагт амьдарч байна. Нийт хүн амын 70 орчим хувь нь амьдарч байгаатай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн гаралтын 50 гаруй хувь нь нийслэлд үйлдэгддэг гэж тооцож болохоор байна.


Харин хүн амын 30 орчим хувь нь орон нутагт амьдарч байхад нийт гэмт хэргийн 50 орчим хувь нь үйлдэгдэж байна гэж үзвэл гэмт хэргийн илрүүлэлт орон нутагт сайн байна гэж дүгнэх нэг нөхцөл болох боломжтой юм. Эсрэгээрээ нийслэл дэх энэ төрлийн гэмт хэргийн илрүүлэлт харьцангуй бага байж болзошгүйг үгүйсгэх аргагүй байна.

Зураг 3. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн байршлын харьцуулалт



Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн дотор хамгийн өндөр хувийг эзэлдэг хүчиндэх гэмт хэргийн тухайд 2018 онд 51.8 хувь, 2019 онд 44.4 хувь, 2020 онд 50.6 хувь, 2021 онд 51.2 хувь, 2022 оны эхний 10 сарын байдлаар 51.3 хувь нь нийслэлд бүртгэгдсэн байна.


Зураг 4. 2018-2021 онд бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн тоон мэдээлэл



Улсын хэмжээнд 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэгт хүчиндэх гэмт хэргийн эзлэх хувь 1.7 хувь, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг дотор эзлэх хувь 81.2 хувьтай байна.. Харин 2022 оны эхний 10 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн тоон дүнг 2020 онд бүртгэгдсэн гэмт хэрэгтэй харьцуулбал 103 хэрэг буюу 25.6 хувиар, 2021 онд бүртгэгдсэн гэмт хэрэгтэй харьцуулбал 65 гэмт хэрэг буюу 14.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Энэ нь гэмт хэргийн гаралт 2020, 2021 онд буурсан нь цар тахлын нөхцөл байдлын улмаас тогтоосон хөл хорио, хязгаарлалтын дэглэмтэй холбоотой үндэслэлийг бататгаж байна гэж судалгааны баг үзэж байна.

Зураг 5. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн тоон мэдээлэл



Улсын хэмжээнд 2022 оны эхний 10 сарын байдлаар үйлдэгдсэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн тоон үзүүлэлтийг 2021 оны эхний 10 сартай харьцуулбал 3 гэмт хэрэг буюу 25 хувиар өссөн үзүүлэлтэй байна¹⁹.

Зураг 6. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тоон мэдээлэл




Улсын хэмжээнд 2021 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 2018 онтой харьцуулбал 5.6, 2020 онд бүртгэгдсэн гэмт хэргээс 3 дахин тус тус буурсан байна. Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн талаарх Эрүүгийн хуульд заасан зарим зохицуулалтууд нь мөн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэрэгтэй ижил агуулгатай байдаг нь хууль хэрэгжүүлэгчдээс зарим гэмт хэргийг бэлгийн мөлжлөгийн бус хүн худалдаалах гэмт хэрэгт тооцож зүйлчилж байгаатай холбоотойгоор гэмт хэргийн тоон статистик буурах үзүүлэлттэй байж болох юм²⁰. Түүнчлэн цар тахлын нөхцөл байдал нь нийт гэмт хэргийн үзүүлэлт 2020, 2021 онд буурах үзүүлэлттэй гарахад нөлөөлж байгаа нь дээр дурдсан статистикуудаар нотлогдож байна.

¹⁹ 2022 оны эхний 6 сарын дүнг харьцуулах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл Цагдаагийн байгууллагын 2022 оны эхний 6 сарын дүн мэдээгээр ЭХТА-н 12.2, 12.3, 12.5, 12.-д заасан гэмт хэргийн тоон үзүүлэлт цахим хэлбэрээр байршаагүй байна.


²⁰ Учир нь цагдаагийн байгууллагын статистикаас харвал хүн худалдаалах гэмт хэрэг 2018 онд 26, 2019 онд 18, 2020 онд 15, 2021 онд 8 бүртгэгдсэн байна.

Зураг 7. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн тоон мэдээлэл



2021 онд бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 2018 онтой харьцуулбал 9.6 хувиар буурсан үзүүлэлттэй ч 2020 онд бүртгэгдсэн гэмт хэргээс 8.6 хувиар өсчээ.

Зураг 8. Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тоон үзүүлэлт



Улсын хэмжээнд биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн гаралт 2020 онд 20 байсан бол 2021 онд 9 болж 2.2 дахин буурсан байна.

Дээрх тоон судалгаанаас харвал дэлхий нийтийг хамарсан цар тахлын нөхцөл байдлын үед тогтоосон хөдөлгөөний хязгаарлалт, бүх нийтийн болон хэсэгчилсэн хөл хорионы дэглэм нь 2019, 2020, 2021 онд энэ төрлийн гэмт хэргийн гаралт буурсан дүнтэй гарах нэг нөхцөл нь болжээ. Тодруулбал дээр дурдсанчлан 2021 онд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 540 бүртгэгдэж байсан бол 2022 оны эхний 10 сарын байдлаар 611 болж 71 гэмт хэрэг буюу 13.1 хувиар өссөн дүнтэй байна.

Түүнчлэн гэр бүлийн харилцаатай хүний зүгээс болон гэр бүлийн хүрээнд үйлдэгдсэн энэ төрлийн гэмт хэрэг мэдээллэгдээгүй байх боломжтойг судалгааны баг үгүйсгэхгүй байна.

Гэмт хэргийн улмаас насанд хүрээгүй хүн хохирох явдал түгээмэл ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь тоон судалгаа болон ганцаарчилсан ярилцлагуудаар тогтоогдож байна.

Шигтгээ 1. Цагдаагийн албан хаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс...

Манай аймгийн хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн гаралт харьцангуй бага. Би жилдээ 10 орчим бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг шалгаж байгаа. Эдгээр хэргүүдийн 80 орчим хувь нь насанд хүрээгүй хүүхдүүд хохирсон хэрэг байна. Ер нь сүүлийн жилүүдэд насанд хүрсэн хүн хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон талаарх гомдол мэдээлэл бага ирэх болсон. Харин хүүхдүүд энэ хэрэгт өртөж хохирсон гомдол, мэдээлэл нэмэгдэх төлөвтэй байгаа.

Шигтгээ 2. Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Манай аймгийн тухайд бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт бага насны хүүхэд өртөж хохирох явдал их байгаа. Энэ төрлийн гэмт хэргийн нийт 75-85 хувь нь бага насны хүүхэд хохирсон хэрэг байгаа нь сэтгэл эмзэглүүлэм байгаа. Нөгөө талаар насанд хүрсэн хүн хохирогч болохгүй байна уу гэвэл үгүй. Ялангуяа орон нутаг учраас санаа зовох, ичих гэдэг мэдрэмжээсээ болоод тэд цагдаагийн байгууллагад гомдол гаргахгүйгээр гэмт хэрэг үйлдсэн хүнтэйгээ тохироод өнгөрөх хандлага давамгайл байна гэж харж байгаа.

НҮБ-ын Хүүхдийн сангаас бусад донор байгууллагуудтай хамтран дэлхийн 96 улсад хийсэн хүүхдийн эсрэг хүчирхийллийн хамрах хүрээг судалсан судалгааны тайланд дурдсанаар²¹ “Дэлхийн 1 тэрбум буюу 2-17 насны бүх хүүхдийн талаас илүү хувь нь өнгөрсөн жилд ямар нэгэн байдлаар сэтгэл зүй, бие махбод, бэлгийн хүчирхийлэлд өртсөн гэсэн тооцоолол байна. Хэдийгээр их гардаг ч хүүхдийн эсрэг хүчирхийлэл нь ихэвчлэн нуугдмал, хүний нүднээс далд, мэдэгдэхгүй болж өнгөрдөг. Нуугдмал байдаг гэдэг нь олон тоо баримтаас ил харагддаг бөгөөд тухайлбал, хүүхдийн өөрөө мэдээлсэн бэлгийн хүчирхийлэл нь албан ёсны мэдэгдсэн хүчирхийллийн тооноос 30 дахин, бие махбодын хүчирхийлэл нь 75 дахин их байдаг гэсэн судалгаа байдаг ажээ. Тэр дундаа охид бэлгийн хүчирхийлэлд өртөх магадлал өндөртэй байдаг. Тухайлбал хүүхэд насандаа охидын 18 хувь нь, хөвгүүдийн 8 хувь нь бэлгийн хүчирхийлэлд өртдөг гэсэн судалгаа байна.

Охидын эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт этгээд нь зонхилон эрэгтэй хүмүүс байдаг. Охид нь өөрийн дотны хамтрагчийн хүчирхийлэлд өртөх (бэлгийн болон бие махбодын), өөрийн таньдаг хүн эсвэл танихгүй хүнд хүчиндүүлэх, эрт, хүчээр гэрлэх, хүүхдийн хөдөлмөр, бэлгийн мөлжлөгийн зорилготой хүний наймаанд өртөх, эм бэлэг эрхтэнг зэрэмдэглэх, зүсэх зан үйлд өртөх нь илүү байдаг. Эдгээр хүчирхийлэл нь охидын аюулгүй өсөн хөгжих ёстой орчин болох гэр орон, сургуулиас ирэх буцах зам, сургууль дээр, өөрийнх нь амьдарч буй орон нутагт зэрэг олон орчинд гарахаас гадна гамшгийн үед, дүрвэн суурьшилт болон мөргөлдөөний дараах нөхцөл байдлуудад тохиолддог байна. Хөвүүдийн

²¹ https://www.unicef.org/mongolia/media/3051/file/INSPIRE-SevenStrategies_MN.pdf

хувьд галт зэвсэг болон хутгатай холбоотой санаатай аллагын хэргийн хохирогч эсвэл гэмт этгээд болох магадлалтай байдаг” гэжээ.

Тоон судалгаа болон болон ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс харахад бэлгийн эрх чөлөөний эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг нь өсөх магадлалтай ба насанд хүрээгүй хүн өртөх эрсдэл өндөр байгаа нь харагдаж байна. Зарим тохиолдолд энэ төрлийн гэмт хэрэг мэдээлэгдэхгүй, далд үйлдэгдэж байж болзошгүй байгааг судалгааны баг үгүйсгэхгүй байна

Үр дүн 2. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хүүхэд хохирох явдал буурахгүй байна. Тодруулбал 2018 онд 9, 2019 онд 22, 2020 онд 29, 2021 онд 46 хүүхэд хохирсон эрүүгийн хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байна.

Судалгааны ажлын хүрээнд шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн дугаар бүхий 100 хэргийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн бөгөөд эдгээр хэрэгт 112 хүн хохирогчоор тогтоогдсоноос 106 нь буюу 94.6 хувь нь насанд хүрээгүй хүн байна.

Хүснэгт 13. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн (100) бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүмүүсийн насны харьцаа


Хохирогчийн нас	2018	2019	2020	2021
0-14 хүртэл	8	10	18	36
14-16 хүртэл		12	5	6
16-18 хүртэл	1		6	4
18-аас дээш	2	1	2	1
Нийт	НХ-сэн – 2 НХ-гүй - 9	НХ-сэн – 1 НХ-гүй - 22	НХ-сэн – 2 НХ-гүй - 29	НХ-сэн – 1 НХ-гүй - 46

Дээрх тоон судалгаанаас харвал хүүхдийн эсрэг үйлдэж буй бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг жил бүр өсөх хандлагатай байгаа нь харагдаж байна.


Үндэсний статистикийн хорооны 2020, 2021 оны гэмт хэргийн статистикийн мэдээллээс харвал 2020 онд бүртгэгдсэн 505 гэмт хэрэгт 502 хүн өртөж хохирсноос 333 буюу 66.3 хувь насанд хүрээгүй хүн байсан бол 2021 онд бүртгэгдсэн 540 гэмт хэрэгт 554 хүн өртөж хохирсноос 362 буюу 65.3 хувь насанд хүрээгүй хүн өртөж хохирчээ²².

²² https://www2.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L23&type=sectorbook

Зураг 8. Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн (100) бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон хүмүүсийн насны харьцуулалт




Зураг 9. 14 хүртэлх настай хохирогчдын насны бүлгийн судалгаа




Судалгааны туршид 14 хүртэлх насны хүүхэд хэмээн онцлон авч үзэж байгаа нь Эрүүгийн хуулийн зохицуулалттай холбоотой. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 10.1 дүгээр зүйлийн тайлбарт **“Энэ хуульд заасан “бага насны хүүхэд” гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно”** гэжээ. Тодруулбал бага насны хүүхдийн эсрэг энэ төрлийн гэмт хэргийг үйлдвэл оногдуулах ял, эрүүгийн хариуцлага өндөр байгааг бид өмнөх хэсэгт авч үзсэн билээ.

Зураг 10. 14-16 хүртэлх насны хохирогч нийт 23 хүүхдийн насны мэдээлэл



Зураг 11. 16-18 хүртэлх насны хохирогч нийт 11 хүүхдийн насны мэдээлэл



Шигтгээ 3. Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Энэ төрлийн гэмт хэргийн тоон мэдээллийн тухайд сүүлийн жилүүдэд харьцангуй их өсөж байгаа. Ялангуяа гэр хороололд амьдралын түвшин доогуур, эсхүл гэр бүлийн орчин архидалт ихтэй, хүүхдүүд нь хараа хяналтгүй, эсхүл эх нь ажил хийж хүүхдүүд нь төрсөн эцэг, эсхүл хойд эцэг, өвөө, ах, эсхүл садан төрлийн хамаарал бүхий эрэгтэй хүнтэй үлдэж байгаа хүүхдүүдийн орчинд илүү их үйлдэгдэж байна. Энэ төрлийн гэмт хэрэг Улаанбаатар хотын тухайд бүх дүүрэгт үйлдэгдэж байгаа боловч тоон мэдээллийн хувьд Сонгинохайрхан дүүрэгт илүү их зонхилж байна гэж үзэж байгаа. Энэ дүүрэгт амьдралын түвшин доогуур орлоготой, хөдөө орон нутгаас шилжин ирэгсэд ихтэй, өөрсдийн байр суурийг олоогүй, эрхэлсэн ажилгүй, орлоготой багатай гэр бүл их байдагтай холбоотой байна гэж үзэж байгаа.

Судалгааны хүрээнд авч судалсан нийт 100 хэрэгт хохирогчоор тогтоогдсон нийт хохирогчдын 94.6 хувь нь хүүхэд бөгөөд үүнээс 67.9 хувь нь 0-14 хүртэл насны, 21.6 хувь нь 14-16 хүртэл насны, 10.3 хувь нь 16-18 хүртэл насны хүн байна.

Үндэсний статистикийн хорооны гэмт хэргийн статистикийн 2020 оны мэдээллээр энэ төрлийн гэмт хэрэгт 0-7 хүртэл насны 19, 8-17 хүртэл насны 314 хүүхэд, 2021 оны мэдээллээр 0-7 насны 19, 8-17 насны 343 хүүхэд өртөж хохирсон нь энэ төрлийн гэмт хэрэгт насанд хүрээгүй хүн өртөж хохирох байдал өсөх хандлагатай байгааг нотолж байна.

Ялангуяа хохирогч хүүхдүүдийн дунд 0-14 хүртэл насны хүүхдийн эзлэх хувь хэт өндөр байгаад анхаарал хандуулах зайлшгүй шаардлагатай болсныг харуулж байна.

Энэ нь эмзэг байдал бүхий, оюун ухаан нь бүрэн төлөвшиж хөгжөөгүй, насанд хүрсэн хүний асрамж хамгаалалтад, тэднээс хараат байдаг зэрэгтэй холбоотой байхаар байна. Тухайлбал, хавтаст хэргийн судалгааны хүрээнд 112 хохирогчийг хэрхэн энэ гэмт хэргийн хохирогч болгосон аргыг нь судалж үзэхэд:

- үйлдэгчтэй хамт амьдардаг, бусдаас тусламж хүсэх бололцоогүй буюу ганцаараа байхад нь, өөрийн гэртээ оруулах зэргээр 49 (44%) хүнийг өөрийн эрхшээлд байгааг далимдуулсан,

- “ална, зодно” гэх зэрэг хүчирхийлэл үйлдэхээр айлган сүрдүүлж, заналхийлэн 18 (16%) хүнийг,

- санхүүгийн хувьд хараат байдгийг нь далимдуулан 7 (6%) хүнийг,


- хүч хэрэглэн 101 (90%) хүнийг ,

- дуртай зүйлийг нь авч өгч, мөнгө өгөх зэргээр хуурч эрхшээлдээ оруулан 4 (3,5%) хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч болгосон байна.

Үр дүн 3. Насанд хүрээгүй хүн өөрийн гэр бүлийн гишүүн, хамаарал бүхий этгээдийн эрхшээлд орж, бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөр байгаа нь хавтаст хэргийн судалгааны үр дүнд ажиглагдаж байна.

Хавтаст хэргийн судалгааны үр дүнгээс харвал хохирогч хүүхдүүд өөрийн амьдарч буй гэртээ хохирохоос гадна 6 хувь нь эгч ахындаа амьдарч байхдаа, 7 хувь нь өвөө, эмээгийндээ амьдардаг, эсхүл тэдэн дээрээ ирсэн байхдаа, 6 хувь нь сургуулийн амралтаар бусдын гэрт очсон байхдаа энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болжээ.

Зураг 12. Гэмт хэрэг үйлдэгдсэн газар



Дийлэнх тохиолдолд хохирогч нь өөрийн амьдардаг гэртээ байх хугацаандаа энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болж байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг гэр бүлийн, ойр дотны, найз нөхдийн, хамаатан садны, танилын хүрээнд үйлдэгдэж байгааг харуулж байна. Энэ нь гэмт хэргийн илрүүлэлтэд ч сөргөөр нөлөөлөл үзүүлдэг байна.


2020 онд бүртгэгдсэн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдсэн 505 гэмт хэргийн 334 буюу 66.1 хувь нь гэр, орон сууцанд, 43 буюу

8.5 хувь нь гудамж талбайд үйлдэгджээ²³. Харин 2021 онд бүртгэгдсэн 540 гэмт хэргийн 386 буюу 71.5 хувь нь гэр, орон сууцанд, 41 буюу 7.6 хувь нь гудамж талбайд үйлэгджээ²⁴.

Шигтгээ 4. 21...569 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Шүүгдэгч “Хүчиндэх” гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдэж, Хүүхдийн эрхийн конвенцод заасан хүүхдийн дээд эрх ашгийг зөрчсөн, уг гэмт хэргийн шинж чанар, хохирол, хор уршгийн байдал, гэмт хэрэг үйлдэгдэх болсон “...бага насны хүүхдүүдийг хараа хяналтгүй орхиж байгаа байдал гэмт хэрэг гарахад нөлөөлсөн буюу шүүгдэгч С.Л нь энэхүү нөхцөл байдлыг ашиглан гэмт санаа зорилгоо хэрэгжүүлсэн...” шалтгаан нөхцөл, “...хохирогчийн ар гэрт нөлөөлж, өөрийн үйлдлийг хаалгах, хэрэгсэхгүй болгох, гэмт хэрэг үйлдэгдээгүй мэт болгох гэж оролдсон...” хувийн байдал зэргийг харгалзан С.Л-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар 15 жилийн хугацаагаар хорих ялыг, хаалттай хорих байгууллагад эдлүүлэхээр шийдвэрлэв.

Зураг 13. Гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч хохирогчийн хамаарал



Дээрх судалгааны үр дүнгээс харвал хохирогч нь, ялангуяа насанд хүрээгүй хохирогч нь өөрийн төрсөн болон үрчилж авсан, хойд эцэг, ах, өвөө, садан төрлийн хүмүүсийн эрхшээлд орж, хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон байна. Бидний судалсан 100 хэргийн 30 хувьд нь ураг төрлийн хүний зүгээс үзүүлсэн бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэг байсан.

²³ Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик-2020

²⁴ Үндэсний статистикийн хороо, Гэмт хэргийн статистик-2021

Шигтгээ 5. 17...139 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Х.Б нь 2004 оны 6 дугаар сарын 21-ний өдөр төрсөн, бага насны буюу 13 настай өөрийн төрсөн охин О-г 2016 оны 11 дүгээр сараас хойш 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Сонгинохайрхан дүүргийн ... дүгээр хороо, Их нарангийн ... дугаар гудамжны .. тоотод байх гэртээ 3 удаа, Чингэлтэй дүүргийн ... дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг "Цэнгэл" төвийн караокед 3 удаа, уг төвийн дэн буудалд 1 удаа, нийт 7 удаагийн үйлдлээр бэлгийн харилцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

Шигтгээ 6. 20...109 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Б.Т нь Увс аймгийн Ховд сумын Ачит багийн нутагт охиныхоо ангийн охин, насанд хүрээгүй хохирогч 15 настай Т-г малынх нь ажилд туслахаар ирсэн байхад нь хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж 2019 оны 08 дугаар сарын 27-ноос 2019 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хүртэл хугацаанд 4 удаагийн үйлдлээр хүчиндэж, жирэмсэн болгосон. Эхнэр хүүхдүүдийнхээ дэргэд, шөнө дунд өөрийнх нь гэрт хүчинддэг байсан. Хохирогчид 2 сая төгрөг хохиролд өгсөн, гомдолгүй гэсэн мэдүүлгийг хохирогчийн хууль ёсны төлөөлөгч/ээж нь/ мэдүүлсэнг шийтгэх тогтоолд дурдсан. Хохирогч Т хүүхдийг нь төрүүлсэн, өсгөж байгаа. Сургуулиасаа гарсан.

Шигтгээ 7. 19...489 дугаартай эрүүгийн хэрэг

Г.Э нь Хан-Уул дүүргийн ... дугаар хороо, Нүхтийн ... дүгээр гудамжны 49 тоот гэртээ болон хашаан доторх тахианы байрандаа 2016 оны зунаас 2018 оны намар хүртэл зээ охин, 11 настай Б-г биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эрхшээлдээ байгааг далимдуулан бэлэг эрхтнээ хөхүүлж бага насны хүүхдийн эсрэг бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн. Хохирогч, түүний дүүг эмээ, өвөөгийнх нь асрамжид байлгадаг нэрээр эцэг, эх нь хайхардаггүй, аль аль нь тусдаа амьдралтай болсон.

Эцэг эх нь гадаадад, эсхүл эцэг эхээсээ тусдаа амьдардаг, өнчин зэрэг амьдрах орчинд нь анхаарал тавих шаардлагатай хүүхдийн судалгааг тусгайлан гаргаж, гэр бүлийн орчны нөхцөлд нь хяналт тавих ажлыг сургуулийн нийгмийн ажилтан, анги удирдсан багшийн хувьд хийх ажиллагаа тулгамдсан асуудал болсон байна.

Үр дүн 4. Бага насны хүүхэд /14 насанд хүрээгүй/ -ийн эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, бие махбод, сэтгэхүйн хувьд өөрийгөө хамгаалах, илэрхийлэх чадвар бүрэн эзэмшээгүй, үг болон үйлдлээс нь эмээж хялбархан эрхшээлд нь ордог зэрэг хүүхдийн биеэ хамгаалж чадахгүй онцлогтой холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох тохиолдол нэмэгдэх хандлагатай

байна.


Хүснэгт 14. Шүүхээр шийдвэрлэгдсэн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хохирогчоор тогтоогдсон насанд хүрээгүй хүмүүсийн тоон мэдээлэл

Он		2018	2019	2020	2021
12.1. Хүчиндэх	Нийт	278	265	308	346
	14-18 нас	31	40	33	27
	бага насны	105	118	120	157
12.2. Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	Нийт		2	9	10
	14-18 нас			1	1
	Бага насны			6	7
12.3. Бэлгийн мөлжлөг	Нийт	1	1		
	14-18 нас				
	Бага насны				
12.5. Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох	нийт	30	72	52	86
	14-16 нас	16	28	35	2

Эх сурвалж: Шүүхийн статистикийн мэдээлэл

Хүүхдийн энэхүү онцлогтой холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох тоо буурахгүй өссөөр байна. Хүчирхийлэгч нь гэр бүлийн бүх гишүүдээ зоддог, үгээр болон үйлдлээр айлган сүрдүүлдэг, байнгын айдастай байлгадаг, бүхий л байдалд өөрийн хяналтыг бүрэн тогтоосон байдаг. Хүчирхийлэгчийн энэ байдлаас шалтгаантайгаар хохирогч тэр хүний эрхшээлд орж, биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болдог байна.

Зураг 14. Хохирогчийн эрхшээлд нь орсон тухай үзүүлэлт



Шигтгээ 8. 20...074 дугаартай эрүүгийн хэрэг

Хохирогч Х-г хүргэн ах нь 14 настайгаас нь эхлэн 3 жил хүчиндсэн. Нэг удаа найзынхаа хажууд хүчиндэж, биед нь халдсаныг нь төрсөн ах руугаа утасдан хэлэхэд ах нь цагдаад мэдэгдсэн. Гэр бүлээрээ О.Ц-ээс айж, түүний бүрэн эрхшээлд амьдардаг.

О.Ц нь урьд нь 3 удаа өөр төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан. Эгчийг нь удаа дараа зодож байсан. Хохирогчийн нүдэн дээр нь заазуур барьж, эгчийг нь ална гэж дайрч байсан. Гэртээ найз нөхдөө авчирч архидан согтуурдаг, хүссэнээ хийлгэдэг байдал хэрэгт тогтоогдсон.

Хохирогч Х-г нөхөр нь хүчирхийлдэг талаар эгч нь мэдээд цагдаад гомдол гаргаж шалгуулж байгаад, хэрэг бүртгэлтийн шатанд “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж шийдвэрлэсэн. Тухайн хэрэгт хохирогч Х-ээр “Хүргэн ах О.Ц-дээ хайртай. Сайн дураараа бэлгийн харьцаанд ордог байсан. ...”, эгч Г-ээр нь “...Гомдол саналгүй. Манай дүү өөрөө сайн дураараа манай нөхөртэй бэлгийн харьцаанд ордог юм билээ. ...” гэж мэдүүлэг өгүүлсэн.

Шүүх хуралдаанд эгч Г нь мэдүүлэхдээ “...О.Ц айлган сүрдүүлж, дүү бид хоёрт үг зааж хэлүүлсэн. Их айдаг. Намайг зодож, гэмтээж байсан. Надад дахиж ингэхгүй, уучлаач гэсэн боловч дахин дүүг маань хүчиндсэн. Манай дүү 2 ч удаа жирэмсэн болж, 1 удаа абортод, 1 удаа ураг нь зулбаж байсан...” гэжээ.

Дээрх эрүүгийн хэргээс дүгнэхэд, байнгын гэр бүлийн хүчирхийлэлд байлгадаг үйлдэгч нь эхнэртээ буюу хохирогч хүүхдийн эгчид нь хуурамч амлалт өгч, хохирогчийг ятгуулан мэдүүлгийг нь өөрчлүүлж өөрт ашигтай байдал үүсгэж, үргэлжлүүлэн хохирогчийг хохироосоор байжээ.

Хүүхэд ийнхүү асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс хараат байдаг учраас бэлгийн боловсрол олгох, хүчирхийллийн бүхий л хэлбэрээс ангид байх эрхийг нь нийгмийн орчинд нээлттэйгээр сурталчлах, хичээлийн хөтөлбөртэй болгох ажлыг хийх шаардлагатай.

Шигтгээ 9. Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Хүүхдийг яагаад энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох байдал өсөөд байна гэхээр хүүхдийн өөрийнх нь төлөвшөөгүй, цэвэр ариун байдаг. Мөн хүүхэд хүнд итгэмтгий, биеэ хамгаалах хэмжээний насанд хүрээгүй байна гэх мэтээр насанд хүрсэн хүнийг бодоход хохирох боломж ихтэй байгаад байна.

Тиймээс хүүхдийг хохирогч болгохгүйн тулд хамгийн наад зах нь хүний бэлгийн амьдрал, эрх чөлөөний мэдлэгийг нас насанд нь тохирсон байдлаар олгох хэрэгтэй. 6 настай хүүхэд юуг мэдэх ёстой вэ? 7,8 настай хүүхэд юу мэдэх ёстой вэ гэх зэргээр.

Шигтгээ 10. 18...189 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Н.П нь 206 онд, 2018 оны 8 дугаар сарын 15-аас 9 дүгээр сарын 8-ны өдөр хүртэл хугацаанд Сонгинохайрхан дүүрэгт өөрийн ахын дагавар охин, 8 настай Б-ийн бие махбодод бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

Хууль ёсны төлөөлөгч/ээж нь/: "...Нөхөр бид хоёр ажил ихтэй тул гэртээ нэг их хонодоггүй байсан. Охины хувцсыг сольтол дотоож нь норчихсон байсан. Би асууж шалгаахад "...П ах миний уруул дээр үнсдэг. Хоёр эмээг унтсан хойгуур миний боожгойг өвтгөдөг гээд уйлаад эхэлсэн. ... Нэг удаа охин Б надад ээж та надаас мөнгө авах уу гэхээр нь чамд хэн мөнгө өгсөн юм бэ гэхэд П ах надад мөнгө өгсөн гэж хэлж байсан. ..." гэж мэдүүлжээ.

Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжээчдийн хохирогч Б-д хийсэн шинжилгээний дүгнэлтээр "...Онош, оношийн үндэслэл: 2016 онд хүчирхийлэлд өртсөн өгүүлэмжтэй, дээрхи хугацаанаас хойш сэтгэл түгшилт, айдас, цочрол ихсэлтийн шинжүүд илэрсэн, одоогийн сэтгэцийн байдал: -ухамсарт ухаан саруул, сэтгэл түгшилт, цочрол ихсэлтийн шинж, айдсын шинж, шээс задгайрлын шинж, DS:F43.2 Дасан зохицохын эмгэг. ..." гэжээ

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал нь зөрчигдөхөөс гадна сэтгэл түгшилт, цочрол ихсэлтийн шинж, айдсын шинж, шээс задгайрлын шинж гэх мэт эрүүл бус шинжүүд бие махбодод нь илэрч, "DS:F43.2 Дасан зохицохын эмгэг" зэрэг сэтгэцийн өвчтэй болох нь ч байдаг нь тодорхой байна. Эндээс энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нэг бүрд сэтгэл заслын эмчилгээ нэн тэргүүнд хийж байх газар, мэргэжилтэн бий болгох хэрэгцээ байдаг болох нь тодорхой байна.

Үр дүн 5. Энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хугацаа харилцан адилгүй байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэгтэй байгууллагаас хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хамгийн богино хугацаа 1 сар 1 хоног, хамгийн урт хугацаа 19 сар 21 хоног байна.

ЭХХШТХ-ийн 30 дугаар бүлэгт гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, шийдвэрлэх талаар заасан бөгөөд хуулийн энэ зохицуулалтын дагуу мөрдөгч, прокурор өөрсдийн чиг үүргийн дагуу ажиллаж байна. Мөрдөгч, прокуророос аливаа гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш тухайн гомдол, мэдээлэлд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ЭХХШТХ-ийн 30.7 дугаар зүйлийн 1.1-1.6 дахь хэсэгт зааснаар гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг 5 хоногт багтаан явуулдаг. Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга нь дээрх хугацааг 14 хүртэл хоногоор сунгаж болдог.

Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагааны хугацаатай

холбоотой авсан мэдээлэлд нийт 89 гэмт хэргийн талаарх мэдээлэл багтсан бөгөөд үүнээс 2 л хэрэгт 5-аас дээш хоногоор гомдол, мэдээллийг шалгасан ба бусад бүх хэрэгт хуулийн анхны хугацаанд нь шалгаж, дараагийн шийдвэрүүдийг гаргасан байна.

Мөрдөгч гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хянан үзээд гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох шаардлагатай бол гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 5 хоногийн үзлэг хийх, шинжилгээнд зориулж дээж, хурууны хээ, ул мөрний хэв авах, хохирогч, гэрчээс мэдүүлэг авах, хэрэгт ач холбогдол бүхий тээврийн хэрэгсэл, мөнгө, эд зүйлийг хурааж авах, эд хөрөнгийг битүүмжлэх, шинжээч томилох зэрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулна.

Дээрх ажиллагааг явуулснаар мөрдөгч хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурорт гаргах, харьяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт гаргах гэсэн шийдвэрүүдийн аль нэгийг гаргах учиртай.

Мөрдөн шалгах ажиллагаа явуулах чиг үүрэгтэй байгууллагаас хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах хамгийн богино хугацаа 1 сар 1 хоног, хамгийн урт хугацаа 19 сар 21 хоног байна. Гэхдээ цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 89 хэргийн мөрдөн шалгах ажиллагааны хугацааг харьцуулан авч үзвэл 49 хэрэг буюу 55.0 хувь нь 2 хүртэл сарын хугацаанд, 17 буюу 19 хувь нь 6-аас дээш сарын хугацаанд шалгасан байна.

Ганцаарчилсан ярилцлагын үр дүнгээс дүгнэхэд хуулийн сахиулах чиг үүргийн байгууллагууд хуульд заасан хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахаар зорьж байгааг илэрхийлж байсан. Судалгааны багийн зүгээс дүгнэхэд дээрх тоон мэдээлэл болон 100 хэрэгт дүн шинжилгээ хийхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа хуулийн хугацаанд шийдвэрлэж байгаа нь ажиглагдаж байна.

Үр дүн 6. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахад хамгийн түгээмэл тулгамдаж буй асуудал нь ДНХ-н шинжилгээ хийлгэх ажиллагаа байна.

ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ²⁵.

Мөрдөгч аливаа хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа холбогдох нотлох баримтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлэх үүрэгтэй бөгөөд ийнхүү цуглуулсан нотлох баримт нь үйл баримтыг зөв тогтоох, шүүхийн шийдвэрийн үндэслэл болох учиртай.

²⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №40

Зураг 15. Нотлох баримтын төрөл

Нотлох баримтын төрөл	Мэдүүлэг
	Эд мөрийн баримт
	Баримт бичиг
	Шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг
	Мөрдөгчийн магадлагаа
	Кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв
	Мөрдөн шалгах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт мэдүүлгэн нотлох баримтаас гадна шүүхийн шинжилгээний төв болон харъяа байгууллагад явуулж буй шүүх эмнэлгийн шинжээчийн дүгнэлт, тэр дундаа тусгай шинжилгээний нэг төрөл болох ДНХ-н шинжилгээний дүгнэлт хамгийн чухал байр суурийг эзэлнэ. Өөрөөр хэлбэл бэлгийн халдашгүй байдалд халдсан үйлдэл цаг хугацааны хувьд ямар хугацааг хамарч байгаагаас шалтгаалж дээрх 2 төрлийн шинжилгээг хийж байна.

Шигтгээ 11. Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...


Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт байцаалтаас гадна хамгийн чухал хийж байгаа процесс ажиллагаа бол шинжилгээ хийлгэх. Хохирогчийн биед учирсан гэмтлийн зэргийг тогтоохоос гадна бэлэг эрхтэнд учирсан гэмтэл, охин хальсны урагдалт, цооролт хэзээ үүсгэгдсэн байх боломжтой эсэх, эр бэлгийн эс, үрийн шингэн илрэх эсэх зэргийг тогтоолгосноор хохирогч, холбогдогч хоёулаа шинжилгээ хийлгэж байгаагаараа онцлогтой.

Шигтгээ 12. Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Хүний бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт явуулж буй тодорхой ажиллагаанаас хамгийн чухалд тооцогдох нэг ажиллагаа нь шүүх эмнэлгийн шинжилгээ хийлгэх юм. Энэ төрлийн гэмт хэрэгт шүүх эмнэлгийн шинжээч эмчийн дүгнэлтээс гадна үйлдэгдээд удаагүй хэрэгт ДНХ-н шинжилгээ хийлгэж байгаа. Ерөнхийдөө шүүх эдгээр нотлох баримтыг шийдвэрийнхээ үндэслэл болгож байгаа. Гэхдээ орон нутагт ДНХ-н шинжилгээ хийх лаборатори байхгүй тул заавал Улаанбаатар руу явуулдаг. Энэ нь хэргийн хугацаа алдах нэг нөхцөл болж байдаг.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас ирүүлсэн тоон мэдээллээс үзвэл бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хийж буй шүүх эмнэлэгийн шинжилгээний тоон үзүүлэлт өсч байгаа нь харагдана..

Зураг 16. 2019-2021 онд шүүх эмнэлгийн шинжилгээний газарт бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт



Цагдаагийн байгууллагад 2019 онд бүртгэгдсэн 481 хүчиндэх гэмт хэрэгт 769 шинжилгээ, 2020 онд бүртгэгдсэн 401 хүчиндэх гэмт хэрэгт 930 шинжилгээ, 2021 онд бүртгэгдсэн 409 хүчиндэх гэмт хэрэгт 990 шинжилгээ хийгдсэн. Энэ нь бүртгэгдсэн нэг хүчиндэх гэмт хэрэгт 2 шинжилгээ хийгдэж байгааг илтгэж байна.

Харин 2019 онд 769 шинжилгээ хийсэн боловч 2021 онд 990 шинжилгээ буюу 28.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлт нь бүртгэгдэж буй гэмт хэрэгтэй шууд хамааралтай болно.

Гэхдээ энэ тоонд гэмт хэргийн улмаас хохирсон хохирогчоос гадна гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээдэд хийсэн шинжилгээний тоон мэдээлэл орсон байгааг анхаарах хэрэгтэй²⁶.

Үр дүн 7. Шүүхийн шинжилгээний байгууллагын Тусгай шинжилгээний газрын ДНХ-н лабораторийн үйл ажиллагааг мэргэжлийн 5 шинжээч хариуцан ажиллах бөгөөд 1 шинжээчид жилд 361 шинжилгээ ногдож байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм. Түүнчлэн 1 шинжилгээнд хамаарах объектын тоо нь 3-4 байгаа нь маш өндөр ачаалалтай ажиллаж байгааг харуулж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас ирүүлсэн тоон мэдээллээс харвал тусгай шинжилгээний газарт хийж байгаа шинжилгээний тоо буурах үзүүлэлттэй байгаа нь харагдаж байна.

²⁶ ШШҮХ-ийн одоогийн цахим сан хохирогч болон холбогдогчийн аль нь болох талаарх ангилан ялгалтыг хийх боломжгүй талаар мэдэгдсэн байна.


Хүснэгт 15. Тусгай шинжилгээний газрын ДНХ-ийн лабораторид хийж буй шинжилгээний тоон харьцуулалт

	Хийсэн шинжилгээ	Шинжилгээ хийсэн объект	Лабораторийн шинжээчийн тоо/оногдох шинжилгээ
2019	2076	7243	4/519
2020	2008	7020	4/502
2021	1807	7018	5/361

Гэвч техникийн боломжоос шалтгаалан дээрх шинжилгээнээс хичнээн хувь нь бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хийгдсэн шинжилгээ болох нь тодорхойгүй байна.

Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт хийгдсэн шинжилгээнд хамрагдсан хүмүүсийн нас, хүйсийн харьцааг авч үзвэл насанд хүрсэн эмэгтэй, насанд хүрээгүй эмэгтэй хүний эзлэх хувь харьцангуй өндөр байна.

Зураг 17. Хүчиндэх, гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт хийсэн шинжилгээний тоог нас, хүйсээр харьцуулсан байдал



Дээрх судалгаанаас харвал хүчиндэх болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн оролцогч болсон насанд хүрээгүй эмэгтэй хүнд хийгдэж байгаа шинжилгээний тоо тогтмол өндөр өсөлттэй харагдаж байгаа бол насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй оролцогчийн тухайд харьцангуй тогтвортой нь ажиглагдаж байна. Энэ нь дээр авч үзсэн энэ төрлийн гэмт хэрэгт насанд хүрээгүй хүн өртөж хохирох явдал өсөх үзүүлэлттэй байна гэсэн судалгааны үр дүнг баталгаажуулж байна. Түүнчлэн Тусгай шинжилгээний газрын ДНХ-н лабораторид хийж буй шинжилгээ нь дан ганц хохирогчид бус гэмт хэрэг үйлдсэн байж болзошгүй этгээд нэг бүрт хийгдэх боломжтой, хийдэг шинжилгээ тул статистикийн мэдээлэл харьцангуй өндөр байхаар харагдаж байна.

Зураг 17-д үзүүлсэн тоон статистик нь хүчиндэх болон гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт хийгдсэн нийт шинжилгээний тоо бөгөөд үүнийг гэмт хэргийн төрлөөр ялган үзэх боломжгүй талаар мэдэгдсэн. Өөрөөр хэлбэл Шүүхийн шинжилгээний байгууллагын статистикийн мэдээлэл нь гэмт

хэргийн төрөл, ангиллаар бус хийгдсэн шинжилгээний тоон үзүүлэлтээр харагдаж байгаа нь тус хүрээлэнгийн дата мэдээлэл бүхий сангийн үйл ажиллагаатай холбоотой бөгөөд цаашид тус хүрээлэнд хийгдэж буй шинжилгээний мэдээллийг гэмт хэргийн төрөл, ангилал, шинжилгээний төрлөөр гэх мэтчилэн нарийн гардаг байхад анхаарах зайлшгүй шаардлагатай нь харагдаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын тусгай шинжилгээний газарт харъяалагдах ДНХ-н лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар 5 бүс нутагт байгуулах асуудлыг нэн яаралтай судалж, шийдвэрлүүлэх нь тодорхой төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт, нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг дээшлүүлэхэд түлхэц болох юм. Учир нь ДНХ-н лабораторийн шинжилгээ нь шинээр буюу анх удаа үйлдэгдсэн гэмт хэргийн ул мөр бүхий шинжилгээний объектод шинжилгээг хийх боломжтой байдаг боловч орон нутагт энэ төрлийн лаборатори байхгүйн улмаас хугацаа алдах, гэмт хэргийн нотлох баримт нотолгооны ач холбогдлоо алдах зэрэг эрсдэлтэй байдал ордог. Энэ нь эргээд гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтэнд сөргөөр нөлөөлж байдаг онцлогтой байна.

Үр дүн 8. Насанд хүрээгүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах байдал харилцан адилгүй байна. Насанд хүрээгүй хохирогчтой эрүүгийн хэргийн 40% орчим хувьд нь тухайн харьяаллын ГБХЗХГ-н мэргэжилтнүүд хууль ёсны төлөөлөгчөөр оролцсон байна

УИХ-аас 2013 онд төлбөрийн чадваргүй яллагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг тогтоох зорилгоор Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлан гаргасан²⁷. Гэвч төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой эрх зүйн орчин байхгүй 10 орчим жил болсны эцэст 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Хууль зүйн туслалцааны тухай хууль батлагдсанаар энэ асуудлыг шийдвэрлэх боломж бүрдсэн²⁸.

ЭХХШтХ-ийн 9.5 дугаар зүйлд зааснаар арван найман насанд хүрээгүй хохирогчийн тухайд түүний төрсөн, үрчилж авсан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг; хэрэв ийм хүн байхгүй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоохоор заасан. Хэдийгээр төрөөс насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ өмгөөлөл, хууль зүйн туслалцаатай холбоотой асуудлыг орхигдуулсан ч хууль ёсны төлөөлөгчийг оролцуулах эрх зүйн орчныг бий болгосон байна.

²⁷ Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2013, №3

²⁸ Гэхдээ энэхүү судалгааны хамаарах цаг хугацаанд хохирогчийн өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрхийн зохицуулалт хязгаарлагдмал байсныг зориуд тэмдэглэж байна.

Хууль ёсны төлөөлөгчөөр томилогдсон этгээд, ялангуяа Гэр бүл, хүүхэд, залуучуудын байгууллагаас томилогдон оролцож байгаа төрийн албан хаагч нь үндсэн үүрэгт ажлын хажуугаар энэхүү үйл ажиллагаанд оролцдог тул мөрдөн шалгах ажиллагаанд оролцох оролцоо харилцан адилгүй байна. Энэ нь цаашид бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн хохирогчдод тэр дундаа насанд хүрээгүй хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлдэг, дагнасан, мэргэшсэн, тусгай алба хаагч, мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийг чадавхжуулах ажилд анхаарлаа хандуулах хэрэгцээ шаардлага бий болсон байгааг харуулж байна.

Шигтгээ 13. Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Насанд хүрээгүй хүн хохирогч болж байгаа ихэнх тохиолдол түүний гэр бүлийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзээд аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсээс хууль ёсны төлөөлөгчийг томилон оролцуулж байгаа. Гэхдээ манай аймгийн хууль зүйн хорооны мэргэжилтэн ажлын ачааллаасаа болоод ч тэр үү мөрдөн шалгах ажиллагаанд оролцох нь хойрго санагддаг.

Шигтгээ 14. Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Манай цагдаагийн газарт хүүхэд хүчиндэх ч гэдэг юм уу бэлгийн хүчирхийллийн хохирогч болчихлоо гэсэн дуудлага ирмэгц бид аймгийнхаа гэр бүл, хүүхэд залуучуудын газарт ханддаг. Тэндээс хууль ёсны төлөөлөгч томилуулж аваад мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг. Манай аймгийн ГБХЗХХ-ийн дарга санаачилгатай хүн байдаг учраас мэргэжилтнүүд нь ч хэрэг шалгах ажиллагаанд тогтмол дэмжлэг үзүүлээд ажиллаж байгаа. Ямар нэгэн үл ойлголцох асуудал гардаггүй. Тэр хүн маань хохирогчоо дагуулаад эмнэлгийн үйлчилгээнд хамруулах зэрэг өөрөөс шалтгаалах бүх ажлыг хариуцаад аваад явчихдаг.

Шигтгээ 15. Прокурортой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Би Дархан-Уул аймгийн хэмжээнд насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хяналт тавьж ажилладаг. Манай аймгийн тухайд жишиг гээж хэлж болохуйц нэг ажлыг энэ төрлийн хэрэг бүрд авч хэрэгжүүлж байгаа. Өөрөөр хэлбэл насанд хүрээгүй хүүхэд хохирогч болсон тохиолдолд аймгийн гэр бүл, хүүхэд залуучуудын газрын гэрээт өмгөөлөгч нарыг оролцуулахаас гадна сэтгэл зүйн гэмтлийг тогтоолгож шаардлагатай эмчилгээ, нөхөн сэргээх засалд явуулдаг. Гэрээт өмгөөлөгчид төлөх 700,000 төгрөгийн зардлыг ГБХЗХХ-ээс гаргахаас гадна сэтгэл зүйн засал үйлчилгээ 1 жилийн хугацаатай хийхээр байвал 2 сая төгрөг гэх мэтчилэн тооцож мөн гаргуулдаг. Энэ төлбөрийг ГБХЗХХ-ээс хууль ёсны төлөөлөгчөөр оролцож байгаа хүнийг иргэний нэхэмжлэгчээр тогтоогоод гэм буруутай этгээдээс нэхэмжилж байгаа. Аймгийн шүүх ч энэ байдлыг жишиг болгон хэрэгжүүлж нэг хэрэгт хамгийн доод тал 2.7 сая төгрөгийн хохирлыг төлүүлэх шийдвэрийг гаргаж байгаа. Энэ шүүхийн шийдвэрийн биелэлт аймгийн хэмжээнд 80 хувьтай байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт юм.

Шигтгээ 16. Мөрдөгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс...

Аймгийн хэмжээнд үйлдэгдэж байгаа бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэгт хүүхэд өртөж хохирсон л бол ГБХЗХХ-тэй гэрээгээр ажилладаг өмгөөлөгч нар байдаг. Тэд нарыг оролцуулдаг. Мөн аймагт үйл ажиллагаа явуулж байгаа сэтгэл зүйн гэмтэл оношлох байгууллагаар хохирогч бүрийн сэтгэцийн гэмтлийг оношлуулж, тодорхой эмчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулдаг. Энэ нь 1 жилийн хугацаатай бол 2 орчим сая төгрөгийн зардал болдог. Өмгөөлөгчийн зардал нь 700,000 төгрөг, нийт 2.7 сая төгрөгийг ГБХЗХХ-ээс гаргадаг бөгөөд шүүхэд иргэний нэхэмжлэл гаргаж хохирлыг буруутай этгээдээр төлүүлж байгаа. Энэ нь манай аймгийн хувьд маш том дэвшил юм.

Хэдийгээр хуулиар зохицуулагдаагүй боловч эрх зүйн бусад баримт бичгийн хүрээнд үүссэн асуудлыг шийдвэрлэхэд оролцогч талуудын хандлага чухал байгааг үүгээр харуулж болох юм. Өөрөөр хэлбэл хуульд зохицуулагдаагүй гээд орхих бус боломжтой бүх арга хэмжээг хуулийн дагуу авах, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж болдог гэдгийг Дархан-Уул аймгийн шүүх, прокурор, цагдаа, ГБХЗХХ-ийн жишээнээс харж болохоор байна.

Насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй ГБХЗХГ-ын мэргэжилтэн, бусад хохирогчид хамгааллын үйлчилгээ үзүүлж буй ТББ-ын төлөөлөгч нарын нотлох баримтыг бүрдүүлэх, хохирлыг зөв тогтоох ажиллагааг хууль зүйн дагуу хийх мэдлэгийг нэн даруй сайжруулах шаардлагатай байна. Учир нь хүүхэд хохирсон нийт хэргийн 40 хувьд нь ГБХЗХГ-ын мэргэжилтнийг хууль

ёсны төлөөлөгчөөр томилсон байх бөгөөд тэдний зүгээс хохирогчид учирсан хохирлыг нотлох баримтаар тогтоох, бүрдүүлж өгөх явдал зарим тохиолдолд хангалтгүй байгаа нь шүүхийн шийдвэрүүдэд бичигдсэн байна.

Шигтгээ 17. 20...238 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Сэтгэл зүйн оношилгооны дүгнэлтээр өсвөр насны хохирогч Н.М, Н.О, Н.М нар сэтгэл зүйн хувьд зовуурь шаналлын ямар хэлбэр, төрөлтэй байгаа, тэдгээрт сэтгэл заслын ямар эмчилгээг, ямар хугацаанд хийх, тэдгээрийн үнэ тариф зэргийг тодорхой зааснаас гадна бага насны хүүхдийн хувьд тархи бүрэн хөгжиж, бие хүн болж төлөвших хүртэл өөрийн сэтгэл хөдлөл дээр тулгуурлаж шийдвэр гаргах, өөрийн хяналтгүй шийдвэр гаргах магадлал өндөр, түүнчлэн бага насанд авсан санаа сэтгэлийн цочрол нь насан туршид нь хадгалагдаж үлдэх, буруу зан үйлд татагдах зэрэг үр дагавартай тул тогтмол сэтгэл зүйчтэй уулзаж, зөвлөгөө авахыг дүгнэжээ.

Прокурор гэмт хэргийн улмаас бага насны хохирогч нарын эрүүл мэндэд учирсан хор уршгийг тодорхой хугацаанд эмчлүүлэхэд гарах хохирлыг шүүгдэгч нараас гаргуулах талаар үндэслэл бүхий санал гаргасан боловч бага насны хохирогч нарын төлөөлөгч, өмгөөлөгч нар эмчилгээ хийлгэсэн хохирлын баримтыг гаргаж өгөөгүй төдийгүй "...Сонгинохайрхан дүүргийн гэр бүл, хүүхэд хөгжлийн хэлтсээс санаачлан "Хөөрхөн зүрх" ТББ-тай хамтран үнэ төлбөргүйгээр бага насны хохирогч нарт сэтгэл заслын зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн. Цаашид бас үзүүлнэ. Энэ төрлийн ТББ-тай хамтран ажиллах боломжтой. ГБХЗХГ-ын "Хүүхэд хамгаалал"-ын төсвөөс сэтгэл заслын зардлыг санхүүжүүлэх боломжтой. ..." гэсэн талаар тайлбар, дүгнэлт хэлсэн тул шүүгдэгч нараас зардлыг гаргуулахгүйгээр шийдвэрлэж, эмчилгээ хийлгэх үүргийг СХД-ийн ГБХЗХХ-ийн мэргэжилтэн, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч нарт хариуцуулав.

Үүнээс гадна гаргасан хохирлын талаарх нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн сайн туршлагауд байгааг доорх шигтгээнээс харах боломжтой юм.

Шигтгээ 18. 21...524 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

У.Б нь үргэлжилсэн үйлдлээр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ өөрийн гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай, төрсөн охид болох насанд хүрээгүй Б.О, Б.С нарын хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан Б.О-той хүчээр бэлгийн харьцаанд орж, хүчиндсэн, Б.С-тэй бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

Давж заалдах шатны шүүх: "... Анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ хохирогчдын төлөөлөгч "Хөөрхөн зүрхнүүдийн аян" төрийн бус байгууллагын гаргасан иргэний нэхэмжлэлийг "шүүхийн нэрийг андуурч буруу бичсэн" үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "шүүх шийтгэх тогтоол гаргахдаа иргэний нэхэмжлэлийг түүний үндэслэл, хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан бүгдийг, эсхүл хэсэгчлэн хангах, эсхүл хэрэгсэхгүй болгоно" гэснийг зөрчсөн гэж үзэхээр байна.

Учир нь, хэрэгт авагдсан баримтуудаар насанд хүрээгүй хохирогч нарын хууль ёсны төлөөлөгч, тус төрийн бус байгууллагын тухайн хэрэг хянан шийдвэрлэх явцад гаргаж зарцуулсан хохирол төлбөр бүрэн тогтоогдсон байхад түүнийг гэм буруутай этгээдээс гаргуулалгүй, жич дахин иргэний шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй гэж шийдвэрлэсэн нь гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг аль болох эрүүгийн хэргийн хамт хамтруулан шийдвэрлэж байх нийтлэг зарчмыг зөрчсөн гэж үзнэ.

Иймд шийтгэх тогтоолын 5 дахь заалтад "шүүгдэгч У.Б энэ тогтоолоор бусдад төлөх төлбөргүй" гэсэн хэсгийг "Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар шүүгдэгч У.Б-ээс нийт 4.405.688 төгрөгийг гаргуулж иргэний нэхэмжлэгч "Хөөрхөн зүрхнүүдийн аян" ТББ-д олгосугай" гэж өөрчилж, шийтгэх тогтоолын бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэлээ..." гэж шийдвэрлэсэн.

Шигтгээ 19. 18...397 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Улсын Дээд шүүх: "...Шүүгдэгч Н.А-ийн үйлдлийн улмаас насанд хүрээгүй хохирогч Э нь 14 насанд хүрээгүй байхдаа жирэмсэн болж 20.. оны .. дугаар сарын 16-ны өдөр хүү Э-ийг төрүүлсэн бөгөөд хэдийгээр хохирогч шүүхэд нотлох баримтаа бүрдүүлж өгөөгүй боловч уг хүүхдийг тээх, төрүүлэх, хооллох, өсгөн бойжуулахад зайлшгүй зардал гарсан болохыг агуулгын хувьд шүүх үнэлж, дүгнэн шийдвэрлэх бүрэн боломжтой байх тул хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийн зүгээс гаргуулахаар нэхэмжилсэн 2,000,000 төгрөгийг шүүгдэгч Н.А-с гаргуулахаар шийдвэрлээ.

...Шийтгэх тогтоол, Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн ... магадлалд "Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Н.А-с 2,000,000 / хоёр сая/ төгрөгийг гаргуулж хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Х.Г-аар дамжуулан насанд хүрээгүй хохирогч Э-д олгосугай. Мөн цаашид гарах гэм хорын хохирол, түүний дотор амьжиргааны баталгаажих доод түвшингээр тооцож насанд хүрээгүй хохирогч болон түүний хүүхэд болох Э-ийг насанд хүртэл нь холбогдох хууль тогтоомжид заасан тэтгэмжийг гаргуулахаар иргэний хэргийн шүүхэд хандан нэхэмжлэх эрхтэй болохыг дурдсугай" гэсэн өөрчлөлт оруулж байна. ..." гэж шийдвэрлэжээ.

Шигтгээ 20. 18...139 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Н.П нь 2016 онд болон 2018 оны 08 дугаар сарын 15-аас 09 дүгээр сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд Сонгинохайрхан дүүргийн ... дугаар хороо, ...-ын 26 тоотод бага насны буюу 8 настай Б-д бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн.

Шүүх сэтгэгц эмгэг судлалын 112 дугаар дүгнэлт: "...Б нь 2016 онд хүчирхийлэлд өртсөн үеэс хойш F43.2 дасан зохицохын эмгэг өвчнөөр өвчилсөн. Эмчлүүлэх шаардлагатай. ..."

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч сэтгэл санааны хохирол 5.000.000 төгрөг, хууль зүйн туслалцаа авсны хөлс, хоёр өмгөөлөгчид төлсөн 1.600.000 төгрөг, нийт 6.600.000 төгрөгийг нэхэмжилсэн.


Улсын Дээд Шүүх: "...Шүүхүүд аливаа гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг бодитой учирсан эсэхийг тодорхойлж, бодит хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх ёстой бөгөөд энэ талаар хоёр шатны шүүх үндэслэлтэй дүгнэлт хийж чадаагүй байна. Бага насны хохирогч Б нь "...F 43.2 буюу "Дасан зохицохын эмгэг" өвчнөөр өвчилсөн..." нь тогтоогдсон тул хохирогчийн өвчнийг эмчлэх, сэтгэл санааны нөхцөл байдлыг арилгах зэрэгт гарах зардалд хохирогчоос нэхэмжилсэн 5 000 000 төгрөгийг гаргуулах шаардлагатай, энэхүү нэхэмжлэлийг хангах нь хор уршигийг гэмт хэрэг үйлдсэн этгээдээр зайлшгүй арилгуулж байх шударга байдалд нийцнэ гэж үзлээ..." гэж шийдвэрлэжээ.

Иймд хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч эдгээр ажилтнуудын эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт, сайн туршлагаасаа хуваалцах ажлыг олон талын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж, хүүхдийн хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах нь чухал байна.

Үр дүн 9. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын тусламж үйлчилгээг ГБХЗХГ-ын хүүхдийн тусламжийн 108 төв болон ТББ-ууд үзүүлж байна.

Хүүхэд хамгааллын тухай хуульд гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд тусалж, дэмжих чиглэлээр мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, шалгах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ үзүүлэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх зэрэг үйлчилгээг үзүүлэхээр зохицуулсан. Хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, хүчирхийлэлд өртсөн хүүхэд, түүний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хүүхдийг гэр бүл болон нийгмийн бүхий л орчинд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, санхүүжүүлэхтэй холбоотой асуудлыг Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмаар зохицуулах бөгөөд энэхүү журмыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаалаар баталсан байна.

Зураг 18. Хүүхэд хамгааллын үйлчилгээний зураглал



Одоогийн байдлаар хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг төрийн байгууллага эсхүл тухайн чиглэлээр мэргэшсэн иргэн, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээд төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх замаар үзүүлж байна.


Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдсан гэмт хэргийн хохирогч болсон хүүхдүүдийн хувьд гэмт хэрэг үйлдэгчид, зуучлагч эсвэл хүлээн авагчдын зүгээс ирэх бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон улмаар тарчлаах үйлдлийн хохирогч болсон байдаг нь дээрх төрлийн гэмт хэргийн хохирогчдод тусгайлан хамгаалуулах, урт хугацаанд нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулах, шаардлагатай хэрэгцээг нь хангах онцгой шаардлага тулгардаг.

ГБХЗХГ-ын дэргэдэх хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээ нь 24 цагийн турш үнэ төлбөргүйгээр Монгол улсын өнцөг булан бүрээс 0-18 насны хүүхдийн хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авч, тухайн орон нутаг, байгууллагын мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучлах, яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучлах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн мэдээллийг хүргэдэг.

Түүнчлэн хүүхдийн дуу хоолойг сонсон хүүхэд хамгааллын асуудлаар шийдвэр гаргахад болон хүүхэд хамгаалалд хүүхдийн оролцоог хангах, оролцоонд тулгуурлан хүүхдийг хөгжүүлэх, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалалд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулдаг.

Үр дүн 10. Хүүхдийн тусламжийн 108 утсанд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн талаар ирсэн мэдээллийг авч хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл өсөх хандлагатай гэсэн өмнөх үр дүнгүүдийг баталгаажуулсан үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл 2020 онд 255 дуудлага ирж байсан бол 2021 онд 402 буюу 57.6 хувиар өссөн дуудлага мэдээлэл бүртгэгджээ.

Зураг 19. Хүүхдийн тусламжийн 108 утсанд бэлгийн хүчирхийллийн талаар ирсэн дуудлага, мэдээлэл




Зураг 20. Хүүхдийн тусламжийн 108 дугаарт ирсэн бэлгийн хүчирхийллийн дуудлага, мэдээллийг ангилан авч үзвэл:



Улсын хэмжээнд 2021 оны байдлаар төрийн эзэмшлийн нэг цэгийн үйлчилгээний төв 13, түр хамгаалах байр 22 үйл ажиллагаа явуулж, 2021 онд 2646 хүүхэд, 1261 насанд хүрсэн хүнд туслалцаа, дэмжлэг үзүүлсэн байна. Гэвч үүнээс хэд нь бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон иргэд байгаа талаарх мэдээлэл ГБХЗХГ-аас бидэнд ирүүлээгүй байна.

Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2021 онд үйлчлүүлсэн бэлгийн хүчирхийллийн хохирогч 345 хүүхдэд хуульд заасан дараах туслалцаа дэмжлэг үзүүлсэн байна.

Зураг 21. Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд үзүүлсэн хүүхэд хамгааллын хариу арга хэмжээ /давхардсан тоогоор/




Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ буюу бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний өртөг зардлыг батласан тэрхүү журмын хэрэгжилт ямар түвшинд байгааг дүгнээгүй байна. Түүний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ирүүлээгүй тул энэ талаарх мэдээлэл уг судалгааны тайланд дурдагдахгүй болно.

Үр дүн 11. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдалд халдаж буй нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 70 гаруй хувийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж байна.


Цагдаагийн болон шүүхийн байгууллагын статистикийн мэдээллээс харвал энэ төрлийн гэмт хэргийн гаралт болон эцэслэн шийдвэрлэж буй хэргийн тоог харьцуулбал дунджаар 72.8 хувьтай байна.

Зураг 22. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хүчиндэх гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал




Хүчиндэх гэмт хэргийн тухайд 2018 онд 71 хувийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж, 24.4 хувийг хэрэгсэхгүй болгосон, 2019 онд 73.3 хувийг шүүхээр эцэслэн шийдэж, 22.8 хувийг хэрэгсэхгүй болгосон, 2020 онд 79.5 хувийг шүүхээр шийдэж, 17.4 хувийг хэрэгсэхгүй болгож, 2021 онд 75.6 хувийг шүүхээр шийдвэрлэж, 12.9 хувийг хэрэгсэхгүй болгосон байна. Бүртгэгдсэн гэмт хэргээс шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоо харьцангуй тогтвортой байх боловч хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн тоо жил ирэх бүрд буурах сайн үзүүлэлттэй байна.

Зураг 23. Шүүхийн статистик мэдээлэл /Хүчиндэх гэмт хэргийн шийдвэрлэлт/²⁹



Шүүхийн статистикийн мэдээллээс харвал жил бүрд хүчиндэх гэмт хэргийн шийдвэрлэлт өсөх үзүүлэлттэй байна. Цагдаагийн байгууллагад 2021 онд бүртгэгдсэн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоотой харьцуулбал 78.8 хувь байна. Гэхдээ шүүхийн дүн мэдээнд цагдаагийн байгууллагын судалгаанд өмнөх онд бичигдсэн хэрэг дараагийн жилүүдэд шүүхээр шийдвэрлэгдсэн байх магадлалтай тул тооны хувьд зөрүүтэй мэт харагдаж байгааг онцлох нь зөв юм.


Зураг 24. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал



Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн тухайд 2018 онд 66.6 хувийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж, 33.3 хувийг хэрэгсэхгүй болгосон, 2019 онд 60 хувийг шүүхээр эцэслэн шийдэж, 40 хувийг хэрэгсэхгүй болгосон, 2020 онд 77.7 хувийг шүүхээр шийдэж, 22.2 хувийг хэрэгсэхгүй болгож, 2021 онд 75 хувийг шүүхээр шийдвэрлэж, 18.7 хувийг хэрэгсэхгүй болгосон байна. Бүртгэгдсэн гэмт хэргээс шүүхээр шийдвэрлэсэн хэргийн хувь сүүлийн 2 жилд өсч, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувь жил ирэх бүрд буурсан үзүүлэлттэй байна.


²⁹ <http://judcouncil.mn/site/news/22>

Зураг 25. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал




Бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн тухайд сүүлийн 4 жилд нийт 19 гэмт хэрэг бүртгэгдснээс 11 хэрэг буюу 57.9 хувийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж, 36.8 хувийг хэрэгсэхгүй болгож, 5.2 хувь буюу 1 хэрэг ажиллагаанд шалгагдаж байна.

Зураг 26. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал



Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн тухайд 2018 онд 50.6 хувийг шүүхээр эцэслэн шийдвэрлэж, 48.1 хувийг хэрэгсэхгүй болгосон, 2019 онд 61.0 хувийг шүүхээр эцэслэн шийдэж, 36.4 хувийг хэрэгсэхгүй болгосон, 2020 онд 76.8 хувийг шүүхээр шийдэж, 18.8 хувийг хэрэгсэхгүй болгож, 2021 онд 84 хувийг шүүхээр шийдвэрлэж, 9.3 хувийг хэрэгсэхгүй болгосон байна. Бүртгэгдсэн гэмт хэргээс шүүхээр шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувь өсч, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргийн эзлэх хувь жил ирэх бүрд буурсан үзүүлэлттэй байгаа нь хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох нотлох баримтыг хангалттай цуглуулсны дараа хэргийг шүүхэд шилжүүлж байгаатай холбоотой гэж үзэхээр байна.

Зураг 27. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал




Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийн тухайд бусад бүлгийн гэмт хэргээс харьцангуй өөр дүр зураг ажиглагдаж байна. 2020 онд бүртгэгдсэн гэмт хэргийн дөнгөж 28.5 хувь нь шүүхээр шийдэгдэж байсан бол 2021 онд 42.8 хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж өссөн үзүүлэлттэй байна. Харин хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо 2020 онтой харьцуулбал 5 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Энэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлт бусад гэмт хэргээс харьцангуй доогуур үзүүлэлттэй байгаа нь өмнө нь зөрчлийн хэрэг нээн шалгаж, ихэнхдээ хялбаршуулсан журмаар шийдвэрлэж байсантай холбоотой байхыг үгүйсгэхгүй. Өөрөөр хэлбэл 2020.01.10-ны өдрөөс өмнө энэ гэмт хэрэг зөрчилд тооцогдож, ихэнхдээ хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэж, зөрчил гаргасан этгээдэд торгох шийтгэл оногдуулж байжээ.

Үр дүн 12. Зөрчлийн тухай хуулийн 6.18.7 дахь хэсэгт зааснаар шийтгэл хүлээсэн 7 хүний 6 нь өмнө нь мөн хуулийн 6.18.4 буюу биеэ үнэлсэн гэж 1-3 удаа шийтгүүлсэн бол 1 нь биеэ үнэлэхийг зохион байгуулах зөрчлийг давтан үйлджээ.

Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.18 дугаар зүйлд Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн талаар тухайлан зохицуулсан. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон үйлдэлд, 7 дахь хэсэгт өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан үйлдлийг зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Зураг 28. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Зөрчлийн тухай хуулийн 6.18.4, 6.18.7 дахь хэсэгт заасан зөрчлийн статистик мэдээлэл



Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн Зөрчлийн тухай хуулийн 6.18.4 дэх хэсэгт заасан зөрчлийн тоон мэдээллээс үзвэл нэг талаас энэ төрлийн зөрчлийн тоо буурах хандлагатай байна. Харин, биеэ үнэлэхийг зохион байгуулах үйлдлийг 2020 оны 01 дүгээр сард Эрүүгийн хуульд нэмэлтээр оруулж, гэмт хэрэгт тооцсоноос хойш 2020 онд 20 гэмт хэрэг бүртгэгдсэн нь 2019 онд бүртгэгдсэн зөрчлийн хэргээс буурсан үзүүлэлттэй байна. Энэ дээр дурдсанчлан цар тахлын нөхцөл байдлын улмаас үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаа хязгаарлагдсантай холбоотой гэж бид үзэв.

2022 онд Азийн сангийн захиалгаар ХТЭТ ТББ-ын судалгааны багийн хийж гүйцэтгэсэн “Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан”-д “...биеэ үнэлсэн зөрчил гаргасан 16 эмэгтэйг өөрийнхөө биеэ үнэлэн бэлгийн харьцаанд орсон зөрчил гаргасан гэж шийтгэл оногдуулсан атлаа тэдэнд төлбөр төлж бэлгийн харьцаанд орсон зөрчил гаргасан гэж зөвхөн “ганц” л эрэгтэйд шийтгэл оногдуулсан нь биеэ үнэлсэн хүнд хариуцлага хүлээлгэдэг, тэдний биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон хүнд хариуцлага тооцдоггүй байдал байгааг харуулж байна” гэжээ.

Зөрчлийн тухай хуулийн 6.18.7 дахь хэсэгт зааснаар шийтгэл хүлээсэн 7 хүний 6 нь өмнө нь мөн хуулийн 6.18.4 буюу биеэ үнэлсэн гэж 1-3 удаа шийтгүүлсэн бол 1 нь биеэ үнэлэхийг зохион байгуулах зөрчлийг давтан үйлджээ.

Эндээс ажиглагдаж буй нэг зүйл нь өмнө нь биеэ үнэлдэг байсан эмэгтэйчүүд хэсэг хугацааны дараа биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт үйлдлийг гаргаж байгааг холбогдох байгууллагууд анхааралдаа авч, урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль³⁰ /цаашид ЗШШТХ гэх/-ийн 6.6 дугаар зүйлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг дараах үндэслэл тогтоогдвол хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжийг бий болгосон байна. Үүнд:

1. Зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол;
2. Зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол;
3. Зөрчил үйлдсэн болох нь стандартаар баталгаажсан хэмжилт-хяналтын төхөөрөмжөөр нотлогдсон бол.

Аливаа гэмт хэрэг, зөрчлийг хуулийн боломжит хугацаанд, оролцогч талуудын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндөхгүйгээр шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчил гаргасан этгээдэд хуулийн тохирох хариуцлага хүлээлгэх нь зүйд нийцнэ. Гэхдээ бүх зөрчлийг, ялангуяа биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох зөрчил бүрийг хялбаршуулсан байдлаар шийдвэрлэх нь цаанаа хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг нуун далдлах нөхцөл байдал үүсгэж болзошгүйг хууль сахиулах байгууллага анхаарах шаардлагатай байна. Түүнчлэн хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны цаана зөрчил гаргасан эсэх нь баримтаар тогтоогдоогүй байхад нь хариуцлага хүлээлгэсэн байж болзошгүй хэд хэдэн мэдүүлгэн нотлох баримтууд зөрчлийн хэргийн материалд авагдсан байжээ³¹.

Зөрчлийг шалгах ажиллагааны хүрээнд зөрчил үйлдсэн этгээдээс тайлбар, мэдүүлэг авч байгаа боловч гаргасан үйлдэл нь хүн худалдаалах болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн шинжтэй байж болох эсэх талаар нарийвчлан асууж тодруулсан зүйлгүй байгаа нь анхаарал татаж байв.

Иймээс прокурорын байгууллагаас ЗШШТХ-ийн 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан прокуророос зөрчлийн хэрэг бүртгэлтэд тавих хяналтын чиг үүргээ, мөн хуулийн 2.3 дугаар зүйлд зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан хүлээлгэсэн бүрэн эрхийг, мөн хуулийн 2.4 дүгээр зүйлд зааснаар зөрчлийн хэрэг бүртгэгч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хэрэгжүүлэх бүрэн эрхээ хэрэгжүүлэх нь зөрчил гэж үзэж байгаа нөхцөл байдлын цаана ямар нэг гэмт хэрэг нуугдмал байдалтай оршиж буйг таслан зогсоох, илрүүлэх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх явдалд тустай юм.

³⁰ Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №24

³¹ Азийн сангийн захиалгаар Хүйсийн тэгш эрх төв ТББ-аас явуулсан Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан, УБ.,2022


1.2. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал /шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ/

Судалгааны ажлын зорилгын хүрээнд нийт шүүхээр Эрүүгийн хуулийн 12 бүлэг “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ээр шүүхээр эцэслэн хянан шийдвэрлэгдсэн 100 хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн. Эдгээр шийдвэрүүдийг хамаарах огноогоор нь авч үзвэл:

- 2018 онд шийдвэрлэсэн 10,
- 2019 онд шийдвэрлэсэн 20,
- 2020 онд шийдвэрлэсэн 30,
- 2021 онд шийдвэрлэсэн 40 шийтгэх тогтоол байна.

Нийт уншиж танилцсан 100 хэрэгт хамаарах 119 шүүгдэгчийн 89.0 хувь нь хүчиндэх гэмт хэрэгт, 1.68 хувь нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт, 9.2 хувь нь арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэгт шүүхээс ял шийтгүүлжээ.

Зураг 29. Судалгаанд ашигласан 100 хэрэгт хамаарах шүүгдэгчийн тоо



Үндэсний статистикийн хорооны 2020, 2021 оны мэдээлэлд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчдын насны байдлыг авч үзвэл:

Хүснэгт 16. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчдын насны байдал

	2020 онд нийт 366 холбогдогч: үүнээс	2021 онд нийт 417 холбогдогч: үүнээс
14-15 насны холбогдогч	13	13
16-17 насны холбогдогч	13	14
18-29 насны холбогдогч	177	205
30-39 насны холбогдогч	83	114
40-49 насны холбогдогч	50	53
50-59 насны холбогдогч	22	12
60 ба түүнээс дээш	8	6

Дээрх мэдээллээс харвал 2021 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт холбогдогчийн тоо 417 болж, өмнөх оноос 51 буюу 13.9 хувиар, 18-29 насныхан 28 буюу 15.8 хувиар, 30-39 насныхан 31 буюу 37.3 хувиар тус тус өссөн байна. Нийт холбогдогчдын 27 буюу 6.5 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байна.

Түүнчлэн 2020 онд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн 366 яллагдагчийн 294 буюу 80.3 хувь нь хүчиндэх, 14 буюу 3.8 хувь нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэгт, 2021 онд яллагдагчаар татагдсан 417 хүний 335 буюу 80.3 хувь нь хүчиндэх, 11 буюу 2.6 хувь нь бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэрэг яллагдагчаар татагджээ.

Хүснэгт 17. Шүүхээс оногдуулсан ялын хугацааны харьцуулалт

Он	2018				2019			2020				2021			
ЭХТА-н зүйл	12.1				12.1			12.1				12.1			
заалт	1	2	4	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	
Хорих ялын хугацаа	2 ж		1				1				2				
	3 ж		1		1			2							
	4 ж				3			1							
	5 ж				3	1		1	1	1				2	
	6 ж					1		2				4	2	1	
	7 ж									1		2			
	8 ж							1					1		
	10 ж					1				2					
	12 ж									3				6	
	13 ж			1						3				2	
	15 ж									2				4	
	16 ж			1			1							2	
	17 ж									1				2	
	18 ж									1				2	
	20 ж			2			2							2	
	Бүх насаар нь														2
Хэрэгсэхгүй болсон	1	1												1	

Хүснэгт 17-с харахад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэгт хамаарах 12.1 дүгээр зүйлд заасан зөвхөн хүчиндэх гэмт хэрэгт шүүхээс оногдуулсан ялын талаарх судалгаанаас үзвэл 12.1 дүгээр зүйлийн 12.1.1 дэх хэсэгт заасан үндсэн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт 2-5 жилийн, 12.1.2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт 2-8 жилийн, 12.1.3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт 5-10 жилийн, 12.1.4 дэх хэсэгт

заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт 5-20 жил хорих ял оногдуулсан байна. Харин судалгаанд харагдсан 2021 оны 12.1.4 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн 25 хүний 2 хүнд буюу 8% хувьд нь бүх насаар нь хорих шийтгэл оногдуулсан нь харагдаж байна..

Гэхдээ шүүх хэдийгээр хуульд заасан ялыг оногдуулж байгаа боловч шүүхийн оногдуулж буй ял “Хүний эрх, эрх чөлөөний баталгаа” болж чадаж уу гэдгийг:

- ✓ энэ хэрэг шийдвэрлэгдсэнээр хохирогч дахин хохирогч болохгүй байж чадах уу,
- ✓ оногдуулсан ялыг эдэлж дуусах үед хохирогч насанд хүрч, өөрийгөө хамгаалах чадвартай болсон байх уу /биеэ хамгаалах чадвартай болсон байх уу/,
- ✓ хохирогч бие даан амьдрах боломжтой болох хугацааг харгалзсан ялыг оногдуулж чадан эсэхээр ялын үр дүнг нь дүгнэж болохоор байна.

Жишээлбэл, 2019 оны 03 дугаар сарын 13-ны шөнө, 2019 оны 05 дугаар сарын 18-ны орой Дорнод аймгийн Хэрлэн сумын ... дугаар баг, Хэрлэнгийн ... тоот гэртээ өөрийн төрсөн охин болох 7 настай С.Б-ын бэлэг эрхтэнд хуруугаа хийж бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн гэмт хэргийг үйлдсэн гэж Г.С-ийг прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар зүйлчлэн ирүүлсэн. Шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хөнгөрүүлэн зүйлчилж, 6 жилийн хугацаагаар хорих ялыг оногдуулжээ. Эндээс “Нэг биш хоёр удаагийн завдалт байсан уу? гэсэн асуулт урган гарах юм.

Хүүхдийн бэлэг эрхтэнд нь хуруугаа хийх нь “хүчиндэх гэмт хэргийн үйлдлийн нэг болох хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсан шинж тогтоогдоогүй гэж үзэх үндэслэл, нотолгоо болно.” гэх үү? гэсэн “Зүйлчлэл хууль зүйн үндэслэлтэй юу гэсэн хууль тайлбарлах, хэрэглээ”-ний олон асуултыг дагуулж байна.

Энэ төрлийн гэмт хэрэгт хууль тогтоогч хүнд төрлийн хорих ялыг оногдуулахаар сонгох санкцигүй, хэмжээг нь хангалттай тогтоосон боловч оногдуулах ялыг хөнгөрүүлэх, хуульд заасан үгийн утга зүйн тайлбарыг махчлан хийх зэргээр ялыг хөнгөрүүлж байгаа нь анхаарал татаж байлаа.

Шүүхээс оногдуулж буй ял, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлж буй бас нэг шалтгаан нь хохирогч өгсөн өгсөн мэдүүлгээсээ буцах, өөрчлөх зэрэгтэй холбоотой байна. Судалгаанд хамрагдсан 100 хэргийн шийдвэрт дүн шинжилгээ хийж үзвэл 12 хэргийн зүйлчлэл өөрчлөгдсөнөөс 4 нь хохирогчийн мэдүүлэг өөрчлөгдсөнтэй холбоотой байжээ.

Шигтгээ 21. ...471 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Шүүх Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 -д заасан "... Хүчиндэх гэмт хэргийн 14-өөс 18 насанд хүрээгүй хүнийг хүчиндэж үйлдсэн" гэсэн хүнд гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 12.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох" гэмт хэргээр хөнгөрүүлэн шийдвэрлэсэн үндэслэлээ: "...хохирогч нь дээрх хүмүүстэй өөрийн хүслээр, зөвшөөрч хурьцал үйлдсэн, төрсөн эхээсээ айгаад хүчиндсэн гэж худал хэлсэн, эдгээр хүмүүсийн зүгээс хүч хэрэглэсэн, заналхийлсэн, айлган сүрдүүлсэн зүйлгүй талаар зарим мэдүүлэгтээ дурдсан нь шүүгдэгчдийн энэхүү үйл явдлын тухай анхнаасаа эхлэн тогтвортой мэдүүлсэнтэй тохирдогос гадна жирэмсэн болсон нь илэрхий болтол Б цагдаагийн байгууллагад гомдол гаргаагүй, энэ тухай гэр бүлийнхэн болон ойр дотны хэнд ч хэлээгүй зэргийг харгалзан хөнгөрүүлэн зүйлчлэх нь зүйтэй байна. " гэж шийдвэрлэжээ.

Шигтгээ 22.. 19...982 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

О.Х нь 2017 оны 9 дүгээр сараас 10 дугаар сарын хугацаанд Сүхбаатар дүүргийн 1 дугаар хороо, ... байрны ... тоотод, 2019 оны 3 дугаар сард Чингэлтэй дүүргийн ... хороо, .. дугаар гудамжны 3 тоотод эхнэрийнхээ төрсөн эгчийн охин М-ын хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эд хөрөнгө бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харилцаанд орсон, бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийх гэмт хэргийг гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн.

Хохирогч шүүхэд гаргасан мэдүүлэгтээ: - Энэ хүнд гомдолгүй. 2 хүүхэд болоод эхнэр нь мөнгөгүй, цаашдын амьдрал нь хэцүү болсон тул өршөөнө үү.

Шүүгдэгч О.Х-ийн эхнэр нь гараа зүсэж амиа хорлохыг завдаж, биедээ гэмтэл учруулж эмнэлэгт хэвтсэнээр цагдаад мэдээлэгдсэн.

Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нар шүүх хуралдаанд оролцож, шүүгдэгчтэй нүүр тулгарахаас зайлсхийдэг. Энэ нь хохирогч оролцуулах хүсэлтээр шүүх хуралдаан олон удаа хойшлох, хохирогч нар мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлгээсээ буцах шууд нөхцөл болдог байна.

Иймд хохирогчоос олон дахин мэдүүлэг авахгүй байх, насанд хүрээгүй хохирогчийг эрх зүйн хамгаалалтыг нь сайжруулах хуулийн зохицуулалтыг ЭХХШТХ-д зааж өгөх хэрэгтэй байна. Тухайлбал, хохирогчийн мэдүүлгийг нэг удаа хэргийн оролцогчдын урьдчилан бэлдсэн асуултын хүрээнд бүрэн авах, хохирогч хүүхдийн насны онцлогийг харгалзан жишиг асуултыг боловсруулах, зөвхөн гэмт хэргийн зүйлчлэлийг заасан (бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал нь хохирсон) гэмт хэргийн насанд хүрээгүй хохирогчоос авах мэдүүлгийн ажиллагааг эрүүгийн хэрэг үүсгэсний дараа, эсхүл хэргийг

шүүхэд шилжүүлэхийн өмнөх шатанд нэг удаа авах гэх мэт зохицуулалтууд шаардлагатай байна.

Үр дүн 13. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэгдэж буй гэмт хэргийн дийлэнх нь нь үргэлжилж үйлдэгдсэн, урт хугацааны дараа илэрсэн байна. Судалгаанд хамрагдсан гэмт хэргийн 80 гаруй хувь нь хоёр ба түүнээс дээш удаагийн үйлдэлтэй, 51 хувь нь цаг хугацааны хувьд үргэлжилсэн үйлдэлтэй байна. Хамгийн урт хугацааны турш үйлдэгдсэн гэмт хэрэг нь 7 жил байжээ.


Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал нь зөрчигдсөн гэмт хэргийн:

- 51% нь цаг хугацааны хувьд үргэлжилсэн үйлдэлтэй
- 8% нь хоёроос дээш дөрөв хүртэлх хохирогчийн давтан үйлдэлтэй
- 18% нь хохирогч жирэмсэлж, ураг томорсны дараа мэдэгдэж мэдээлэгджээ.

Зураг 30. Гэмт хэргийн үргэлжилсэн хугацааны харьцуулалт



Зураг 31. Гэмт хэрэг үргэлжилсэн давтамж




Дээрх мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэг нууц далд бөгөөд ихэнхдээ олон удаагийн давтамж, урт хугацааны дараа илэрдэг болох нь харагдаж байна. Тодруулбал 2 ба түүнээс дээш удаагийн үйлдэлтэй, 7 жил хүртэл хугацаагаар үргэлжилсэн гэмт хэрэг нь судалгаанд хамрагдсан хэргийн 51% нь цаг хугацааны хувьд үргэлжилсэн үйлдэлтэй байгаагаас харж болох юм.

Шигтгээ 23. 18...175 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос...

М.Н нь 2017 оны 04 дүгээр сард Увс аймгийн Завхан сумын ... дүгээр багт бага насны О-г 14 нас хүрээгүй байхад нь хүчиндсэн, 2018 оны 02 дугаар сард мөн газарт Х-г 16 насанд хүрээгүй байхад нь хүчиндэхийг завдсан. М.Н нь авга ах нь ба өвөөтэй нь архи хамт уугаад өвөө нь согтоод унтсан. Шөнө дунд хүчээр хувцсыг нь тайлж хүчиндсэн. 2018 оны Эмнэлгийн ажлын төлөвлөгөөний дагуу 8-9 ангийн охидод бэлгийн боловсрол олгох ажлын үеэр хийсэн эмчийн үзлэгээр “..Охин хальс нь гэмтсэн...” болохыг тогтоож, цагдаад мэдээлсэн.

Зураг 32. Гэмт хэргийн талаарх анхны гомдол, мэдээллийг гаргасан зарим эх сурвалж



Шигтгээ 24. 19...914 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Хохирогч Т-ийн ангийн хүүхэд М, Э нар:-“...Т нь 7 дугаар ангиас хойш юм бодоод гөлрөөд суучихдаг болсон. Заримдаа би хөөе наад хичээлээ хийгээч гэхээр үгэнд ордог. Нэг удаа ширээ дэрлэж суугаад байхаар нь яасан бэ гэхэд бид хоёрыг ангиас гаръя гэж цуг гараад “...2016, 2017 оны зун манай жинхэнэ аавын эгчийнх нь эрэгтэй хүүхэд намайг хүчиндсэн. Зуны амралтаар очих болгонд олон удаа хүчиндсэн. ...” гэсэн. Ээждээ хэлээч гэхэд ээж аав хоёр маргалдсан байгаа, салчихвал яах юм, бүх зүйл надаас болсон гээд нөгөө хүнийг зүгээр өнгөрөөчихвөл яах юм гээд уйлаад байсан...” гэж хэрэгт гэрчээр мэдүүлэг өгсөн байна.

Шигтгээ 25. 19...052 дугаартай эрүүгийн хэргээс


Насанд хүрээгүй хохирогч Г нь: "...ээж, аав, дүү нар ургийн баярт явцгаасан. ...аавын дүүгийн хүүхэд Н.М нь намайг өдрийн хоол хийж байхад тэвэрч авч үнсээд, ор руу дөхүүлээд дээрээс дараад авсан. Би болиочээ гэж өшиглөж, цохиж эсэргүүцсэн боловч дийлээгүй. ... 2017 оны 10 сард нь би жирэмсэн болсон гэдгээ мэдсэн. ...Энэ явдлыг ах дүүс болон нутгийн хүмүүс мэдэж болохгүй гэж явсаар хүүхэд том болсон..."

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч Х.Г нь (гэр бүл, хүүхэд залуучуудын газрын мэргэжилтэн): "...хэрэг болсны дараа хохирогчтой уулзах гэхэд Улаанбаатар хотод хичээл эхэлсэн байна гээд ирэхгүй, ярихгүй болсон. ...",
Гэрч М.Ц нь: - "...эмч нарын зөвлөгөөний хурлаар оруулж, хожуу хугацаанд эмийн аргаар үр хөндөх шийдвэр гаргасан. ...зулбуулах эмийн 4 тун /бүрэн тун/ өгч ургийг эхсийн хамт зулбуулан гаргаж, умайн хөндийг багаж ашиглан цэвэрлэсэн. ..." гэжээ.

Эндээс харвал энэ төрлийн гэмт хэргийн талаар хамгийн анх мэдэх боломжтой субъект нь тухайн хохирогчийн эх (төрсөн, үрчилж авсан, хойд...) болон эмнэлгийн мэргэжилтэн байх боломжтой байна. Түүнчлэн сургуулийн орчноос энэ төрлийн гэмт хэргийн талаарх мэдээллийг хохирогчийн багш, нийгмийн ажилтан эсхүл найз нөхөд нь мэдээлэх явдал байдаг бөгөөд энэ тохиолдолд хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зайлшгүй шаардлага үүсдэг болох нь зарим хавтаст хэргийн материал болон шүүгч нартай хийсэн ярилцлагын үр дүнд дурдагдсан байна.

Үр дүн 14. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон хохирогчдын нэхэмжилсэн иргэний нэхэмжлэлийг Иргэний болон ИХШХШ тухай хуульд зааснаар нэхэмжлэх эрхийг нээлттэйгээр үлдээн шийдвэрлэж байгаа нь хохирогчид ээлгүй тогтолцоо өнөөг хүртэл байсаар байгааг илтгэж байна.

Зураг 33. Хохирлоо төлүүлэх талаар Иргэний шүүхэд хандахгүй байгаа хохирогчийн шалтгаан нөхцөл




Иргэний хуульд "...гагцхүү хуульд заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхөөр³², хохирогч "...гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах..."³³ эрхтэй гэж заажээ.

Хохирогчийн хохирлоо гаргуулна гэсэн шаардлага бүхий иргэний нэхэмжлэлийг шүүх үндэслэл, хохирол хор уршгийн хэр хэмжээний нотлогдсон байдлыг харгалзан шийдвэрлэдэг³⁴ тул нотлох баримтгүй нэхэмжилж буй хохирлыг иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар нэхэмжлэлээ гаргах эрхтэй болохыг нь зааж шийдвэрлэж байна.

Судалгаанд оролцсон бүх шүүгч нар хохирогчийн сэтгэл санааны болон бие эрхтний хохирлоо нотлох баримтаа бүрдүүлэн иргэний шүүхээр жич шийдвэрлүүлэх эрхийг нь нээлттэй үлдээдэг гэж байгаа боловч судалсан шүүхийн шийдвэрийн 81 хувьд нь жич нэхэмжлэх эрхтэй болохыг заасан байна.

Зураг 34. Хохирогчийн сэтгэл санааны болон бие эрхтний хохирлоо нотлох баримтаа бүрдүүлэн иргэний шүүхээр жич шийдвэрлүүлэх эрхийг нээлттэй үлдээж шийдвэрлэсэн байдал.



Хүчирхийлэлд өртсөн, айдастай байдаг, бусдад мэдэгдэхгүй байх шаардлага байдаг гэсэн энэ төрийн гэмт хэргийн хохирогчийн онцлогийг харгалзан сэтгэл заслын эмчилгээ, бие махбодын эмчилгээний наад захын зардлыг урьдчилан тогтоож, жишиг үнэлгээг гаргах боломжтой ба энэхүү жишиг үнэлгээнд заасан хэмжээгээр хохирлыг гаргуулж шийдвэрлэх боломжтой. Ингэхгүй бол бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн хэргийн хохирогч бусад төрлийн гэмт хэрэг шиг гэмтлээ эмчлүүлэхэд гарсан зардал, оршуулгын зардал, эд хөрөнгийн хохирол гэх зэргээр мөнгөн дүнгээр тооцон нэхэмжлэл гаргах, нотлох баримт бүрдүүлэх боломжгүй ба энэ төрлийн гэмт хэргийг үйлдэгчид хохирол төлөхгүй ял завшиж, ял хөнгөрүүлэх боломжийг эдэлсээр байна. Иймд:

- хохирлын баримтыг хэрхэн бүрдүүлдэг,
- мөнгөн дүнгээр үнэлэн нэхэмжлэх боломжтой ямар ямар хохирогчид үзүүлэх эмнэлгийн болон сэтгэл зүйн үйлчилгээ байдаг,
- дээрх үйлчилгээг хэн, ямар төлбөртэйгөөр явуулдаг,

³² Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2 дахь хэсэг. 2002 он

³³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.9 дүгээр заалт. 2017 он.

³⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг. 2017 он.

- санхүүгийн асуудлыг нь шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх ямар эс сурвалжууд байж болох /байгууллага, сан/ зэргийг багтаасан гарын авлага, мэдээлэл авах боломжтой зурагт хуудас зэргийг хүүхдийн очиж болох газрууд (сургууль, нийтийн тээвэр, сүлжээ дэлгүүр)-д хүртээмжтэйгээр түгээх ажлыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Үр дүн 15. Хохирогчийн хохирол, хор уршгаа нэхэмжлэх эрхийг “...жич иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй...” гэсэн хэвшмэл өгүүлбэрээр бус “Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна” гэсэн³⁵ хуулийн шаардлагад нийцсэн байдлаар бичигдэх шаардлагатай байна.

Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид цаашид нь урьдчилан тааварлах аргагүй хор уршгууд үлддэг. Үүнийг харгалзан тухайн гэмт хэргээс үүдэлтэй хор уршгаа цаг хугацаа өнгөрснөөс үл хамааран гэм буруутай этгээдээс нэхэмжлэх хохирогчийн эрхийг шүүхийн шийдвэрт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “...Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна. ...” гэж заасан шаардлагад нийцэхээр бичиж, зааж байх нь чухал ач холбогдолтой.

Бэлгийн замын халдварт өвчин халдааж үйлдсэн гэмт хэргийг үйлдсэнийг гэмт хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэх шинж болгож хууль тогтоогч зааж ялыг оногдуулж байгаа боловч энэ өвчнөөр гэмт хэргийн хохирогч болсныхоо хувьд өвчлөн үлдэж буй хохирогчийн хохирлыг хэрхэх, яаж энэ хохирлыг тооцож арилгуулах талаар эрх зүйн зохицуулалт өнөөдрийг хүртэл байхгүй л байна.

Тухайлбал, Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас хохирогч жирэмсэн болох нь цөөнгүй байна. Энэ тохиолдолд жирэмслэлтийг таслах шаардлага үүсдэг. Практикт үр хөндөх, зулбуулах аргыг хэрэглэдэг. Хэдийгээр манай улсад “...Бэлгийн хүчирхийлэлд өртөж жирэмсэлсэн бол...” үр хөндөлтийг зохих журмын дагуу хийхийг зөвшөөрдөг³⁶ боловч хохирогчид үлдэх хор уршгийг тооцох, мэдэх боломжгүй юм.


Үр хөндөлтөөс шалтгаантайгаар хохирогчийн умайн хэсэг гэмтэх, умай цоорох хүндрэлээс шалтгаантайгаар дахин хүүхэд чадахгүй болох дахин жирэмслэхгүй болох хүртэл хор уршиг үлддэг ба энэ нь хожим илэрдэг хор уршиг юм. Судалгаанд хамрагдсан 100 хэргийн 12 хохирогч нь жирэмсэлсэн, үүнээс 12 настай 1, 14 настай 4, 15 настай 4, хохирогч тус тус үр хөндүүлсэн байна. 12 хохирогч насанд хүрээгүй буюу хүүхэд байхдаа жирэмсэлсэн. 6 долоо хоногтой /1 сар гарантай/ -оос 7 сартай ургийг үр хөндүүлж, 3 хохирогч

³⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг

³⁶ 2019 оны А/387 дугаар Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын тушаал

нь хүүхдээ төрүүлсэн байна.

Зураг 35. Хохирогчийн үр хөндүүлсэн байдал



ДЭМБ-ийн хийсэн судалгаагаар дэлхийд жилд 40-50 сая, өдөрт 125000 үр хөндөлт хийгдэж байна. Үүний 20-40% нь хоёрдогч үргүйдэлтэй болно гэж бодохоор үргүйдлийн асуудал өнөөдөр дэлхий нийтийн тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Америкийн судлаач эмч нарын судалгаагаар эмийн болон мэс ажилбараар үр хөндөлт хийлгэсэн эмэгтэйчүүдэд дараагийн жирэмслэлт нь умайн гаднах жирэмсэн болох магадлал 2.3-2.4%, зулбах эрсдэл 12.2-12.7%-тай байна гэсэн судалгаа гарчээ.³⁷

Түүнчлэн, төрсөн эцэг нь охиноо, ойрын төрөл саднаа хүчиндэж жирэмсэн болгосон, улмаар төрж хүүхдээ бусдад үрчлүүлсэн үйл баримт ч байна. Энэ тохиолдолд төрсөн хүүхдийн генийн өөрчлөлт, удмын өвчлөлийн асуудал зайлшгүй хөндөгдөнө.

Шигтгээ 26. 19...189 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Т.Ж нь 2019 оны 9 дүгээр сард Ховд аймгийн Ховд сумын ... багийн нутагт байрлах иргэн М-н нэг өрөө бүхий байшинд тухайн үед 13 нас 6 сартай байсан, төрөл садны холбоотой буюу үеэл дүү Х-тай бэлгийн харьцаанд орж, жирэмсэн болгосон. Хохирогч Х-г 7 сартай жирэмсэн болсон хойно нь мэдсэн. Хүүхдийг төрүүлээд хүнд үрчлүүлсэн. Хүүхдэд хийсэн ДНХ-ийн шинжилгээгээр Т.Ж 99,99% магадлалтайгаар биологийн эцэг байх магадлалтай гэсэн дүгнэлт гарсан. Хохирогч Х нь хүүхдээ төрүүлээд өөр аймгийн хүүхэдгүй гэр бүлд үрчлүүлжээ.

Шигтгээ 27.. Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Дахин жирэмслэхгүй байх, бэлгийн дур хүсэл нь эрт өдөөгдөх, бэлгийн дур хүсэлгүй болох, эсрэг хүйстнээ үзэн ядах, айдас, сэтгэл гутрал гэх мэт хор уршгууд хохирогчид үлддэг.

Мөн хохирогчийн сэтгэл зүй хэвийн бус байдлаар гэмтдэг ба айдас, хүчирхийллийн ул мөр хохирогчид яаж үлдэх, амьдралд нь хэрхэн нөлөөлөх

³⁷ <http://www.ase.mn/Default.aspx?page=36&news=220>

талаар мэргэжлийн судлаач, сэтгэл зүйч нараар шинжилгээ хийлгэх эрх зүйн зохицуулалтыг эрх зүйн хүрээнд шийдвэрлэх шаардлагатай байна. Сэтгэц эмгэг судлалын эмч нараар шинжээчийн дүгнэлт гаргуулснаар энэ асуудлыг бүрэн төгс шийдвэрлэж чадахгүй юм.

Шигтгээ 28.. 19...405 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Э.Т нь 2017 оны 12-р сар, мөн 2018 оны 01, 02 саруудад удаа дараа насанд хүрээгүй буюу 16 настай Ц-ийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэн хүчиндэж, улмаар жирэмсэн болгосон. Хохирогч гэрээсээ оргож, амиа хорлохоор шуугаа зүсэж байсан болох нь гэрчийн мэдүүлэг болон 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон. Хохирогчийнх айлын хашаанд амьдардаг ба ээж нь нас барсан, аав нь гадуур явж ажил хийн, өдөртөө дүү нараа харж байдаг байсан. Хохирогч Ц: "...Жирэмсэн болсонг нь хамаатных нь эгч Б мэдээд аймаг орж, үр хөндүүлсэн. Эгч Б нь Э.Т-ээс мөнгө нэхэж аваад байдаг, сургууль дээр жирэмсэн болсныг хүүхдүүд мэдээд яриад бсан тул гарын шуугаа зүссэн. ..." гэж мэдүүлсэн.

Энэ мэтээр хохирогчийн мэдээллийн нууцлал алдагдсанаас амиа хорлохыг оролдох, амиа хорлох, нэр төр гутаагдах, сургуулиасаа гарах, сургууль шилжих, гэр орноосоо дайжих гэх мэт эрсдэл гардаг байна.

Шигтгээ 29. . 20...231 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Б.Б нь 2020 оны 8 дугаар сарын 22-ны өдөр 15 цагийн үед Сонгинохайрхан дүүргийн .. дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах амбаарт бага насны хүүхэд болох б настай Э-н хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй байдлыг нь далимдуулан хүчээр өөрийнхөө бэлэг эрхтнийг бага насны хүүхэд Э-бэлэг эрхтэнд оруулах байдлаар бэлгийн харьцаанд орсон

Шүүх сэтгэц эмгэг судлалын шинжээчийн дүгнэлт: "...Э нь сэтгэцийн ямар нэгэн өвчин үгүй байна. Харин болсон хэрэгтэй холбоотой сонгомол дуугайрах хариу урвалтай байна. Э нь хүчирхийллийн дараах дарамтад эмгэггүй байна. Одоо илэрч байгаа сонгомол дуугайрах хариу урвал нь таагүй, сөрөг үйл явдалд үзүүлж буй сэтгэлзүйн түр зуурын хэвийн хариу урвал юм. Одоо илэрч буй сонгомол дуугайрах хариу урвал нь цаашид хэрхэн сэтгэлзүйд нөлөөлөхийг одоогоор тогтоох боломжгүй. Учир нь, цаашидын үр дүн нь тухайн сөрөг үйл явдлын үргэлжлэх хугацаа, хүч, шийдэгдсэн байдал, ар гэрийнхний дэмжлэг болон тухайн хүүхдийн стрессийг даван туулах чадвараас хамаардаг болно."

АНУ-ын Оклохома мужид гэхэд гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд нэг бүрт 50 цагийн сэтгэл зүй, сэтгэл заслын 50 цагийн сургалтыг явуулдаг байна³⁸.

Гэтэл манай улсад ийм сэтгэл зүйн гэмтэл хохирогчид байгаа талаар дүгнэлт гаргаж байгаа ч энэ гэмтлийг эмчлэхэд ямар төрлийн эмчилгээг хийх,

³⁸ www.fcsok.org

хэдий хугацаанд үзүүлэх талаар зөвлөмж гаргахгүй байгаа тул дүгнэлтийн нэг хэсэг болгож энэ талаар шинжээчийн дүгнэлтийг заавал гаргуулж байх хэрэгтэй байна.


Түүнчлэн, бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдал нь цаг бусын шалтгаанаар зөрчигдсөн хохирогч бэлгийн замын халдварт өвчинтэйгөөр насанд ту ршдаа үлдэх /тэмбүү, ДОХ/ эрсдэл ч байдаг байна.

Үр дүн 16. Эрүүгийн хуулиар эрэгтэй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах боломжийг бий болгосон. 2021 онд шүүхээр шийдвэрлэсэн хэрэгт 46 хүн хохирогчоор тогтоогдсоны 6 нь эрэгтэй хүн байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, түүн дотроо хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсийн хүн байж болохоор зохицуулсан нь хүний эрхийг хангасан, дэвшилтэд зохицуулалт болсон.

Сүүлийн үед эрэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд цөөнгүй үйлдэгдэх болжээ. Тухайлбал 2021 онд шүүхээр шийдэрлэгдсэн энэ төрлийн гэмт хэрэгт 46 хүн хохирогчоор тогтоогдсоны 6 нь эрэгтэй хүйсийн хүн байжээ.

Зураг 36. 2021 онд шийдвэрлэгдсэн хэргийн 46 хохирогчийн хүйсийн харьцаа



Эрэгтэй хүний шулуун гэдсэнд нь бэлэг эрхтэн, хуруугаа оруулах зэргээр хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл хийж, бэлгийн дур хүслээ хангасан шүүгдэгч нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлд заасан “Хүчиндэх” гэмт хэргээр гэм буруутайд тооцож шийдвэрлэжээ.

Дээр дурдсан 6 хэргийг авч үзвэл: эрүүгийн 180..009 дугаартай хэрэгт 6 настай эрэгтэй, 200...238 дугаартай хэрэгт 11 настай эрэгтэй, 210...471 дугаартай хэрэгт 5 болон 6 настай эрэгтэй, 200...237 дугаартай хэрэгт 12 настай эрэгтэй хүүхдийн шулуун гэдсэнд бэлэг эрхтнээ оруулж хүчиндсэн, 200...537 дугаартай хэрэгт 13 настай эрэгтэй хүүхдийг эмэгтэй хүн хүчиндсэн тохиолдол байна.

Олон жил энэ төрлийн гэмт хэргийн хохирогч нь зөвхөн эмэгтэй хүн байх ёстой гэсэн үзэл хандлага нь өнөөдрийг хүртэл өөрчлөгдөхгүй, эрэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөөнд халдах боломжгүй мэтээр ойлгох хандлагатай байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг мэдээлэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна гэж судалгааны баг үзэж байна.

Үндэсний статистикийн хорооны гэмт хэргийн 2020 оны мэдээлэлд энэ төрлийн гэмт хэрэгт 502 хүн хохирогчоор тогтоогдсоноос 398 буюу 79.3 хувь нь эмэгтэй, 104 буюу 21.6 хувь нь эрэгтэй, 2021 онд 554 хүн хохирогчоор тогтоогдсоноос 536 буюу 96.8 хувь нь эмэгтэй, 18 буюу 3.1 хувь нь эрэгтэй хүн байна³⁹.

Шигтгээ 30. 21...471 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

О.Э нь 5 настай, эрэгтэй Л-г 2019 оны 04 дүгээр сараас 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл удаа дараагийн үйлдлээр бэлэг эрхтнээ хөхүүлж, шулуун гэдсээр бэлгийн харьцаанд орсон, бэлгийн харьцаанд орохдоо шулуун гэдэсний салстад язрал бүхий хөнгөн хохирол санаатай учруулсан, мөн 6 настай, эрэгтэй С-ийг 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл удаа дараагийн үйлдлээр бэлэг эрхтнээ хөхүүлж, шулуун гэдсээр бэлгийн харьцаанд орж хүчиндсэн.

Бага насны хохирогч С нь уйлаад сууж байхыг харсан багш нь учрыг лавласнаар олж мэдсэн.

Иймд насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг илрүүлэх бүхий л ажиллагааг хүйс харгалзахгүй хийх шаардлага үүсч байна

Үр дүн 17. ГБХЗХГ-ын мэргэжилтнүүд хууль ёсны төлөөлөгчөөр оролцсон байгаа ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоход гарсан зардлыг нэхэмжилсэн практик байхгүй байна. Зөвхөн 10% нь л тус байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон өмгөөлөгчийн хөлсийг л нэхэмжилжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид төлөх зардлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд оруулан шүүгдэгчээс гаргуулах талаар заасан байхад төрийн байгууллага болох Гэр бүл, хүүхэд хөгжлийн газар нотлох баримтаа бүрдүүлэн шүүхээр шийдвэрлүүлж, гаргасан зардлыг эргээн төсөвт төвлөрүүлж байх хэрэгтэй. Ингэснээр хохирогч хамгааллын эргэн төлөгддөг эргэх харилцаа төсөвт бий болно.

³⁹ https://www2.1212.mn/Stat.aspx?LIST_ID=976_L23&type=sectorbook

Шигтгээ 31. 19...489 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгчөөс шүүх хуралдаанд: - "...Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас насанд хүрээгүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэхээр өмгөөлөгч Д.Б-г 1,000,000 төгрөгийн хөлсөөр ажиллуулсан /1 хх 234-235/. Энэ зардлыг нэхэмжилнэ. ..." гэв. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардалд хохирогчийн өмгөөлөгчид төлөх зардал багтаж байх тул нэхэмжлэлийг хангах үндэслэлтэй байна. Иймд шүүгдэгч Г.Э-ээс 1,000,000 төгрөгийг гаргаж ГБХЗХГ-т олгохоор шийдвэрлэв.

Шигтгээ 32. 18...129 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Л.Н нь 2018 оны 04 дүгээр сард Орхон аймагт 16 настай А-г хүчиндэж, уг үйлдлийн улмаас насанд хүрээгүй хохирогч жирэмсэн болсон. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хууль ёсны төлөөлөгчөөр оролцож, тус газраас өмгөөлөгч авсан боловч эрүүгий хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зардал нэхэмжлээгүй.

Шигтгээ 33. Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Өмгөөлөгчийн хөлсийг ихэвчлэн гаргуулж байна.Цөөн хэрэгт эмчилгээнд зарцуулсан баримт байвал гаргуулж байна.

Үр дүн 18. Хохирогчийг хамгаалах байранд хамгаалалтад байлгах, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай эмнэлгийн үзлэгийг хийлгэх зэргээр "Хүчирхийллийн эсрэг үндэсний төв", "Хөөрхөн зүрх" зэрэг төрийн бус байгууллагууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцжээ.

Төрийн байгууллагуудын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагууд гүйцэтгэж болдог тул хохирогчийн эрх, бие махбодын хамгаалал руу чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудыг тодорхой хэмжээгээр санхүүжүүлж үйл ажиллагааг нь дэмжих ажлыг хийх нь зүйтэй байна.

Шигтгээ 34. 17...139 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

ГБХЗХГ-аас хууль ёсны төлөөлөгчөөр, ээжийнх нь хамт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон. Хохиролд:-Хохирогчийн аюулгүй байдал, хамгаалалтын үйлчилгээний зардалд 3.657.650 төг, эмчилгээ бусад зардалд 5.651.950 төг, өмгөөлөгчийн төлбөр 1 сая нийт 10.219.600 төг нэхэмжилсэн.

Анхан шатны шүүх: -шүүгдэгч Х.Б-ээс 10.219.600 төгрөг гаргуулж Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар хохирогч О, түүний эх Ш нарт 5.651.950 төгрөг, “Хүчирхийллийн эсрэг үндэсний төв” ТББ-д 3.567.650 төгрөг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1.1-т зааснаар бага насны хохирогчийн өмгөөлөгч С.Б, Б.А нарт 1.000.000 төгрөг тус тус олгуулахаар шийдвэрлэсэн.

Шигтгээ 35. Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Цаг хугацаанд хавчигдсан, хэрэгтээ дарагдсан сэтгэлээр хандахгүй л байх хэрэгтэй. Юу юуг нэхэмжилж болох вэ, ямар баримт бүрдүүлэх вэ гэх мэт ойлгомжтой зурагт хуудас, мэдээллийг цагдаа, прокурор, өмгөөлөх байгууллага, хүүхдийн байгууллага дээрээ байлгаж болж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалан ЭХХША-д оролцдог ТББ-уудын сайн үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хохирогчийг орон байраар ханган хамгаалах, сэтгэл зүйн зохих эмчилгээг хийх зэрэг ажиллагааг нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын сангаас санхүүжүүлэх, шүүхийн шийдвэрээр татан буцаан төвлөрүүлэх зэрэг ажлуудыг хийж болохоор байна.

Үр дүн 19. Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд нь бага насны (14 нас хүртэл), арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдэгдсэн гэсэн хохирогчийн наснаас хамаарч хүндрүүлэх шинжээр зүйлчлэгдэж шийдвэрлэгдэж байна.

Шүүхээс хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийг хүндрүүлэх шинжээр нь зүйлчлэгдэхэд шүүгдэгчид оногдуулах ялын төрөл, хэмжээ хүндэрдэг тул хохирогчийн насыг андуурсан, харагдах байдлаар насыг нь андуурахаар байсан гэсэн мэдүүлгүүдийг өгч, хохирогчийн өөрийн нь хэлсэн үг өгүүлбэр, харилцан бичсэн мессеж, фейсбүүкийн харилцсан бичлэг (чат) зэргийг нотлох баримт болгон ашиглах явдлууд байдаг.

Гэвч шүүхээс хохирогчийн гадна харагдах байдал, өсөлт зэргийг дурдаж, энэ төрлийн гэмт хэргийн зүйлчлэлийг өөрчлөхөд нөлөөлсөн шийдвэрүүдийг гаргасан нь учир дутагдалтай гэж судалгааны баг үзэж байна. Өөрөөр хэлбэл хохирогчийн гадна харагдах байдал, насны андуурал нь гэмт хэргийг үгүйсгэх, гэмт хэрэгт оногдуулах ялыг хөнгөрүүлж үзэх нөхцөл байдал биш юм.

Дээр дурдсан үндэслэлээр хөнгөрүүлж шийдвэрлэсэн 12 хэргийн 3 нь нас төөрөгдсөн үндэслэлээр зүйлчлэл өөрчлөгдсөн байна.

Хүснэгт 18. 19...052 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Н.М нь 2017 оны 08 дугаар сард Өвөрхангай аймгийн Б суманд оршин суух Ц-н гэрт бага насны буюу 13 нас 11 сар 20 хоногтой Г-г хүч хэрэглэж хүчиндсэн.

Хүчиндэх гэмт хэргийн хувьд хохирогч нь бага насны, эсхүл өсвөр настай эсэхээс шалтгаалж өөр өөр хууль зүйн үр дагавар үүсгэдэг бөгөөд хохирогчийн биеийн өсөлт хөгжил, ажил сургууль, зан харьцаа, биеэ авч яваа байдал зэрэг хувь хүний онцлог шинжүүдийг сайтар шалгаж тогтоосны эцэст хууль зүйн зөв дүгнэлт хийх шаардлагатай болно.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хүчиндэх гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн байхын тулд шүүгдэгч хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хурьцал үйлдэж буйгаа ухамсарлан ойлгохоос гадна хохирогч нь бага насны буюу 14 насанд хүрээгүй гэдгийг лавтай сайн мэдсэн байвал зохино. Хохирогчийн насны талаар төөрөгдсөн нөхцөл байдал нь шүүгдэгчийн гэм буруугийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлд тооцогдох тул энэ төөрөгдөл нь хохирогчийн биеийн өсөлт хөгжил, өөрийн насны талаар ярьж хэлсэн байдал зэрэг хохирогчийн зүгээс илэрхийлэгдэх нөхцөл байдлаас гадна шүүгдэгчийн хувьд хохирогчийн насны байдлыг бодитой зөв ухамсарлан хүлээж авах чадварын түвшингээс хамааран зарим онцгой тохиолдолд үүсэж болно.

Тухайн үед хохирогчийн биеэ авч яваа байдал, зан харьцаа, биеийн өсөлт, хөгжил зэрэг нөхцөл байдлаас дүгнэхэд хохирогчийг 14 нас хүрээгүй буюу бага насны гэдгийг шүүгдэгч Н.М лавтай сайн ухамсарлан мэдэж байсан, эсхүл мэдэж болох байсан гэх байдал эргэлзээтэй, хангалттай нотлогдоогүй буюу хохирогчийн насны талаар бодитой төөрөлдсөн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдож байна.

Иймд шүүгдэгч Н.М нь хохирогч Г-г бага насны буюу 14 насанд хүрээгүй болохыг баттай мэдсэн байх нөхцөл үгүйсгэгдэж байх боловч тэрээр хохирогчийг 16 насанд хүрээгүй болохыг мэдсэн, мэдэх боломжтой байсан тул түүний хэргийн зүйлчлэлийг "... гэр бүлийн хамаарал бүхий арван зургаан насанд хүрээгүй хүнийг хүчиндсэн" буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хөнгөрүүлэн зүйлчилж, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэн тогтоох нь зүйтэй.

Шигтгээ 36. 20...528 дугаартай эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолоос

Ч.Г нь 2017 оны 03 дугаар сарын 10-наас 11-нд шилжих шөнө Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Дрим” нэртэй зочид буудлын 44 тоот өрөөнд бага насны буюу 13 нас 11 сар 24 хоногтой хохирогч У-г согтуурсан үед нь хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэн хүчиндсэн, Я.Б нь 2017 оны 03 дугаар сарын 11-ний өдөр мөн зочид буудлын 44 тоот өрөөнд бага насны хохирогч У-г эд хөрөнгийн улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчиндсэн.

Хэрэг үйлдэгдсэн 2017 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хохирогч У-г таних болсон шүүгдэгч нар хохирогчийг 16 настай гэж эндүүрсэн болох нь цуг явсан У-тай цуг тус зочид буудалд ирсэн найз Б болон хохирогчийн өөрөө өөрийнх нь, шүүгдэгч нарын 16 настай гэж өөрийгөө танилцуулсан талаарх мэдүүлгүүдээр нотлогдож байх тул Ч.Г, Я.Б нарыг 14 насанд хүрээгүй буюу бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэргийг үйлдсэн гэж үзэх боломжгүй гээд шүүгдэгч нарын үйлдлийг зүйлчилсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан хэргийн зүйлчлэлийг тус хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.1-ээр хөнгөрүүлэн зүйлчилж шийдвэрлэжээ.

Шигтгээ 37. 18...343 дугаартай эрүүгийн хэргийн шийдвэр

Хохирогч Ц нь 2018 оны 6 дугаар сарын 28-наас 29-нд шилжих шөнө 14 нас хүрэхэд 1 хоног дутуу байсан нь төрсний гэрчилгээгээр тогтоогдсон боловч түүний хувийн байдал, биеийн хөгжлийн талаар өмгөөлөгчийн гомдолд дурдсан нэр бүхий гэрчүүдийн өгсөн мэдүүлгүүд болон хавтаст хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудаар хохирогч Ц нь өөрөөс ах С.О-тэй тодорхой хугацаанд үерхэж, бусадтай өсвөр насны хүүхэд шиг харилцаж, эцэг эхийнхээ эзгүй үед гэртээ очихгүй гадуур хоноглож явсан, урьд нь өөр хүнтэй бэлгийн харьцаанд орж, охин хальсанд хуучин сорвижиж эдгэсэн урагдал үүссэн байсан нь Шүүхийн шинжилгээний албаны 442 дугаартай шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон, мөн шүүгдэгч С.О-ийн хувийн байдал, түүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг үндэслэн шүүгдэгч С.О-ийн хувьд хохирогч Ц бага насны хүүхэд гэдгийг лавтай сайн мэдээгүй буюу түүнийг 14 нас хүрсэн гэж төөрөгдсөн талаар өмгөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хүлээн авах боломжтой гэж дүгнэсэн.

Шигтгээ 38. Шүүгчтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Хохирогчийн нас, бие физиологийн онцлогийг харгалзан зүйлчлэлийг тогтоох шаардлагатай гэж зарим гэмт хэргүүд дээр харагддаг. Насанд хүрсэн хүн шиг биеийн хөгжилтэй насанд хүрээгүй хүүхэд байдаг. Ийм хүүхдүүд насаа нэмж хүнтэй танилцаад бэлгийн харьцаанд орж байна. Гэтэл насаар нь хэргийг зүйлчлээд өндөр ял оногдуулж байна.

Бага насны хүүхэд бэлгийн бойжилт, боловсрол бүрэн хөгжөөгүй гэж үзэж хүсэл зоригийн эсрэг байх, эсхүл зөвшөөрсөн байх зэрэг асуудал байх ёсгүй гэж хууль зүйн хувьд тайлбарлаж хуулийг хэрэглэдэг боловч өнөөгийн нийгэмд нийгмийн харилцаа харьцангуй их хөгжиж байгаатай холбоотойгоор буюу ялангуяа цахим хэрэгсэл хөгжсөнтэй холбоотойгоор 14 насанд хүрээгүй хүүхдүүд бэлгийн бойжилтын талаар ойлголцолтой өөрөө бэлгийн харилцааг эхлүүлж байна.

Хууль тогтоогчийн бага насны хүүхдийн сэтгэхүйн хөгжлийн онцлог, үг ярианы хөгжил, хариуцлагаа хүлээх чадвар, үг хэл, үйл хөдлөлийн онцлог зэрэг шинжлэх ухааны олон шалгуурыг судалгаатайгаар харгалзан хатуу хуульчлан хуульд тусгайлан заасан “Насны хязгаар”-ыг шүүх шүүгдэгчийн мэдүүлгээр, хохирогчийн биеийн өсөлтийн хэмжээ зэрэг хийсвэр дүгнэлтээр “Гэмт хэргийн шинж”-ийг өөрчилж байна гэж дүгнэхээр байна.

Иймд хууль тогтоогч “Яагаад” 14 хүртэлх, 16 хүртэлх, 18 хүртэлх гэж насаар хохирогчийн насыг гэмт хэргийн хүндрүүлэх шинж болгон заасан болохыг харьцуулсан судалгаа, анагаах болон сэтгэл зүйн шинжлэх ухааны тайлбартайгаар хэлэлцүүлж, нас тухайн хүүхдийн сэтгэхүйн онцлогийг тодорхойлох үзүүлэлт болох талаар ойлголтыг хууль хэрэглэгч нарт олгох хэрэгцээ байна.

Үр дүн 20. Монгол Улсын Дээд шүүх тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ жишиг тогтохуйц эрх зүйн дүгнэлтүүдийг хийсэн нь энэ төрлийн гэмт хэргийг зөв зүйлчлэх, нэг мөр ойлгож шийдвэрлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа анхаарч нотлох баримтуудыг бүрдүүлэхэд ач холбогдолтой болжээ.

- Шүүхүүд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг чиглэсэн үйлдэл нь хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулах зэргээр хурьцал үйлдэхэд чиглэгдээгүй, энэ талаар төлөвлөөгүй зөвхөн өөрийн дур хүслийг бэлгийн шинжтэй бусад байдлаар хангаж, таашаал авах зорилгоор хохирогчтой харьцсан үйлдлийг бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэж ойлгох нь зүйтэй.⁴⁰
- Прокуророос Б.Ө-т холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.5, 4 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн бөгөөд шүүгдэгч тухайн нэг зүйлд заасан гэмт хэргийг хүндрүүлэх хэд

⁴⁰ 2020 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 391 дүгээр Улсын Дээд Шүүхийн тогтоол

хэдэн шинжээр үйлдсэн байх тул уг зүйлүүдийг нэгтгэн хамгийн хүндрүүлэх шинжээр нь зүйлчлэн ял оногдуулах нь зүйтэй.⁴¹

- Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд заасан “Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл” нь хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан, хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулснаар төгс үйлдэгдэх бөгөөд шинжилгээгээр хохирогчийн биед гэмтэл тогтоогдоогүй, охин хальс бүтэн, үтрээ, шулуун гэдэснээс эр бэлгийн эс, үрийн шингэн илрээгүйн дээр бусад нотлох баримтуудаар шүүгдэгч Б.Н нь бага насны хохирогч Б-г хүчиндэхэд чиглэсэн дотоожийг нь тайлах, бэлэг эрхтнээр нь оролдох зэрэг үйлдлийг эхлүүлсэн боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй, өөрөөр хэлбэл тэрээр гэмт хэрэг үйлдэхээр зорьж дээрх үйлдлийг хийх үед бага насны хохирогч айж уйлсан, тухайн цаг үед хохирогчийн эх С сэрснээр шүүгдэгчийн үйлдэл таслан зогсоогдсон нөхцөл байдал тогтоогдож байх тул шүүгдэгч Б.Н-ыг бага насны хүүхдийг хүчиндэх гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй.⁴²
- Хүчиндэх гэмт хэргийг үйлдэхээр завдсан гэдгийг гэмт этгээдийн зүгээс хохирогчийг хүчиндэхэд чиглэсэн үйлдлийг хийж эхлүүлсэн боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг туйлдаа хүрээгүй, шүүгдэгч өөрийн хүсэж зорьсон үйлдлийг бүрэн хийгээгүй таслагдсан нөхцөл байдал гэж ойлгоно.⁴³
- Хууль тогтоогч сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлал журмыг хуулиар зохицуулаагүй тул давж заалдах шатны шүүхээс шийтгэх тогтоолын 7 дахь заалтад шүүгдэгч Л.Т-аас нэр төр, сэтгэл санааны хохирол 10.000.000 төгрөгийг гаргуулан насанд хүрээгүй хохирогч О-т олгуулахаар шийдвэрлэснийг хүчингүй болгосон нь зөв байна.⁴⁴
- Гэр бүлийн орчин эерэг таатай бус, эцэг эх, асран хамгаалагчийн анхаарал хайр, халамж дутмагаас хараа хяналтаас гадуур байж хүүхдийн сониуч зан, бэлгийн харьцааны талаар хүчирхийлэгчийн зүгээс өгч байгаа хандлага, өдөөлтийн дохионд автаж бэлгийн хүчирхийлэлд өртсөнийг бэлгийн харилцаанд хүсэл зоригийн дагуу орсон гэж үзэх боломжгүй болно. Үүнээс гадна энэ хэргийн шүүгдэгч Т.Д нь хохирогчийг асран хамгаалах үүрэгтэй этгээд атлаа арван дөрвөн насанд хүрээгүй хүүхдийн биеэ хамгаалах чадваргүй байдлыг ашиглаж бэлгийн хүчирхийлэлд оруулж, хүүхдийн эрүүл өсөж, бойжих, бие махбодын хувьд хүчирхийлэлд өртөхгүй байх эрхийг нь ноцтой зөрчсөн өөрийн үйлдэлд хийж буй дүгнэлт, түүний хор уршгаар жирэмсэлсэн үр дагаварт хандаж буй байдалд шүүх зөв дүгнэлт хийж чадаагүй гэж үзлээ.⁴⁵

⁴¹ 2019 оны 10 дугаар сарын 2-ний өдрийн 453 дугаар Улсын Дээд Шүүхийн тогтоол

⁴² 2019 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 388 дугаар Улсын Дээд Шүүхийн тогтоол

⁴³ 2020 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 391 дүгээр Улсын Дээд Шүүхийн тогтоол

⁴⁴ 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 160 дугаар Улсын Дээд Шүүхийн тогтоол

⁴⁵ 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 461 дүгээр Улсын Дээд Шүүхийн тогтоол

- Эрүүгийн хуулийн тусгай ангид гэмт хэрэгт тооцохоор заасан нийгэмд аюултай тодорхой үйлдэл (эс үйлдэхүй)-н объектив болон субъектив шинжүүдийг тодорхойлсон хэм хэмжээний тэр хэсгийг диспозиц гэдэг бөгөөд түүнийг тодорхойлсон байдлыг харгалзан энгийн, тодорхойлсон, заасан, иш татсан (бланкет) гэж ангилан үздэг билээ. Эдгээрээс тодорхой гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг Эрүүгийн хууль болон бусад хууль, тогтоомжоос ишлэх замаар заасан хэм хэмжээг иш татсан (бланкет) диспозиц гэдэг ба Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.3-т заасан “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн” гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг мөн хуулийн 10.4 дүгээр зүйлийн тайлбарт заасан хүрээнд хоёр шатны шүүх тайлбарлан хэрэглэсэн нь хуульд нийцжээ.⁴⁶
- Хууль тогтоогч биеийн өсөлт хөгжил нь гүйцээгүй, оюун ухаан нь төлөвшөөгүй, бэлгийн харилцааны учир холбогдлыг ойлгож ухаараагүй, бага насны буюу 14 насанд хүрээгүй хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар онц хүндрүүлэн зүйлчлэхэд хүчиндэх гэмт хэргийн аргад хамаарах объектив талын шинж тогтоогдсон эсэхийг заавал шаардахгүй гэсэн агуулгаар Эрүүгийн хуульд аутентик тайлбар хийсэн нь бага насны хүүхдийн эрх ашиг, эрүүл мэнд, бэлгийн халдашгүй байдлыг гэмт халдлагаас онцгойлон хамгаалахад чиглэсэн төрийн бодлогын илрэл юм. Тодруулбал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн тайлбарт заасны дагуу бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй бөгөөд бага насны хохирогч хурьцал үйлдэхийг зөвшөөрсөн эсэх нь түүний эсрэг үйлдэгдсэн хүчиндэх гэмт хэргийг үгүйсгэх үндэслэл болохгүй юм.⁴⁷

Монгол Улсын Дээд шүүхийн энэхүү тайлбартай хэргүүд, жишиг болохуйц тайлбартай тогтоолуудыг товхимол болгон хэвлэх замаар хууль хэрэглэгчдийн энэ төрлийн гэмт хэргийн талаарх ойлголтыг нэг түвшинд авчирч болохоор байна.

⁴⁶ 2021 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 161 дүгээр Улсын Дээд Шүүхийн тогтоол

⁴⁷ 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 246 дугаар Улсын Дээд Шүүхийн тогтоол

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

2.1. Үндэсний эрх зүйн зохицуулалт

Үр дүн 21. Монгол Улсад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах, хохирогчид үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байна. Гэсэн ч хуулийн хэрэгжилтийн үнэлгээ тогтмол хийгдэхгүй байгаа нь эрх зүйн орчны үр нөлөөг шууд тодорхойлох боломжгүй байдлыг бий болгожээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна”, 16 дугаар зүйлийн 13-т “Халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй...” гэж заасан нь Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт хууль зүйн дээд хүчин чадалтайгаар үйлчлэх учиртай.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн гаралт жил ирэх тусам нэмэгдэхийн зэрэгцээ энэ нь илүү хүүхдийн эсрэг чиглэж байгаа нь анхаарал татаж байна.

Манай улсад хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалахтай холбоотой Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Жендерийн тэгш байдлыг хангах тухай хууль болон хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой 40 орчим журам, стандартууд үйлчилж байна.

Хууль тогтоомжийн тухай хууль⁴⁸-ийн 12 дугаар зүйлийн 12.1-т хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал; хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалыг Засгийн газар батаж мөрдүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор дээрх аргачлалыг баталсан байна.

⁴⁸ Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016

Хүснэгт 19. Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хяналт шинжилгээ хийх болон үр дагаварт үнэлгээ хийх зорилго

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх
хууль тогтоомжийн зорилгыг хангаж байгаа түвшинг тодорхойлох;	хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах;
хууль тогтоомжийн үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох;	хууль тогтоомжийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг байдлыг тодорхойлох;
	зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох.

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйлчилж буй дээр дурдсан хуулиудаас Хүүхэд хамгааллын тухай хуулиас бусдад нь хэрэгжилтийн болон үр дагаврын үнэлгээ хийгдээгүй байгаа нь хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах, хуулийг хэлбэрэлтгүй сахих, хууль шаардлагатай хүн бүртээ хүрч буй эсэхийг шууд тодорхойлох боломжийг хязгаарлаж байна.

Зөрчлийн тухай хууль

УИХ-аас 2017 онд баталсан Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 6.18 дугаар зүйлд Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих зөрчлийн талаар тухайлан зохицуулсан. Энэ зүйлийн 4 дэх хэсэгт биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон үйлдэлд, 7 дахь хэсэгт өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан үйлдлийг зөрчилд тооцож хариуцлага хүлээлгэхээр заасан байсан. Харин УИХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.6 дугаар зүйлийг нэмж, Биеэ үнэлэхийг зохион байгуулсан, зуучилсан, татан оролцуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр шийдвэрлэсэн байна.

Манай улс түүхэндээ анх удаа бэлгийн дарамт учруулах үйлдлийг гэмт хэрэгт тооцож, 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.4 дүгээр зүйлд заасан. Гэвч энэ хууль хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хүчингүй болгосон.

Улмаар иргэний нийгмийн байгууллагын шахалт, олон улсын байгууллагын зөвлөмж зэргийг харгалзсан 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар зөрчилд тооцож, Бэлгийн дарамт учруулах үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцож, хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

Зураг 37. Зөрчлийн хууль дахь бэлгийн эрх чөлөө, халдашгүй

6.18 дугаар зүйл. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих	4. Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6.26 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах	1.Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д “төр нь хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй” гэж, Монгол Улсын нэгдэн орсон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт”-д гишүүн улс бүр уг пактаар хүлээн зөвшөөрсөн эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн аливаа хүнийг үр нөлөөтэй эрх зүйн хамгаалалтаар хангахыг үүрэг болгожээ. Мөн “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц”-ийн 13 дугаар зүйлд “Гомдол гаргасан этгээд болон гэрчүүдийг гомдол гаргасан болон нотлох баримт гаргаж өгсөнтэй нь холбогдуулан зүй бусаар харьцах, айлган сүрдүүлэхээс хамгаалах арга хэмжээ авна” гэж заажээ.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор баталсан “Авлигын эсрэг конвенц”, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/25 дугаар тогтоолоор баталсан “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц” болон бусад олон улсын гэрээ, конвенцод “Оролцогч улс бүр энэхүү конвенцод тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон, буюу айлган сүрдүүлгээс хамгаалахаар заах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцод хамаарах гэмт

хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна” гэж тус тус үүрэг хүлээлгэсэн байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 40/34 дугаар тогтоолоор 1985 онд “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргасан нь олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлын нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”-ыг улсуудад уриалсан байна.

Гэрч, хохирогч нь гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад гол үүрэг гүйцэтгэдэг субъектүүд бөгөөд судалгаанаас үзэхэд тэдний аюулгүй байдал хамгаалалтгүй байна. Гэрч, хохирогчийг сүрдүүлэх, дарамтлах, хуурч мэхлэх, мөнгө өгөх, гуйх, ятгах, заналхийлэх зэрэг хэлбэрээр нөлөөлөх явдал гарсаар байгаа бөгөөд үүний үр дагавар нь мэдүүлэг өгөхгүй байх, эсхүл худал мэдүүлэг өгөх, сэтгэл зүйн хувьд хэвийн байдлаа алдах, амиа хорлох, амиа хорлох оролдлого хийх зэрэг үйлдэл болж буйг судлаачид тэмдэглэсэн байна. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж буй этгээдүүд гэрч, хохирогчийг хамгаалах эрх зүйн зохицуулалт, тогтолцоо байхгүй гэсэн үндэслэлээр гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг хийдэггүй болох нь судалгаагаар тогтоогдсон бөгөөд амь нас, эрүүл мэндэд нь аюул заналхийлэл тулгарсан хүүхэд, эмэгтэйчүүдийг Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг Хүйсийн тэгш эрхийн төв гэсэн төрийн бус байгууллагууд хамгаалах зарим арга хэмжээ авч хэрэгжүүлдэг ч маш бага хүрээг хамардаг, санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг зэрэг хууль зүйн болон практик шаардлагуудыг үндэслэн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн боловсруулах шаардлагыг тодорхойлсон. Монгол Улсын Их хурлаас 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталж, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн зорилт нь эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэхэд оршино.

Гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, тэдэнд үзүүлэх туслалцааны талаар хуулийн хоёрдугаар бүлэгт тодорхой тусгасан.

Зураг 38. Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ

урьдчилан сануулах
тодорхой үйлдлийг хязгаарлах
биечилсэн хамгаалалт
мэдээллийн нууцлалыг хангах
нэг бүрийн тусгай хэрэгсэл болон
тусгай техник хэрэгсэл, харилцаа
холбооны хэрэгслээр хангах
аюулгүй газарт түр байрлуулах
нүүлгэн шилжүүлэх
баримт бичгийг солих
гадаад төрхийг өөрчлөх

Зураг 39. Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

Сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ

гэрч, хохирогчийг хамгаалалтад авсан үеэс эхлэн
шаардлагатай тохиолдолд сэтгэл зүйчийг байлцуулах;
гэрч, хохирогчийн оролцоотой явагдах мөрдөн шалгах
ажиллагааны явцад үүсэх сэтгэл зүйн таагүй нөхцөл
байдлын талаар урьдчилан мэдээлэх;
шүүх хуралдааны хугацаа, дараалал, явц болон нөхцөл
байдлын талаар урьдчилан мэдээлэх;
шүүх хуралдааны танхимд гэрч, хохирогчтой сэтгэл зүйчийг
хамт байлцуулах;
шаардлагатай бусад арга хэмжээ

Аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хамтатган хэрэглэж болох бөгөөд хамгаалалтад шаардагдах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Гэхдээ дээр дурдсан хамгаалалтын арга хэмжээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сонгож хэрэглэнэ.

Гэрч, хохирогчид үзүүлэх сэтгэл зүйн хамгаалалтыг арга хэмжээг сэтгэл зүйчийн баг хэрэгжүүлнэ

Хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид дараах туслалцаа үзүүлнэ. Үүнд:

- хууль зүйн туслалцаа;
- сэтгэл зүйн туслалцаа;
- эрүүл мэндийн туслалцаа.

Гэрч, хохирогчид хууль зүйн, сэтгэл зүйн болон гэмт хэргийн улмаас эрүүл мэнд нь хохирсон бол эрүүл мэндийн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлнэ. Эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журмыг эрүүл мэндийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

Хууль зүйн болон сэтгэл зүйн туслалцааг Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх байгууллагын дэргэдэх гэрч, хохирогчийг хамгаалах нэгж хариуцан хэрэгжүүлнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын иргэн "...аюулгүй орчинд амьдрах, халдашгүй чөлөөтэй байх эрхтэй" -г онцлоод төр "хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүрэгтэй"-г заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 онд, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр 2007 онд тус тус батлагдан хэрэгжиж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалан байрлуулах, утсаар зөвлөгөө өгөх болон нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг байгуулан хохирогчдод үйлчилгээ үзүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа боловч Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зохицуулалт оновчтой бус, байгууллагуудын эрх хэмжээ, оролцоог хэт ерөнхий, салангид байдлаар тусгаж, хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хамгаалах журмыг орхигдуулсантай холбоотойгоор хүчирхийллийн гаралт буурахгүй, харин ч хүний амь нас хохирох, гэмтэх, хүүхэд өртөх зэргээр илүү ноцтой хэлбэрт шилжих болсон тул гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн зохицуулалтыг хохирогчийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах, хүчирхийлэл дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах зарчимд нийцүүлэх шаардлагатай болсон тул Монгол Улсын Их Хурлаас 2016 оны 12 дугаар сарын 22-ны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталж, өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зорилт нь гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтооход оршино.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн үйлчлэлд дараах этгээд хамаарна. Үүнд:

1. эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;
2. тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.

Хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн эрхийг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна дараах байдлаар хангана:

1. хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалуулахаар гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан тэргүүн ээлжид шийдвэрлэх;
2. гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллийг хүлээн авсан, хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтан хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний хувийн мэдээллийг нууцлах, задруулахаас урьдчилан сэргийлэх;
3. хохирогч гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, эсхүл хүчирхийллийн болзошгүй эрсдэл учирсан гэж үзвэл энэ тухай гомдол, мэдээллийг биечлэн, эсхүл хууль ёсны төлөөлөгч болон бусдаар дамжуулан гаргах нөхцөлийг хангах;
4. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа эсэхээс үл хамааран хохирогч, хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүнд энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлэх;
5. гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх үүргийг хуулиар хүлээсэн албан тушаалтан нь хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний аюулгүй байдлыг хангах, даруй тусгаарлах, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг авах;
6. хохирогч өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцож санал өгөх, албан тушаалтны гаргасан шийдвэрт гомдол гаргах нөхцөлийг хангах;
7. хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх бүхий этгээд, өмгөөлөгч, төрийн, төрийн бус байгууллага хохирогчийн эрх ашгийг хуульд заасны дагуу төлөөлөх;
8. гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа, явц, нөхцөл байдал болон хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэсэн хариуцлагын талаарх мэдээллийг тухайн гэмт хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэж байгаа албан тушаалтан хохирогчид танилцуулж, тайлбарлан өгөх;
9. ажил олгогч нь хохирогчийг энэ хуульд заасны дагуу хамгаалалтад байх хугацаанд түүний ажил, албан тушаалыг хэвээр хадгалах;

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгад тусгагдсан нэгэн онцлог зохицуулалт нь хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах талаар тусгайлан зохицуулсан явдал юм.

Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн хамгаалах үүрэгтэй бөгөөд энэ үүрэг нь хүүхдийг асран халамжилж байгаа этгээд нэгэн адил хүлээнэ. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах этгээд хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.

Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй гэж үзвэл төрийн, төрийн бус байгууллагын ажилтан, хуулийн этгээд, бусад этгээд цагдаагийн байгууллагад, цагдаагийн алба хаагчийн эзгүйд сум, багийн Засаг даргад болон хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх утасны үйлчилгээнд мэдээлэх үүрэгтэй.

Бүх шатны боловсролын байгууллагын багш, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан, хүүхдэд үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага, ажилтан нь хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүрэгтэй.

Хүүхэд хохирсон, эрсдэлтэй нөхцөлд байгаа тухай мэдээллийг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан ажилтан цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж, холбогдох үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай мэдээлэл хүлээн авсан цагдаагийн байгууллага, сум, багийн Засаг дарга хүчирхийллийг таслан зогсоох, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авна. Үүнд:

1. хүүхдийг нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх;
2. нэг цэгийн үйлчилгээний төв, эсхүл түр хамгаалах байранд хүргэх боломжгүй бол эцэг, эх, төрөл, садангийн болон бусад этгээд, өөр гэр бүлд хүлээлгэн өгөх;
3. хүүхдэд асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн, төрийн бус байгууллагад хүргэх.
4. хүүхдийн байгууллага, ажилтанд мэдээлэх.

Дээр дурдсан арга хэмжээг аюулын эрсдэлийн зэрэг дунд, өндөр, эсхүл дараах нөхцөл байдлыг байна гэж үзвэл эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг харгалзахгүй авна. Үүнд:

- а) хүчирхийллийг хүүхдийн амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн, эсхүл үйлдэж болзошгүй;
- б) хүүхдээ барьцаалсан, барьцаалж болзошгүй;

- с) хүүхдийн эмзэг байдлыг өөрт ашигтай шийдвэр гаргуулах, ашиг олоход ашигласан, ашиглаж болзошгүй;
- д) хүүхдийг айдас, сэтгэл санааны дарамтад оруулсан, оруулж болзошгүй;
- е) хүчирхийлэл үйлдэгч согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэдэг.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид дараах үйлчилгээг үзүүлнэ. Үүнд:

1. аюулгүй байдлын хамгаалалт;
2. эмнэлгийн тусламж, үйлчилгээ;
3. сэтгэл зүйн үйлчилгээ;
4. нийгмийн халамжийн үйлчилгээ;
5. хүүхэд хамгааллын үйлчилгээ;
6. эрх зүйн туслалцаа;
7. холбон зуучлах үйлчилгээ.

Хохирогчид үзүүлэх аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ дараах хэлбэртэй байна. Үүнд:

- түр хамгаалан байрлуулах;
- нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх;
- Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд хамруулах.

Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд байрлаж байгаа, эсхүл түр хамгаалалтад байгаа хохирогч, түүний насанд хүрээгүй хүүхэд хүчирхийлэл үйлдэгчтэй уулзах шаардлагатай бол насанд хүрсэн хохирогч өөрөө, эсхүл гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргаж болно. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд арван дөрвөн насанд хүрсэн бол өөрөө хүсэлт гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч зөвшөөрч байгаага бичгээр илэрхийлсэн байна. Хохирогчид үйлчилгээ үзүүлж байгаа хамтарсан баг хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэнэ. Хамтарсан баг уулзалтын зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэхдээ нөхцөл байдлын болон аюулын зэргийн үнэлгээг үндэслэн хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг харгалзана.

Хүүхдийн эрхийн тухай хууль

Хүүхдийн эрхийн тухай хуулийн зорилт нь хүүхдийн эрхийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн бүрэн эрхийг тодорхойлж, хүүхдийн эрхийг хангах тогтолцоог бий болгох, хүүхдийн эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү хууль нь хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 насанд хүртэлх хугацаанд түүний эрхийг хангахад чиглэгдэж үйлчилнэ. Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүүхдэд нэгэн адил хамаарна.

Хүүхэд дараах эрхийг баталгаатай эдэлнэ. Үүнд:

1. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх
2. Хүүхдийн хөгжих эрх
3. Хүүхдийн хамгаалуулах эрх
4. Хүүхдийн нийгмийн амьдралд оролцох эрх
5. Хүүхдийн хүмүүжил, төлөвшил

Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах байдал болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй

Хүүхэд хамгааллын тухай хууль

Хүүхэд хамгааллын тухай хуулийн зорилт нь хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, оролцогч талуудын харилцааг тодорхойлж, хүүхдийг үл хайхрах байдал, дарамт, мөлжлөг, хүчирхийллийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүүхэд хамгааллын үндсэн зарчим, стандартыг удирдлага болгоно. Хүүхэд хамгаалал нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэрээс, эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх зорилготой олон талт, цогц, мэргэшсэн үйл ажиллагаанаас бүрдэнэ.

Хүүхэд хамгаалал гэр бүл төвтэй, дагнасан, шуурхай, тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй байна.

Хүүхэд, өсвөр насны хүнийг халамжлах, эмчлэх, удирдан чиглүүлэх, тэдэнд боловсрол олгох үүрэг хүлээсэн эцэг, эх, асран хамгаалагч, бусад хүн тэднийг хүмүүжүүлэх, алдаатай зан авирыг нь засахдаа бие махбодын болон доромжлон гутаасан бүх төрлийн шийтгэлийн арга хэрэглэхийг хориглоно.

2.2. Олон улсын эрх зүйн зохицуулалт

Үр дүн 22. Монгол Улсын Засгийн газар хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах, түүний эсрэг үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээнийхээ талаар НҮБ-ын чиглэлийн хороодод тайлагнаж, ирүүлсэн өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаж байна.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn/-д нийтлэгдсэнээр Монгол улс нийт 600 гаруй 2 талт болон олон талт гэрээ, конвенцод нэгдэн орж, соёрхон баталжээ.

Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/-ын бүрэн эрхт гишүүн болсноос хойш НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээнд үүнээс хүний эрхийн суурь 18 гэрээний 17-д нь нэгдэн ороод байна⁴⁹. Үүнд:

Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протокол

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын Цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протокол

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын нэмэлт протокол

Хүний эрхийн түгээмэл тунхаглал

Хүүхдийн эрхийн тухай конвенц

Хүүхдийг зэвсэгт мөргөлдөөнд оролцуулахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай Конвенцод оруулах нэмэлт протокол]

Хүүхдийн эрхийн тухай конвенцын “Мэдээлэл хүргүүлэх журмын тухай нэмэлт протокол”

Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенц

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын нэмэлт протокол

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц

1. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протокол

⁴⁹ Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, НҮБ “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс” (нэгдүгээр боть), УБ, 2021 он, 11 хуудас

Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хангах, хамгаалах, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой олон улсын гэрээ, конвенцын талаар дор авч үзэв.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактыг Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны 2200A(XXI) тоот тогтоолоор баталж, 1976 оны 3 дугаар сарын 23-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1968 оны 01 дүгээр сарын 05-нд гарын үсэг зурж, 1974 оны 11 дүгээр сарын 18-нд соёрхон баталсан. Энэхүү пакт нь удиртгал, 6 бүлэг, 48 зүйлтэй.

Энэхүү пакт нь хүний амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх, чөлөөтэй бодож сэтгэх, шашин шүтэх, эс шүтэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчөөрөө уламжлан оролцох, сайн дурын үндсэн дээр гэрлэх, өрх тусгаарлах, өмчтэй байх, хүн бүр хуулийн өмнө адил тэгш хамгаалуулах, улсынхаа дотор чөлөөтэй зорчих, амьдран суух газраа чөлөөтэй сонгох зэрэг иргэний болон улс төрийн суурь эрхүүдийг багтаасан хүний эрхийн баримт бичиг юм.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц

Ерөнхий Ассамблейн 34/180 тоот тогтоолоор 1979 оны 12 дугаар сарын 18-ны өдөр баталж, 1981 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Монгол Улс 1980 оны 07 дугаар сарын 10-нд гарын үсэг зурж, 1981 оны 5 дугаар сарын 14-ны өдөр соёрхон баталсан байна.

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод нэгдсэн орсон улс орнууд эмэгтэйчүүдийг нийгэм, улс төр, эдийн засгийн харилцаанд эрэгтэй хүний адил оролцох, ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас ангид байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.

Энэхүү конвенцод нэгдэн орсон оролцогч улсууд нь эмэгтэйчүүдийг худалдах, тэднийг биеийг үнэлүүлэн ашиглах бүх хэлбэрийг таслан зогсоохын тулд зохистой бүх арга хэмжээ, түүний дотор хууль тогтоох арга хэмжээг авна.

Монгол Улс энэхүү конвенцын хэрэгжилтийн тайланг НҮБ-ын харьяалах хороонд дөрвөн жил тутам хүргүүлж байна.

Хүүхдийн эрхий тухай конвенц болон Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол

Хүүхдийн эрхийн тухай конвенц нь 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж, 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон. Удиртгал, 3 хэсэг, 54 зүйлтэй. Монгол Улс 1990 оны 01 дүгээр сарын 26-нд гарын үсэг зурж, 1990 оны 07 дугаар сарын 05-нд соёрхон баталсан.

Энэхүү конвенцод нэгдэн орсон улс орнууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин,

улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас үл шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй байж хүүхдийг хамгаалах, тэднийг хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, дарамтаас хамгаалж, эрүүл аюулгүй орчинд өсгөх, хүүхдийг бие дааж амьдрахад бүрэн бэлтгэх, хүүхэд өсөж торних таатай орчныг бүрдүүлэх үүргийг хүлээнэ.

Түүнчлэн хүүхдийг бэлгийн замаар ашиглан мөлжих бүхий л хэлбэрээс хамгаалах бөгөөд дараах зүйлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үндэсний, хоёр талт болон олон талт шаардлагатай бүх арга хэмжээг авна. Үүнд:

- a) хүүхдийг бэлгийн хууль бус аливаа ажиллагаанд татан оролцуулах буюу шахалт үзүүлэх;
- b) хүүхдийн биеийг үнэлүүлэх буюу бэлгийн хууль бус бусад ажиллагаанд ашиглан мөлжих;
- c) хүүхдийг садар самуун үзүүлбэр болон түүнийг сурталчилсан материалд ашиглах зэрэг юм.

Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол 2000 оны 5 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан. Манай улсын хувьд 2002 оны 10 дугаар сарын 11-ний өдөр энэхүү протоколд нэгдэн орж соёрхон баталсан.

Энэхүү нэмэлт протокол нь 17 зүйлтэй бөгөөд хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, садар самуунд татан оролцуулах, сурталчлахаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн бэлгийн эр чөлөө, халдашгүй байдлыг хамгаалах зорилгоор нэгдэн орсон улс орнууд эрүүгийн хуульдаа оруулах зохицуулалтыг тусгаж өгсөн байна.

Протоколын зорилгод:

- a) хүүхдийг худалдах гэж аливаа этгээд буюу бүлэг этгээд шан харамж буюу бусад аливаа төлбөр авч хүүхдийг бусад этгээд буюу бүлэг этгээдэд шилжүүлэн өгөх аливаа үйлдэл буюу хэлцлийг хэлнэ;
- b) хүүхдийн биеийг үнэлэх гэж шан харамж буюу бусад аливаа төлбөрийн хэлбэрээр хүүхдийг бэлгийн харилцаанд ашиглахыг хэлнэ;
- c) хүүхдийг садар самуунд сурталчлах гэж хүүхдийг ил тод бэлгийн харилцаанд бодитоор буюу хиймлээр оруулж байгааг аливаа арга хэрэгслээр илэрхийлэх буюу гол нь бэлгийн харилцааны зорилгоор хүүхдийн бэлэг эрхтнийг аливаа байдлаар харуулахыг хэлнэ.

Түүнчлэн оролцогч улс бүр эрүүгийн болон гэмт хэргийн талаарх хуульдаа дор хаяж дараах үйлдэл болон үйл ажиллагааг бүрэн хамааруулж, эдгээр гэмт хэрэг улсын дотоодод буюу үндэстэн дамнасан болон ганцаарчилсан буюу зохион байгуулалттай хэлбэрээр үйлдэгдсэнийг харгалзахгүйгээр хариуцлага хүлээлгэх шаардлагыг тавьсан байна. Үүнд:

- (a) хүүхдийг аливаа арга хэрэгслээр бэлгийн хүчирхийлэлд ашиглах, шан харамж авч хүүхдийн эрхтэнг шилжүүлэх, хүүхдийг албадан хөдөлмөр эрхлүүлэхэд ашиглах зорилгоор санал болгох, шилжүүлэх буюу авах;
- (b) хүүхэд үрчлэх үйл ажиллагаанд зуучлахдаа хүүхэд үрчлэх тухай олон улсын эрх зүйн баримт бичгийн заалтыг зөрчиж хууль бус арга хэрэглэн зөвшөөрүүлэх,
- (c) хүүхдийн биеийг үнэлэх зорилгоор хүүхдийг санал болгох, авах, шилжүүлэх болон өгөх;
- (d) хүүхэд оролцсон садар самуун сурталчилгааг үйлдэх, түгээх, тараах, импортлох, санал болгох, худалдах буюу хадгалах.

Нэмэлт протоколын 8 дугаар зүйлд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бэлгийн хүчирхийллийн хохирогчийг хамгааллын талаар дараах арга хэмжээг авахыг оролцогч улсуудад үүрэг болгожээ. Үүнд:

- ✓ хохирогч хүүхдийн эмзэг байдлыг хүлээн зөвшөөрч, тэдний онцгой шаардлагыг хүлээн зөвшөөрсөн журам батлах;
- ✓ хохирогч хүүхдэд түүний эрх, үүрэг болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны агуулга, хугацаа болон явц, уг хэргийн талаарх шийдвэрийн тухай мэдээлэх;
- ✓ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад холбогдох хуулийн дагуу хохирогч хүүхдийн санаа бодол, шаардлага болон асуудлыг тэдгээрийн хувийн ашиг сонирхол хөндөгдсөн үед танилцуулж, хэлэлцүүлэх боломж олгох;
- ✓ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед хохирогч хүүхдэд зохих дэмжлэг болох үйлчилгээ үзүүлэх;
- ✓ шаардлагатай үед хохирогч хүүхдийн амь нас, нэр төрийг хамгаалах болон үндэсний хууль тогтоомжийн дагуу хохирогч хүүхдийн нэрийг мэдэгдүүлсэн мэдээллийг зүй бусаар тараах явдлаас зайлсхийх арга хэмжээ авах;
- ✓ хохирогч хүүхэд, түүнчлэн түүний гэр бүлийнхний болон тэдний өмнөөс гэрчлэгчдийг аливаа сүрдүүлэг, өшөө хонзонгоос зохих үед хамгаалах арга хэмжээ авах;
- ✓ хохирогч хүүхдэд нөхөн төлбөр олгох тухай шүүхийн тогтоол болон шийдвэр гүйцэтгэлийг онцын шаардлагагүйгээр хойшлуулахаас зайлсхийх зэрэг байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон түүний нэмэлт конвенцод Монгол Улс нэгдэн орсныг 2008 оны 12 дугаар сарын

19-ний өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон батлах тухай” Монгол Улсын хуулийн дагуу соёрхон баталсан байна⁵⁰.

Энэхүү конвенц нь нийт 50 зүйлтэй бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй бүх хүн хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнчлэн тэдний нэр төр, нандин чанарыг хүндэтгэн дэмжихэд гол зорилго нь оршино.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хамруулахаар зохицуулсан байна.

Оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь орон гэрийнхээ дотор, гадна хаана ч жендэрт үндэслэсэн байдлыг оролцуулан аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос ангид байх явдлыг хангах үүднээс бүхий л зохистой хууль тогтоох, захиргааны, боловсролын болон бусад арга хэмжээг авна.

Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нас, хүйсийн онцлогт тохирсон тусламж, туслалцаа үзүүлэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, асран халамжлагчдад нь аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолтой холбоотой бодит явдлын талаар мэдээлэх, таниулах болон эдгээрээс хэрхэн сэргийлэх талаар мэдээлэл түгээх боловсрол олгох зэргээр дэмжлэг үзүүлэх явдлыг хангах замаар аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолоос урьдчилан сэргийлэх зохистой бүхий л арга хэмжээ авна.

Мөн аливаа хэлбэрийн мөлжлөг, хүчирхийлэл, доромжлолын хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие махбод, танин мэдэхүй, сэтгэлзүйн хувьд сэргээх, нөхөн сэргээх, нийгмийн амьдралд дахин оролцуулах, ялангуяа хамгаалах үйлчилгээ үзүүлэх зэрэг зохистой бүхий л арга хэмжээг авна. Ийнхүү сэргээх, нийгэмд оролцуулах арга хэмжээг тухайн хүний эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, өөрийгөө хүндэтгэх байдал, нандин чанар, хувь хүний хараат бус байдлыг хангасан орчин нөхцөлд л авахын зэрэгцээ тухайн хүний нас, хүйсийн онцлогийг харгалзан үзсэний үндсэн дээр хэрэгжүүлнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдол гарсан бол түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах хууль тогтоох болон бусад үр дүнтэй арга хэмжээ, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль тогтоох болон бусад арга хэмжээг авахыг оролцогч улсуудад даалгасан байна.

⁵⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=10034> – Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон батлах тухай хууль

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол 2000 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр батлагдсан бөгөөд манай улс 2008 оны 6 дугаар сарын 27-ны өдөр нэгдэн орсон.

Энэхүү конвенцын зорилго нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргээс илүү үр дүнтэй урьдчилан сэргийлэх болон түүнтэй тэмцэх хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын 3-р зүйлд Хүн худалдаалах гэмт хэргийг тодорхойлохдоо:

- a) Хүн худалдаалах гэмт хэрэг гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ. Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтнийг нь авах үйлдлийг ойлгоно.
- b) Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.
- c) Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно гэжээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах болон туслах ялангуяа нутаг буцаах талаар Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцод нэгдэн орсон улс бүр үндэсний хууль тогтоомжид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохыг үүрэг болсон.

Тухайлбал, хүн худалдаалах хэргийн хохирогчдыг бие бялдар, сэтгэл зүй болон нийгэмд эзлэх байр суурийн хувьд нөхөн сэргээх арга хэмжээг, тухайлбал зохих тохиолдлуудад дор дурдсан арга хэмжээг засгийн газрын бус байгууллагууд, бусад холбогдох байгууллагууд болон иргэний нийгмийн бусад хэсэгтэй хамтран дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна: Үүнд:

- a) зохих орон байраар хангах;
- b) хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод ойлгогдох хэлээр, ялангуяа хуулиар тогтоосон эрхийн талаар зөвлөгөө ба мэдээлэл өгөх;
- c) эмнэлгийн, сэтгэл зүйн ба материаллаг туслалцаа үзүүлэх
- d) хөдөлмөрлөх, боловсрол эзэмших болон суралцах бололцоогоор хангах.

Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэлт, хамтын ажиллагаа болон бусад арга хэмжээ, улс орнууд мэдээлэл солилцоо болон үр нөлөөтэй сургалт зохион байгуулах, хилийн хяналтын цогц арга хэмжээ хэрэгжүүлэхийг үүрэг болгожээ.

2.2.1. Нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн тайлан, түүнд өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 193 дугаар тогтоолоор “Монгол Улсын олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайлан боловсруулах журам”-ыг баталсан⁵¹.

Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтаар нийт 30 олон улсын гэрээ, конвенцын хэрэгжилтийн тайланг боловсруулахаар баталснаас хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгаалахтай холбоотой дараах олон талт олон улсын гэрээний хэрэгжилтийн тайлан, түүнийг хариуцан гаргах эрх бүхий байгууллагыг тогтоосон байна. Үүнд:

1. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц, түүний нэмэлт протокол
3. Хүүхдийн эрхийн тухай конвенц, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн тухай конвенцын нэмэлт мэдээлэл хүргүүлэх журмын тухай III протокол

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, түүний протокол

Манай улс 1981 онд энэхүү конвенцод нэгдэн орсон бөгөөд өнөөдрийг хүртэл нийт 10 удаагийн тайлан илтгэлийг НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хороонд хүргүүлж, ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, 1982 онд 1 дүгээр, 1986 онд 2 дугаар, 1999 онд 3, 4 дүгээр, 2008 онд 5, 6, 7 дугаар, 2014 онд 8, 9 дүгээр тайланг хүргүүлсэн бөгөөд 10 дахь удаагийн тайлан илтгэлийг Монгол Улсын Засгийн газрын 2022 оны тавдугаар

⁵¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12817>

сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, улмаар НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хорооны 82 дугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.

Монгол Улсын ээлжит найм ба есдүгээр нэгтгэсэн илтгэлийн⁵² талаар НҮБ-ын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах хорооноос энэхүү конвенцын хэрэгжилтийг хангуулахад хууль тогтоох байгууллагын үүрэг чухал ач холбогдолтойг онцлон тэмдэглээд 10 дугаар тайлан илтгэл ирүүлэх хүртэлх хугацаанд хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг ирүүлсэн. Хорооноос Монгол Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, гэр бүлийн болон охид, эмэгтэйчүүд, хүйсийн цөөнхийн эсрэг хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож, тухайн хохирогчтой эвлэрсэн гэх замаар буруутай этгээд ял шийтгэлээс зайлсхийдэг байсныг халсан, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл гэсэн нэр томъёог өргөжүүлж оруулсан зэргийг талархан хүлээн авч байгааг илэрхийлсэн байна. Гэвч:

- Гишүүн оронд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тоо өндөр байгаагийн зэрэгцээ холбогдох статистик тоо мэдээлэл дутмаг байгаа

- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжийг цагдаагийн байгууллагад байгуулсан хэдий ч гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах төрийн мэдлийн цорын ганц байр байгаа

- Хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн хувьд тэдгээр хамгаалах байр нь хүртээмжгүй байгаагийн улмаас тэд зохих дэмжлэг туслалцаа, үйлчилгээ авч чадахгүй, хөгжлийн бэрхшээлтэй хохирогч эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ, эмзэг байдалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр цагдаагийн ажилтнууд, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулдаггүй байгааг анхаарлаа хандуулахыг зөвлөжээ.

Түүнчлэн ажиглалтын дүгнэлтийн мөрөөр Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эрүүгийн хэрэг болгон хуульчилсан хууль тогтоомжийг хатуу чанд хэрэгжүүлэх, гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн жендерийн мэдрэмжтэй журмуудын хэрэгжилтийг хангуулах ажилтнууд, шүүгч, прокурор, цагдаа зэрэг хууль сахиулах ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх албан журмын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг зөвлөжээ.

Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит **аравдугаар илтгэлд** Эрүүгийн хуульд бэлгийн дарамт бол гэмт хэрэг гэдгийг оруулсан тухай дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болохыг тусгасан байна.

Гэмт хэргийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд нөхөн сэргээх зохистой нөхцөлийг бүрдүүлэх зөвлөмжийн хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, бүх төрлийн

⁵² Хавсралт 2-с харна уу.

дарамт, мөлжлөгт өртөх, гэмт хэргийн хохирогч болох, гэмт хэрэгт татагдан орох зэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хууль сахиулах, хүүхдийн эрхийг хамгаалах, боловсролын болон төрийн эрх бүхий холбогдох байгууллага хэрэгжүүлнэ”, 29 дүгээр зүйлийн 29.1.Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн тэгш эрхийг боловсрол, хөдөлмөр, нийгэм, эдийн засгийн салбарт хангах зорилгоор төрөөс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 29.1.2.хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэл, дарамтад өртөх, гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах; 29.1.4.гэрч, хохирогчийг хамгаалах байр нь хөгжлийн бэрхшээлтэй хүний онцлог, хэрэгцээ шаардлагад нийцсэн байх гэж хуульчилсан байгаа нь эрх зүйн хувьд ерөнхий байдлаар туссан байна. Гэсэн хэдий ч Гэмт хэргийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд нөхөн сэргээх зохистой нөхцөлийг бүрдүүлж байгаа талаар тодорхой мэдээлэл байхгүй байна энэхүү зөвлөмжийн хэрэгжилт, хохирогч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай нь харагдаж байна.

Оролцогч улсын Үндсэн хуульд олон улсын гэрээ, конвенцыг соёрхон баталсны дараа үндэсний хууль тогтоомжийн нэгэн адил мөрдүүлэхээр заасан байгаа боловч конвенцын заалтыг иш татсан, бүртгэгдсэн шүүхийн хэрэг байхгүй байгааг тэмдэглэв. Түүнчлэн эмэгтэйчүүд, ялангуяа хөдөө орон нутагт оршин суугч эмэгтэйчүүд, малчин эмэгтэйчүүд, лесбиян, бисексуал, трансжендер, интерсекс эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд Конвенцод заасан эрх, тэдэнд үзүүлэх боломжтой арга хэмжээний талаар ихэнхдээ мэддэггүйг санаа зовниж байна. Эмэгтэйчүүдийн Конвенцод заасан эрхийнхээ талаарх ойлголтыг нэмэгдүүлж, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах хууль, эрх зүйн талаарх мэдлэгийг дээшлүүлж, конвенц болон Хорооны ерөнхий зөвлөмжийн талаарх мэдээллийг бүх эмэгтэйчүүдэд, тэр дундаа нийгмийн эмзэг бүлгийн эмэгтэйчүүдэд хүртээмжтэй байлгахыг зөвлөжээ.

Оролцогч улсад эмэгтэйчүүдийн хувьд улс төрийн оролцоо, ажил эрхлэлт, ялангуяа шийдвэр гаргах болон удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн төлөөлөл багатай байх тул эдгээр салбарт эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн тэгш байдлыг хангахын тулд арга хэмжээ аваагүйд анхаарал хандуулах ёстой гэж үзжээ.

Ингэснээр Монгол Улсын **арав дах удаагийн тайлангийн хүрээнд** Хорооноос дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг шаардсан байна. Үүнд:

- (а) Цар тахлын эмэгтэйчүүдийн эрхээ эдлэхэд үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй тул Тогтвортой Хөгжлийн Зорилтод нийцүүлэн COVID 19-ийн нөхөн сэргээх стратегийн төвд эмэгтэйчүүдийг байрлуулах замаар эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн хооронд удаан үргэлжилсэн тэгш бус байдлыг арилгах, жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх ;

- (b) Сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулж, улс төрийн намуудын сонгуулийн жагсаалтад эмэгтэй нэр дэвшигчдийн квотыг 30 хувиас доошгүй болгох, сонгуулийн сурталчилгааны санхүүжилт, эмэгтэй нэр дэвшигчдэд сургалт явуулж буй улс төрийн намуудад санхүүгийн урамшуулал олгох, эмэгтэй нэр дэвшигчдэд ихээхэн саад учруулж буй “нэр дэвшигчийн татвар”-ыг хасах;
- (c) Хөгжлийн бэрхшээлтэй хүн, түүний дотор эмэгтэйчүүдийн сонгох эрхийг хязгаарласан Сонгуулийн тухай хуулийн заалтыг цаг алдалгүй хүчингүй болгож, хөгжлийн бэрхшээл нь хуулиар ялгаварлан гадуурхахыг хориглосон үндэслэл болохыг баталгаажуулж, тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх
- (d) Эмэгтэйчүүдийн тэтгэвэрт гарах нас эрт байгаа нь эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг хязгаарлаж, эмэгтэйчүүдэд олгох тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг бууруулах үр дагавартай байх тул бүх салбарын цалинг хянаж, жендерийн мэдрэмжтэй аналитик ажлын ангилал, үнэлгээний аргыг хэрэглэж, цалин хөлсний судалгааг тогтмол явуулж, эрэгтэй, эмэгтэй хүмүүст олгох цалингийн зөрүүг багасгаж, ижил албан тушаалд ажиллаж буй бүх хүмүүст ижил үнэ цэнэ бүхий цалин хөлс олгох зарчмыг хэрэгжүүлэх;
- (e) Ажлын уян хатан нөхцөлийг нэвтрүүлэх, ОУХБ-ын Гэр бүлийн үүрэг хариуцлагатай ажилчдын тухай 1981 оны конвенцыг соёрхон батлах;
- (f) Ажлын байран дахь бэлгийн дарамтыг тусгайлан гэмт хэрэгт тооцохоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, ажил олгогч, ажилтнуудад бэлгийн дарамтын талаар болон Жендерийн эрх тэгш байдлыг дэмжих тухай хуулийн холбогдох заалтыг сурталчлах, бэлгийн дарамтын талаарх бүх мэдээллийг үр дүнтэй шалгах, гэмт хэрэг үйлдэгчдийг зохих ёсоор шийтгэж, Дарамт, хүчирхийллийг устгах тухай ОУХБ-ын 190 дүгээр конвенцыг соёрхон батлах зэргийг дурджээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын анхдугаар илтгэлийг 2011 онд НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороонд хүргүүлсэн. Энэхүү анхдугаар илтгэлд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 16 дугаар зүйлд заасан хүчирхийлэл, доромжлол, мөлжлөгөөс ангид байх эрхийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн талаар тусгасан байна. Үүнд:

- “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” хуулийн зарчим нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хууль дээдлэх, хүчирхийлэл үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээг шуурхай авах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх зарчимд үндэслэнэ. Энэ хуулийн зарчмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч хамгаалагдсан.

Монгол Улс Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийн асуудлаарх НҮБ-ын конвенцод нэгдэн орж, түүний заалтуудыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн нь нэг талаас өөрийн улс оронд эрх зүйн орчныг сайжруулж, хэрэгжилтийг эрчимжүүлэх эдийн засгийн нөхцөл боломжийг бүрдүүлэх хариуцлагатай алхам бөгөөд нөгөөтээгүүр НҮБ ба түүний төрөлжсөн байгууллагууд, Олон улсын хамтын нийгэмлэгээс авах техник арга зүйн дэмжлэг, туслалцааг өргөжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байгаа юм.

НҮБ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос ирүүлсэн асуумжийн хариултад дараах арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар дурдсан байна. Үүнд:

- 2018 онд бэлгийн мөлжлөг, гэр бүлийн хүчирхийлэл, зүй бус харьцаанд өртсөн охид, эмэгтэйчүүд, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүд, охидыг хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв улсын хэмжээнд 25 байгаа ба “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавин нийтлэг шаардлага” MNS 6040:2009 Монгол Улсын стандарт⁵³-д нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байна.
- Нийслэлийн цагдаагийн газрын түр хамгаалах байранд 2016-2019 оны эхний 5 сар хүртэлх хугацаанд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 20 хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамгаалалтад авч, эрх зүйн болон сэтгэл зүйн анхан шатны туслалцаа үзүүлж, оршин суух хорооны хамтарсан багийн хяналтад холбон зуучилж ажилласан. Хамгаалалтад авсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 10 нь насанд хүрсэн хүн, 10 нь хүүхэд байсан бөгөөд сонсгол болон хэл ярианы бэрхшээлтэй 14, тулгуур эрхтний бэрхшээлтэй 2, харааны бэрхшээлтэй 4 иргэн байсан.
- Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр 2018 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрыг байгуулсан. Тус газрын нэг чиг үүрэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны явцад хяналт, шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх, дотоодын хяналт шалгалт, аудитыг журмын дагуу зохион байгуулах, шаардлагатай судалгаа, мэдээллээр хангах асуудал байдаг. Энэ газар байгуулагдаад удаагүй байгаа учир хөгжлийн бэрхшээлтэй хүний мөлжлөг, хүчирхийлэл, зүй бус харилцаанаас хамгаалахтай холбоотой үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр зарим ажлыг хийхээр төлөвлөж байгаа хэдий ч одоогоор хэрэгжүүлж эхлээгүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын 1 дүгээр зүйлд зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбод, оюун санаа,

⁵³ Стандарт, хэмжил зүйн газраас 2009 онд батлагдсан Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS6040:2009) стандартыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд 2019 онд орсон нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан өөрчлөлт оруулж, “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6040:2019) стандартыг шинэчлэн баталсан.

сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согогтой бөгөөд уг согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нэгдэн нийлсний улмаас бусдын нэгэн адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад учруулахуйц болсон этгээдийг хэлнэ.

Ийнхүү конвенцод нэгдэн орсноор Монгол Улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль буюу бие даасан хууль батлагдсан. Энэхүү хуульд зааснаар “хөгжлийн бэрхшээлтэй хүн” гэдэгт бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлэх бөгөөд эндээс үзэхэд Монгол Улсын хууль тогтоомжийн заалт нь Монгол Улсын нэгдэн орсон конвенцын заалттай нийцэж байна.

Энэхүү судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт дурдсанчлан Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн арван хоёрдугаар зүйлд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын гэмт хэргийг хуульчилсан бөгөөд энэхүү Эрүүгийн хуулийн зарчмын дагуу хөгжлийн бэрхшээлтэй иргэд ч мөн хамгаалагддаг. Ийнхүү хуульчилсан нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг мөлжсөн, хүчирхийлсэн, доромжилсон тохиолдол гарсан бол түүнийг илрүүлэх, мөрдөн шалгах болон мөрдөн байцаах хууль тогтоох болон бусад үр дүнтэй арга хэмжээ, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдэд чиглэсэн хууль тогтоох болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх Монгол Улсын нэгдэн орсон конвенцын холбогдох заалтад нийцүүлэн арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа явдал мөн юм.

Хүүхдийн эрхийн конвенц, Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протокол нэмэлт протокол

Монгол Улсын Ерөнхий сайд, Хүүхдийн төлөө Үндэсний Зөвлөлийн тэргүүн 2013 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр 178 дугаар захирамж гаргаж, Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх тавдугаар илтгэлийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайланг гаргах ажлын хүрээнд 2009-2014 онд Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Хорооны дүгнэлт зөвлөмжүүдийн хэрэгжилттэй холбоотой тайлан, статистик мэдээллийг нэгтгэсэн байна.

Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар илтгэлд дурдсанаар:

- Хүний эрх, ялангуяа хүүхдийн эрхэд ээлтэй байх зарчимд суурилсан Шүүхийн шинэтгэлийн тухай багц хуулиуд батлагдан хэрэгжиж эхэлсэн. Хүүхэд гэр бүлтэйгээ ойр байх ёстой гэсэн зарчмын дагуу хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих бодлого барьж байна. Эрүүгийн хуульд зааснаар хууль зөрчин, эрүүгийн хариуцлага хүлээж байгаа насанд

хүрээгүй этгээдэд оногдуулах ялын бодлого, шийтгэлийг хүүхдэд ээлтэй байх зарчмыг баримтлан хэрэгжүүлж байна.

- Монголд эмэгтэйчүүдийг БНХАУ, Макао, Гонконг, БНСУ, Сингапур, Тайван, Турк, Израйл, Япон, Малайз болон Европын Холбооны Улсуудад худалдсан хэрэг бүртгэгдэх болсноор хүний наймааны илгээгч улс орон болж байна гэж ЦЕГ үзэж байна. 2009- 2013 онд 113 хохирогчтой хүний наймаатай холбоотой 94 хэрэг бүртгэсэн. Үүнээс 54 хэргийн хохирогч БНХАУ-ын Эрээн, Хөх хот, Макао, Хайнан зэрэг газарт, Солонгос, Сингапур, Энэтхэг, Египет, Африк зэрэг улсад худалдагдсан, тэдгээрийн 41 нь 16-17 насны хүүхэд байсан юм. Харин үлдсэн 40 хэргийн хохирогч нь дотооддоо буюу эх орондоо хүний наймааны хохирогч болсон байна.
- 2010–2014 онд бэлгийн мөлжлөг, хүүхдийг хил дамнуулах худалдаалах асуудлаар 8 төрлийн судалгаа хийж, үр дүнг нь холбогдох байгууллага олон нийтэд мэдээлсэн байна. Тухайлбал, 2010 онд Үндэсний статистикийн хороо ОУХБ хамтран хийсэн “Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа” -аар Нийслэлд 4683 биеэ үнэлэгч байгаа, тэдний 0.9 хувь буюу 43 нь 15-17 настай, хамгийн бага нь 13 настай байна гэжээ. Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Хүүхдийн эрхийн үндэсний төв ТББ-ууд хамтран хийсэн “Өсвөр насны хүүхдийн садар самуун, бэлгийн мөлжлөгт өртөж буй талаарх судалгаа”-аар асуулгад оролцогчдын 89 хувь нь хүний 87 наймааг “Ноцтой асуудал” хэмээн тодорхойлсон байна. Хүний наймааны төрөл, хэлбэрийн хувьд бэлгийн мөлжлөг болон хуурамч гэрлэлтийг хамгийн түгээмэл хэлбэр гэж үзсэн байна. Асуулгад оролцогчдын 41,6 хувь нь 20-24 насны, 34,7 хувь нь 15-19 насныхан буюу залуу, өсвөр насны хүүхэд ихэвчлэн хүний наймааны гэмт хэрэгт өртөж байна гэж үзсэн байна.
- Цөөн тооны хүүхэд уран нугаралтын үзүүлбэрээр хилийн чанадад гэрээгээр ажиллах явцдаа хөдөлмөрийн мөлжлөг, хүний наймаанд өртөх эрсдэлтэй байдалд орсон үед гадаад дахь Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газрууд, Эрүүгийн цагдаагийн газар хамтран ажиллаж, хүүхдийг эх оронд нь буцаасан байна. Энэ төрлийн хэргийг илрүүлэх, мөрдөх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх механизмыг бэхжүүлэхээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг 2011 онд батлуулсан юм. Энэ хуулийн 30 орчим заалт нь хохирогчийг хамгаалах, 11 заалт нь хүүхэд, тэр дундаа охидыг бэлгийн мөлжлөгт өртөхөөс сэргийлэх, хамгаалахтай холбоотой байна. Хууль батлагдсанаар хүн худалдаалахтай тэмцэх ажлыг уялдуулан зохицуулах бүтэц бүхий Дэд зөвлөлийг ажиллуулж эхэллээ.
- Эрүүгийн хуулийн 113-р зүйлээр хүний наймааны бүх хэлбэрийг хориглосон бөгөөд ХХТТХ хууль батлагдсанаар энэ заалтад бусдын биеийг хүчээр үнэлүүлэх болон хүүхдийн биеийг үнэлэх асуудлыг нэмж хамааруулах боломжтой болсон.

- Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэргийг илрүүлэх, мөрдөн байцаах, шүүх, яллах үйл ажиллагааг бэхжүүлэх, хохирогчид үзүүлэх тусламжийн үйлчилгээг хөгжүүлэхэд АНУ-ын Азийн сан, Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ИОМ), Швейцарын хөгжлийн агентлаг, “Оюу толгой” компани зэрэг байгууллага, аж ахуйн нэгжүүд техник, санхүүгийн дэмжлэг үзүүлж ирлээ. Гэмт хэргийн хохирогчдод бие махбод сэтгэл санааны хувьд нөхөн сэргээх, нийгэмшүүлэх, эх оронд нь ирүүлэх зэрэгт олон улсын хамтын ажиллагааг дэмжсэн алхмууд хэрэгжиж байна. Тухайлбал, 2010 онд Хүн худалдаалахтай тэмцэх асуудлаар хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн Газар, БНХАУ-ын Макаогийн Засаг захиргааны онцгой бүсийн Засгийн Газар хоорондын хэлэлцээрийг байгуулсан. 5 бүлэг, 20 зүйлтэй уг хэлэлцээр нь эмэгтэйчүүдээс гадна хүүхдийг худалдахаас урьдчилан сэргийлэх, хохирогч 90 хүүхдийг хамгаалах, эх оронд нь буцаах, нийгэмшүүлэхтэй холбогдуулан арваад заалтыг тусгайлан оруулсан. Хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэх зорилгоор Хүний аюулгүй байдлын судалгааны төв (ХАБСТ) нь 2014 оны 6 дугаар сарын 5-7-нд Гадаад харилцааны яам, Тахарын ерөнхий газар, Гэмт хэрэгтэй тэмцэх газар болон тус төвийн төлөөллийг оролцуулсан ажлын уулзалтыг АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэй зохион байгуулсан. Үүний үр дүнд хэлэлцээрийг хэрэгжүүлэх 2014-2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх тохиролцоонд хүрсэн байна.
- Орон нутагт ч бэлгийн мөлжлөгт өртсөн, хүчирхийллийн хохирогч охидыг хамгаалж, тэднийг нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх үйлчилгээг үзүүлж эхэлсэн байна. Тухайлбал, Говь-Алтай аймгийн ХЭК-ийн тайланд тус аймагт хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдийг хамгаалах байр буюу “Нэг цэг”-ийн үйлчилгээ, “Хүүхэд, гэр бүлд зөвлөгөө өгөх танхим” зэргийг ажиллуулж, холбогдох хууль, шүүхийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа ажээ. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөгт өртсөн 23 хүүхдэд нөхөн сэргээх, сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйлчилгээг 2008 оноос хойш Хамтарсан багаар үзүүлснийг мөн тайланд дурджээ. 2010 оноос Улаанбаатар хот болон Замын-Үүдэд хүний наймааны хохирогчийг хамгаалах хоёр байр байгуулж өнөөг хүртэл Хүйсийн тэгш эрхийн төв ТББ ажиллуулж байна. Энэ нь хэрэг бүрдүүлэх шатанд хохирогчдыг хамгаалах боломжийг өргөжүүлж байна. Хамгаалах байраар үйлчлүүлсэн 111 хохирогчийн дотор 4 хүүхэд байсан байна. Хүүхдийн тусламжийн утасны зөвлөгч операторуудыг бэлгийн мөлжлөгөөс сэргийлэх, хохирогчийг хамгаалах, зөвлөгөө өгөх арга барилд сургаж байна. 2013 онд 11-13 насны 23 охиныг садар самуунд уруу татсан хэрэгт яллагдагч 25 жилийн хорих ял авсан.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын тавдугаар тайлан, илтгэлийг хэлэлцээд НҮБ-ын хүүхдийн эрхийн хорооноос дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

1. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахын эсрэг Хүүхдийн эрхийн тухай конвенцод оруулах нэмэлт протоколын 2 болон 3-р зүйлд нийцүүлэн хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахыг гэмт хэрэг гэж тодорхойлон хуульчлах;
2. Хүүхдийн секс аялал жуулчлалыг устгах, үүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтын үр дүнтэй хүрээг тогтоож, хууль, захиргаа, нийгэм болон бусад бүх шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх;
3. Хүүхдийн эрхийг бүрэн дүүрэн хангахын тулд Бүх цагаач ажилчид, тэдний гэр бүлийг хамгаалах олон улсын конвенцыг соёрхон батлах.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12.3 дугаар зүйлд зааснаар бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг арван дөрвөөс арван найман насанд хүрээгүй хүнийг болон бага насны хүүхдийг албадан оруулах нь хүнд гэмт хэрэг байхаар хуульчлан тусгасан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд заасан биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарахаар хуульчилсан байна.

Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан хүн худалдаадах гэмт хэргийг хүүхэд гэдгийг мэдсээр байж үйлдсэн үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан. Түүнчлэн төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх хүүхэд худалдах гэмт хэрэг болохыг тогтоож Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16.6 дугаар зүйлд хуульчилсан байна.

Хүүхдэд садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг зориуд үзүүлсэн, өгсөн, сурталчилсан; хүүхдээр садар самуун үйлдэл хийлгэсэн; хүүхдэд биеэ үнэлэх, бэлгийн харьцаанд орохыг санал болгосон бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16.8 дугаар зүйлд хуульчилсан байна.

Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэсэн, борлуулсан, тараасан, хадгалсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх бөгөөд энэхүү хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах гэмт хэргийг кибер орчныг ашиглаж, бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх тухай Монгол Улсын Эрүүгийн хуулийн 16.9 дүгээр зүйлд заасан байна.

Ийнхүү хуульчилснаар хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самуунд сурталчлахыг гэмт хэрэг гэж тодорхойлон хуульчлах зөвлөмжийн хэрэгжилтийг хангасан бөгөөд хүүхдийн секс аялал жуулчлалыг устгах, үүнээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн зохицуулалтын үр дүнтэй хүрээг хуульчлан тогтоох зөвлөмжийн хэрэгжилтийг хангах хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэг мөн гэж бид үзэж байна.

Харин манай улс Бүх цагаач ажилчид, тэдний гэр бүлийг хамгаалах олон улсын конвенцыг соёрхон батлаагүй байна. Иймд энэхүү зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улс дахь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний болон олон улсын эрх зүйн орчныг судлах, энэ төрлийн гэмт хэргийн нөхцөл байдлыг тодорхойлох замаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны ажлын хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Манай улс хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг баталгаатай хангахтай холбоотой олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орсон. нэгдэн орсон гэрээ конвенцын хэрэгжилтийг хангах, болон үндэсний хууль тогтоомж, тэдгээрийг даган гарсан хэм хэмжээ тогтоосон актуудыг батлан, хэрэгжүүлж байна.
2. Энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчдыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж буй төрийн бус байгууллагын хүчин чармайлт, олон улсын дэмжлэгтэйгээр олон судалгаа хийгдэж бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хууль тогтоомжийн чадавх эрс сайжирсан гэж дүгнэж байна.
3. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцод болон түүний протоколд нэгдэн орсон оролцогч улсын хувьд Хорооноос өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой бөгөөд энэ талаар тодорхой, шийдвэртэй арга хэмжээг авч, тухай бүрд нь тайлан илтгэлээ илгээн түүнийгээ амжилттай хамгаалж байна.
4. Эрүүгийн хуульд хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт оногдуулах ялын интервал давхцалтай байгааг (5-12 жил, 8-15 жил гэх мэтээр) арилгаж, давхардлыг арилгах шаардлагатай байна.
5. Аливаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг тусгайлсан бүлгээр насанд хүрэгчдээс ялгамжтай зохицуулдаг болон насанд хүрээгүй хохирогчийн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох онцлогийг тусгайлан системчлээгүй байна. Энэ нь ялангуяа өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах үед илүү анзаарагдах бөгөөд цаашид засаж залруулах зайлшгүй шаардлагыг бий болгожээ.
6. УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Хууль зүйн туслалцааны тухай хууль 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжсэнээр ЭХТА-ийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт өртөж хохирсон, төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх эрх зүйн үндэс тавигджээ. Хууль батлагдсантай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх өмгөөлөгчдийг

давтан, мэргэшүүлэх багц сургалтад зайлшгүй хамруулах шаардлага бий болно.

7. Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн мөн чанар нь нэгэнт үйлдэгдсэн гэмт хэргийг нотлоход бус урьдчилан сэргийлэхэд хууль зүйн учир холбогдол нь оршиж байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой боловч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, алба хаагчдын хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах хандлага, мэдлэг, мэргэшлийн ур чадвараас ихээхэн шалтгаалдаг.

Иймд бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлын үр дүн нь батлагдсан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээ тогтоосон актын агуулга, мөн чанараас гадна түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо, иргэн, албан тушаалтны үйл ажиллагаа, сэтгэлгээний хандлагаас ихээхэн шалтгаалах нь дамжиггүй гэж үзэж байна.

8. Хүний бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн гаралт өсөх үзүүлэлттэй бөгөөд хохирогч нь насанд хүрээгүй хүн, ялангуяа бага насны хүүхэд ихээр өртөж байгаад дүн шинжилгээ хийж, тэднийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагыг бий болгож байна.
7. Бэлгийн халдашгүй байдалд нь халдсан гэмт хэргийн хохирогч, ялангуяа насанд хүрээгүй хохирогчид Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээгээр дамжуулан шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх ажиллагаа явагдаж байна. Цаашид төрийн эзэмшлийн түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг олон улсын жишигт нийцүүлэн байгуулах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь хохирогч, гэрчийн аюулгүй байдалтай салшгүй холбоотой байна.
8. Хэдийгээр хүүхэд хамгааллын 108 төв нь бэлгийн хүчирхийллийн хүүхдийг богино хугацаанд буюу 3 хүртэл сар хамгаалж, энэ хугацаандаа хохирогч хүүхдийг гэр бүлд нэгтгэх, өөр байгууллагад шилжүүлэх, холбон зуучлах үйлчилгээ үзүүлж байгаа боловч, цогц үйлчилгээ дутагдаж байна. Иймээс хүүхдийг эсрэг үйлдэж буй аливаа гэмт хэрэгт ялангуяа хүн худалдаалах, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, туслалцаа үзүүлэх чиглэлээр ажиллах хүүхдийн хамгаалах дагнасан байрыг яаралтай ашиглалтад оруулж, цогц үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх шаардлагатай.
9. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэж буй гэмт хэргийн гаралт өсөх хандлагатай байна. Ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн улмаас хүүхэд хохирох явдал буурахгүй байгаа нь ажиглагдаж байна.
10. Бэлгийн хүчирхийллийн эсрэг гэмт хэргийн үйлдэгдэж байгаа онцлогоос шалтгаалан энэхүү төрлийн гэмт хэргийн гомдол, мэдээллийг хүлээн

- авах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэргэшсэн боловсон хүчний бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах явдал чухал байна.
11. Бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт болж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нэг ажиллагаа нь шүүх эмнэлгийн болон ДНХ-н шинжилгээ юм. Гэвч манай улсын хэмжээнд зөвхөн нийслэлд ДНХ-н шинжилгээ хийх лаборатори ажиллаж байгаа нь хэргийн хугацаа алдах, нотлох баримт нотолгооны шинж чанараа алдах зэрэг эрсдэлийг бий болгож магадгүй нөхцөл байдлыг үүсгэж байна.
 12. Энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг сайтар судлан зөв сонгож оролцуулах шаардлагатай байна. Ингээгүйгээс үйлдэгч нарын нөлөөнд автах, нэгэнт хохирсон хохирогч нарыг өөрийг нь буруутгах, хайхрахгүй орхих зэрэг байдлууд байдаг байна. Түүнчлэн хууль ёсны төлөөлөгчийг хариуцлагажуулах шаардлага байна. Ялангуяа хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төлөөлөгчийг энэ энэ төрлийн гэмт хэрэгт оролцох үеэс нь эхэлж, эрх үүргийг сайтар ойлгуулж, үүрэгжүүлэхгүй бол хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлдэггүй байдал анзаарагдлаа.
 13. Хохирогч нарын сэтгэл зүйн хохирлыг тодорхойлох аргачлалыг яаралтай бий болгох шаардлагатай байна.
 14. Өнөөдрийн байдлаар хохирогчид учирсан хохирлыг дан ганц бие махбодод учирсан гэмтлийг хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол гэж тодорхойлон зааж өгсөн. Иймд тодорхойлсон сэтгэл зүйн гэмтэл (учирсан хохирол)-ийн сэргээгдэх хугацаа, хохирогчийн нас зэргээс хамаарсан байдлаар нь биед нь хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол учирсан болохыг тогтоосон аргачлал байж болохоор байна. Үүнтэй уялдан сэтгэл зүйн хохирлыг арилгах сэтгэл зүйн эмчилгээний тарифаар хохирлыг гаргуулан хохирогчийн сэтгэл зүйн хохирлыг эмчлүүлэхээр байна.
 15. Дархан-Уул аймгийн шүүх, прокурор, цагдаа, ГБХЗХХ-ийн хамтран ажиллаж буй туршлагыг нийт нутаг дэвсгэрт нэвтрүүлэх замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааг бий болгох зайлшгүй шаардлагатай байна.
 16. Засгийн газрын тусгай ангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт Эрүүгийн хуулийн ... 12.1 дүгээр зүйл /Хүчиндэх/, 12.3 дугаар зүйл /Бэлгийн мөлжлөг/, ...-д заасан гэмт хэргийн улмаас амь насаа алдсан этгээдийн гэр бүлийн гишүүн, түүнчлэн хүнд гэмтэл учирсан хохирогчийн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрт заасан эмчилгээний зардал, оршуулгын зардал, хөдөлмөрийн чадвар алдсанаас дутуу авсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого зэрэг хохиролд нөхөн төлбөр

олгоно гэж заасан. Хуулийн энэ зохицуулалтын дагуу ялангуяа хүүхэд хохирсон хэрэгт хохирлыг барагдуулахад Засгийн газраас анхаарах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Судалгааны багийн зүгээс судалгааны ажлын үр дүнг үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. НҮБ-ын хороодоос ирсэн зөвлөмжийг бодитойгоор хэрэгжүүлэх ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж, хяналт шинжилгээ-үнэлгээг тогтмолжуулах;
2. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчид туслалцаа дэмжлэг үзүүлэхтэй холбоотой хуулиудын хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээг яаралтай хийж, шаардлагатай арга хэмжээг авах;
3. ЭХТА-ийн 12.3 дугаар зүйлийн 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор гэж заасан нь ЭХТА-ийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн заалттай өрсөлдүүлсэн хэм хэмжээ болсон байх тул хуульд өөрчлөлт оруулах замаар зөвтгөх;
4. ЭХТА-ийн 12 дугаар бүлэгт гэмт хэрэгт өртөж хохирсон “хүүхэд”-ийг насны ангиллаар ялгаж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулах ялыг ялгамжтай зохицуулсныг нэг болгож өөрчлөх;
5. ЭХТА-ийн 12.5 дугаар зүйлд заасан Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэргийн субъектийн нас 18 байгааг өөрчилж, нийтлэг субьекттэй болгох;
6. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг яаралтай баталж, улмаар хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон хүний сэтгэцэд учирсан хор уршгийг зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргах боломжийг бий болгох;
7. Улсын дээд шүүхээс ЭХТА-ийн 12 дугаар бүлэгт хамаарах нэр томъёог нэг мөр ойлгож хэрэглэхтэй холбоотой тайлбар гаргаж, хэрэглээнд нэвтрүүлэх;
8. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн улмаас хохирсон хүнийг хамгаалах, тэдэнд шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэхтэй холбоотой улсын хэмжээнд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дагаж мөрдөх стандартыг шинэчлэн боловсруулж, батлах;
9. ГХУСАЗЗ-ийн Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан дэд зөвлөлөөс:
 - 9.1. ЦЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн болон УЕПГ-ын хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэгт хяналт

- тавих хяналтын прокуроруудын мэдэг чадварыг дээшлүүлэх, хүүхэд хамгаалал төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний чиглэлийн сургалтад тогтмол хамруулах;
- 9.2. УИХ-аас 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан Хууль зүйн туслалцааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон төлбөрийн чадваргүй хүний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор ХЗТТ-ийн өмгөөлөгч нарыг давтан мэргэшүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;
- 9.3. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийн мэдээллийг хамгаалах, нууцлах, ийм гэмт хэргийн хохирогч болсон хүүхэдтэй ажиллах арга зүйг эзэмшүүлэх зорилгоор ЕБС-ийн нийгмийн ажилтан, багш нарыг тогтмол сургалтад хамруулах;
- 9.4. ГБХЗХГ-тай хамтран энэ төрлийн гэмт хэрэг хууль ёсны төлөөлөгчөөр оролцож буй хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, чадвар эзэмшүүлэх;
- 9.5. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон хүмүүсийн 90 гаруй хувь нь 18 хүртэлх насны хүүхэд байгааг онцгой анхаарч, тэднийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар цогц бодлогын баримт бичиг боловсруулж, хэрэгжүүлэх;
10. Шүүхээс бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт, ялангуяа хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн бие сэтгэхүйн онцлог, цаашид учирч болох эрсдэл, хохирлыг тооцохтой холбоотой шийдвэр гаргахдаа "...жич иргэний журмаар нэхэмжлэх эрхтэй..." гэсэн хэвшмэл өгүүлбэрээр бус "Шүүхийн шийдвэр нь тодорхой, ойлгомжтой, түүнийг биелүүлэхэд ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүй байхаар бичигдсэн байна" гэсэн хуулийн шаардлагад нийцсэн байдлаар бичиж хэвших;
11. УЕПГ, ЦЕГ, ГБХЗХГ-аас бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдэд үзүүлж буй туслалцаа дэмжлэг, тэдний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар өндөр зохион байгуулалттай ажиллаж буй Дархан-Уул аймгийн сайн туршлагыг нийт нутаг дэвсгэрт нэвтрүүлэх талаар хамтран ажиллах;
12. Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн чухал нотлох баримтыг бүрдүүлж буй Тусгай шинжилгээний газарт харьяалагдах ДНХ-н лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар 5 бүс нутагт байгуулах асуудлыг нэн яаралтай судалж, шийдвэрлүүлэх,

13. Шүүхийн шинжилгээний байгууллагын хийж буй аливаа шинжилгээний тоон статистик нь гэмт хэргийн төрөл, ангилал, шүүхийн шинжилгээний төрөл, шинжилгээний объект гэх мэт нарийвчлалтай, судалгаа шинжилгээнд ашиглах бүрэн боломжтой байхаар тооцож шинжилгээний сангийн программ хангамжийг сайжруулах зэрэг болно.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Хууль тогтоомжийн жагсаалт

1. Хүүхдийн эрхийн конвенц, 1990
2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №24
3. Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №41
4. Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл УБ.,2002, №2
5. Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2013, №30
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг соёрхон батлах тухай хууль
7. Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2016, №21
8. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, УБ.,2017, №40
9. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, НҮБ “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс” (нэгдүгээр боть), УБ, 2021 он
10. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, НҮБ “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс” (хоёрдугаар боть), УБ, 2021 он, 641-642 дугаар хуудас;
11. Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6040:2019) стандартыг шинэчлэн баталсан.
12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам

Бусад эх сурвалж

13. Б.Энхболд, С.Гантулга, Эрүүгийн эрх зүй, тусгай анги, УБ.,2020,
14. <http://judcouncil.mn/site/news/22>
15. <http://www.ase.mn/Default.aspx?page=36&news=220>
16. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12817>
17. <https://mn.wikipedia.org/wiki>
18. www.fcsok.org
19. Азийн сангийн захиалгаар Хүйсийн тэгш эрх төв ТББ-аас явуулсан Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ судалгааны тайлан, УБ.,2022

20. АНУ-ын Оклохома мужийн Тулса хотын Дүүргийн прокурорын газарт байрлах Family Safety Center
21. Дэлхийн зөн Монгол ОУБ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа, УБ.,2021

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлыг хамгаалахтай холбоотой хэм хэмжээ тогтоосон актын жагсаалт

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/239 дүгээр тушаалаар “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”
2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/612 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”
3. Гадаад харилцааны сайдын 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн Дугаар А/91 тушаалаар “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам”
4. Засгийн газар 2019 оны 201 дүгээр тогтоолоор “Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх журам”
5. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 177 дугаар тогтоол “Сургуулийн эргүүлийн ажиллах журам”
6. Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/22, А/31 дүгээр хамтарсан тушаалаар “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам”
7. Улсын ерөнхий прокурорын 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн А/14 дугаартай тушаалаар батлагдсан “Мөрдөн шалгах ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загвар”
8. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/68 дугаар тушаалаар “Цахим орчинд хүүхэд хамгаалах үйл ажиллагаанд баримтлах чиглэл”
9. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Дугаар А/190, А/280 “Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам”
10. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдөр А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар “Хамтарсан багийн ажиллах, түүнийг санхүүжүүлэх журам”
11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/120, А/178 дугаар хамтарсан тушаалаар “Нөхцөл байдлын үнэлгээ хийх журам”

12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/331 дүгээр тушаалаар “Хүүхдийн эрхийн мэдээллийн санг бүрдүүлж ашиглах журам”
13. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны А/79 дүгээр тушаалаар “Хүүхдийн эрхийн ажилтны ажиллах журам”
14. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”
15. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар “Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх журам”, Холбон зуучлах үйлчилгээнд илгээх хуудас”
16. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалаар “Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх журам”
17. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн дугаар А/150 тушаал “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”
18. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны А/148 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам”
19. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдөр дугаар А/210 тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”, “Магадлан итгэмжлэгдсэн байгууллагад олгох гэрчилгээний загвар”
20. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн дугаар А/218 тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”
21. Хөдөлмөрийн сайдын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/135 тушаалаар батлагдсан “Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”
22. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/253, /А/252 дугаар хамтарсан тушаал “Өсвөрийн сэргийлэгч сайн дурын бүлгэмийн ажиллах журам”, “Таних тэмдгийн загвар”
23. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/56, А/35 дугаар хамтарсан тушаалаар “Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтыг зохион байгуулах журам” “Хохирогчийг хүчирхийлэл үйлдэгчтэй уулзуулах уулзалтын бүртгэлийн маягт”
24. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн

- А/84, А/59, А/130 дугаар хамтарсан тушаалаар “Хохирогчид үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам”
25. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/25 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”, “Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам”
26. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/29 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлэх журам”
27. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/38 дугаар тушаалаар “Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам”
28. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/39 дүгээр тушаалаар “Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам”, “Холбогдох маягтууд”
29. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/83 дугаар тушаалаар “Аюулын зэргийн үнэлгээ хийх журам”, “Аюулын зэргийн үнэлгээ хийсэн тэмдэглэлийн загвар”
30. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/73 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ хэрэглэх журам”
31. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/107 дугаар тушаалын хавсралтаар “Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам”, “Гэрээ, маягтын загвар”
32. Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/112 дугаар тушаалаар батлагдсан “Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах, аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам”
33. Хууль зүйн сайдын 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн А/113 дугаар тушаалаар “Гэрч, хохирогчийг тусгай техник, хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам”
34. Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/204 дүгээр тушаалаар батлагдсан “Биечилсэн хамгаалалтын журам”
35. Хууль зүйн сайдын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн Дугаар А/08 тушаалаар “Урамшуулал олгох журам”
36. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл батлах тухай”

37. Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Дугаар 356, А/182 хамтарсан тушаалаар “Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам”
38. Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/394 дүгээр тушаалаар “Хохирогчид эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, “Хохирогчид сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”, “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд эмнэлгийн болон сэтгэл зүй, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх журам”

Хавсралт 2. Бэлгийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлж буй ТББ-уудын мэдээлэл

№	Байгууллагын нэрс	Үйлчилгээний төрөл, хэлбэр	Үйлчилгээний үе шат
1	Гүүд нэйборс ОУТББ	<ul style="list-style-type: none"> ✓ Сэтгэл зүйн зөвлөгөө, засал 	<ul style="list-style-type: none"> ✓ Илрүүлэх ✓ Нөхцөл байдлын үнэлгээ хийх ✓ Холбон зуучлах ✓ Гэр бүлд нэгтгэх
2	Анбаунд Монгол ТББ	<ul style="list-style-type: none"> ✓ Анхан шатны туслалцаа ✓ Түрээсийн байр ✓ Аюулгүй газраас хангах ✓ Хоол хүнс, хувцсаар хангах ✓ Гэр бүл рүү буцаах 	<ul style="list-style-type: none"> ✓ Илрүүлэх ✓ Холбон зуучлах ✓ Гэр бүлд нэгтгэх
3	Иргэдэд туслах хүний эрхийн төв	<ul style="list-style-type: none"> ✓ Хууль зүйн туслалцаа 	
4	Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ	<ul style="list-style-type: none"> ✓ Сэтгэл зүйн зөвлөгөө, засал 	<ul style="list-style-type: none"> ✓ Кейс менежментийн үйлчилгээний тогтолцоогоор үйлчилгээгээ үе шаттайгаар үзүүлдэг.
5	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв	<ul style="list-style-type: none"> ✓ Өмгөөллийн үйлчилгээ ✓ Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ ✓ Боловсролыг тасралтгүй хөгжүүлэх үйлчилгээ ✓ Орон гэртэй болоход дэмжлэг үзүүлэх 	<ul style="list-style-type: none"> ✓ Хохирогчийг хүлээн авна ✓ Бүртгэл хөтөлнө. Үйлчлүүлэгчдээ файл үүсгэнэ.

**ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ
ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

6	Лантуу дохио ТББ	<ul style="list-style-type: none"> ✓ Хамгаалан байрлуулах ✓ Сэтгэл зүйн зөвлөгөө ✓ Боловсролын үйлчилгээ ✓ Нийгмийн ажил үйлчилгээ ✓ Эрүүл мэндийн үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> ✓ Илрүүлэх ✓ Нөхцөл байдлыг үнэлгээ гэр бүлд нэгтгэх
7	Талита Ази	<ul style="list-style-type: none"> ✓ Хамгаалах байранд байрлуулах ✓ Нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> ✓ Кейс менежмент
8	ХТЭТ	<ul style="list-style-type: none"> ✓ Анхан шатны туслалцаа ✓ Нөхөн сэргээх үйлчилгээ ✓ Эх оронд эргүүлэн авчрах ✓ 2 төрлийн хамгаалах байр 	<ul style="list-style-type: none"> ✓ Илрүүлэх ✓ Эргэн нийгэмшүүлэх хөтөлбөр ✓ Холбон зуучлах ✓ Гэр бүлд нэгтгэх
9	ГССҮТ-НЦҮТ	<ul style="list-style-type: none"> ✓ 24-72 цаг байрлуулдаг. 	<ul style="list-style-type: none"> ✓ Хохирогч ирлээ шүүх эмнэлэгт хандаад гэмтлийн гаралтай эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлээд хорооны хамтарсан багийг дууддаг. ✓ Хорооны хамтарсан багийн ирээд уулздаг. ✓ Нөхцөл байдлын үнэлгээ хийдэг. ✓ Холбон зуучлах
10	Өмнөговь аймгийн Түр хамгаалах байр	<ul style="list-style-type: none"> ✓ Сэтгэл зүйн зөвлөгөө ✓ Эрх зүйн зөвлөгөө ✓ Нийгмийн халамжийн 	<ul style="list-style-type: none"> ✓ Илрүүлэх үйлчилгээ ✓ Нөхцөл байдлын үнэлгээ ✓ Холбон зуучлах
11	Дорноговь аймгийн Түр хамгаалах байр	<ul style="list-style-type: none"> ✓ Сэтгэл зүйн зөвлөгөө ✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ 	<ul style="list-style-type: none"> ✓ Илрүүлэх үйлчилгээ ✓ Нөхцөл байдлын үнэлгээ ✓ Холбон зуучлах

Хавсралт 3. Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх 8, 9 дүгээр тайланд өгсөн зөвлөмж ба түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Зөвлөмж	Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ
Зөвлөмжийн үндэслэл	
<p>Монгол Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, гэр бүлийн болон охид, эмэгтэйчүүд, хүйсийн цөөнхийн эсрэг хүчирхийллийг гэмт хэрэгт тооцож, тухайн хохирогчтой эвлэрсэн гэх замаар буруутай этгээд ял шийтгэлээс зайлсхийдэг байсныг халсныг Хороо талархан хүлээн авч байна. Түүнчлэн, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төсөлд гэр бүлийн хүчирхийлэл гэсэн нэр томъёог өргөжүүлж оруулсныг талархан хүлээн авлаа.</p> <p>Гэвч тус хуулийг батлуулах явц удаашралтай байгаад анхаарал хандуулж байна. Гишүүн оронд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн тоо өндөр байгаад Хороо анхаарал хандуулж, холбогдох статистик тоо мэдээлэл дутмаг байгаад сэтгэл зовниж байна. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэгжийг цагдаагийн байгууллагад байгуулсан хэдий ч гэмт хэргийн хохирогчдыг хамгаалах төрийн мэдлийн цорын ганц байр байгаад Хороо анхаарал хандуулах ёстой гэж үзэж байна.</p> <p>Түүнчлэн, хөгжлийн бэрхшээлтэй охид, эмэгтэйчүүдийн хувьд тэдгээр хамгаалах байр нь хүртээмжгүй байгаагийн улмаас тэд зохих дэмжлэг туслалцаа, үйлчилгээ авч чадахгүй байна.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй хохирогч эмэгтэйчүүдийн онцлог хэрэгцээ, эмзэг байдалд дэмжлэг үзүүлэх чиглэлээр цагдаагийн ажилтнууд, нийгмийн болон эрүүл мэндийн ажилтнуудад сургалт явуулдаггүй байна.</p>	
19	<p>Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн тухай 1992 оны 19 дүгээр Ерөнхий Зөвлөмжид дурдсанчлан, Гишүүн орныг дараах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг Хороо шаардаж байна. Үүнд:</p> <p>(а) Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн төслийг батлуулах явцыг яаравчлах, охид, эмэгтэйчүүдийн хүчирхийллээс сэргийлэх, шийдвэрлэх цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх, хүчирхийллийн хохирогчдын хохирлыг барагдуулах, хамгаалах, буруутай этгээдүүдийг илрүүлэх, зохих ёсны шийтгэл оногдуулах зэрэг арга хэмжээг нэн даруй авах;</p> <p>а) Монгол улс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр баталж, 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр шинэчлэн найруулсан байна. Энэхүү хуулиар гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоосон байна. Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын 11.7 дугаар зүйлд Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг хуульчилсан бөгөөд энэ зүйлийн 2 дахь хэсэгт энэ гэмт хэргийг хүүхэд, жирэмсэн эмэгтэй, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний эсрэг үйлдсэн бол хүндрүүлэхээр хуульчилжээ.</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор ТББ-ын оролцоог хангах, дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.</p>

**ХҮНИЙ БЭЛГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ, ХАЛДАШГҮЙ БАЙДЛЫН ЭСРЭГ ГЭМТ
ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

	<p>(b) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг эрүүгийн хэрэг болгон хуульчилсан хууль тогтоомжийг хатуу чанд хэрэгжүүлэх, гэмт хэргийн хохирогч болсон эмэгтэйчүүд, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн жендерийн мэдрэмжтэй журмуудын хэрэгжилтийг хангуулах ажилтнууд, шүүгч, прокурор, цагдаа зэрэг хууль сахиулах ажилтнуудын чадавхыг дээшлүүлэх албан ёсны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;</p>	<p>Шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр, сургалт нь жендерт суурилсан хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох, хууль тогтоомжийг чанд мөрдөх асуудлыг багтаасан эсэх АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-ын хэрэгжүүлсэн “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, нийслэл, 20 аймгийн цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн гишүүд зэрэг 980 хүнийг хамруулан зохион байгуулсан.</p> <p>“Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тэмцэхэд хууль зүйн салбарын чадавх, уялдаа холбоог бэхжүүлэх сургалт”-ыг зохион байгуулж, нийслэл, 21 аймгийн цагдаа, прокурор, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах Салбар зөвлөлийн гишүүд 1000 хүнийг хамруулан мэдлэг, ур чадварыг нь дээшлүүлсэн. Дотоод хэргийн их сургуулийн хичээлийн хөтөлбөрт сонгон үзэж байсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хичээлийг 2017 оны хичээлийн жилээс эхлэн заавал үзэх хичээлийн хөтөлбөрт оруулсан.</p>
	<p>(c) Хөдөө орон нутагт хамгаалах байр байгуулах, сэргээн засах үйлчилгээ үзүүлэхэд төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаагаа дээшлүүлэх замаар гэмт хэргийн хохирогч эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдэнд зохих туслалцаа үзүүлэх;</p>	<p>с) Монгол дахь жендерт суурилсан хүчирхийлэл/гэр бүлийн хүчирхийллийн тархалтын судалгааг 2017 онд 7300 гаруй эмэгтэйчүүдийн дунд зохион байгуулж, ойр дотно хүмүүс болон бусдын зүгээс эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэж буй хүчирхийллийн төвшнийг тогтоосон. Уг судалгааны үр дүнд үндэслэн гэр бүлийн хүчирхийлэл хамгийн их гардаг, хохирогч хамгааллын тогтолцоо хамгийн их шаардлагатай байгаа Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг, Баянзүрх, Хан-Уул дүүргүүдэд “Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төв”-үүдийг шинээр байгуулсан. Эдгээр төвийг шинээр байгуулахад орон нутгаас 623 сая төгрөг, НҮБ-ын Хүн амын сангийн хэрэгжүүлж буй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-өөс 764.5 сая төгрөг зарцуулсан. 2019 оны байдлаар үндэсний хэмжээнд Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгааллын нийт 14 түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний 15 төв ажиллаж байсан.</p>

	<p>(d) Гэр бүлийн, бэлгийн болон эмэгтэйчүүдийн эсрэг бусад хэлбэрийн хүчирхийлэлтэй холбогдсон статистик тоо мэдээг нас болон хохирогч ба буруутай этгээдийн харилцаа хамаарлын задаргаатайгаар гаргах;</p>	<p>Жендерийн үндэсний хороо (ЖҮХ), Үндэсний статистикийн хороотой хамтран Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль (2011) болон Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017)-т заасан хүйсээр ангилсан албан ёсны статистикийн болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй, хүртээмжтэй байдлыг хангах, жендерийн мэдээллийн сан бүрдүүлэх, нэгдсэн сүлжээ байгуулах, салбар, орон нутгийн хэмжээнд хүйсээр ангилсан статистикийн мэдээллийг бүрдүүлэх, жендерийн статистикийн мэдээллийг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаанд ашиглах аргачлал боловсруулах зорилгоор 2018 онд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллаж байна. Энэ зорилгын хүрээнд энэхүү зөвлөмжтэй холбоотойгоор Үндэсний статистикийн хорооны 1212.mn статистикийн мэдээллийн нэгдсэн цахим хуудаснаас “Жендер” гэсэн хэсгийг ЖҮХ-ны цахим хуудас руу холбож, англи, монгол хэл дээр жендерийн статистик үзүүлэлтүүдийг харах, хянах бололцоотой болсон⁷ байна.</p>
	<p>(e) Гэмт хэргийн хохирогч хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийн хувьд нөхөн сэргээх зохистой нөхцөлийг бүрдүүлэх.</p>	<p>Энэ талаар хэрэгжүүлсэн ажлын тайлан байхгүй байна</p>
<p>Зөвлөмжийн үндэслэл</p>		
<p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн хэрэгжилтийг зохицуулах зорилгоор хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудлаар салбар зөвлөлийг 2012 онд байгуулсныг Хороо онцлон тэмдэглэж байна. Гэвч Хороо дараах асуудалд анхаарал хандуулж байна. Үүнд:</p> <p>(a) Ядуу өрхийн охид, тэдний гэр бүлийн гишүүд хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж байгаагийн үндсэн шалтгааныг тогтоож шийдвэрлэх, хүний наймааны хохирогч болсон охид, эмэгтэйчүүдийг хамгаалах, тэдэнд чиглэсэн нөхөн сэргээх үйл ажиллагаа хангалтгүй байгааг шийдвэрлэхэд одоогийн хэрэгжиж байгаа хууль тогтоомж, хөтөлбөрүүдийн санхүүгийн хөрөнгө нөөц хязгаарлагдмал байна;</p> <p>(b) Хүн худалдаалахтай тэмцэх Үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдах явц удааширч байна.</p> <p>(c) Охид, эмэгтэйчүүдийг худалдаалах, бэлгийн мөлжлөгтэй холбогдсон гомдлын тоо, мөрдөн байцаалт, шүүх болон ял оногдуулах үйл ажиллагаа, түүнчлэн хохирогчдод туслалцаа үзүүлэх, нөхөн сэргээх хөтөлбөрүүдийн талаарх мэдээлэл хомс байна.</p> <p>(d) Хүний наймааны хохирогчдыг эрт илрүүлэх, тэдэнд чиглэсэн жендерийн мэдрэмжтэй арга замуудын ач холбогдлын талаар шүүх, хууль сахиулах байгууллага, хилийн хяналтын болон нийгмийн ба эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэг, мэдээлэл хангалтгүй байна.</p> <p>(e) Биеэ үнэлж буй эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, тэдний хэрэгцээнд нийцсэн хамгаалах байр байхгүй байгаа болон биеэ үнэлэхээс ангижрахыг хүсэж буй эмэгтэйчүүдэд чиглэсэн нийгэмших хөтөлбөрүүд хангалтгүй байна.</p>		

⁵⁴ Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс, НҮБ “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс” (хоёрдугаар боть), УБ, 2021 он, 641-642 дугаар хуудас;

	<p>(a) Хүн худалдаалахын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, холбогдох хууль, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хуваарилагдсан санхүүгийн хөрөнгө нөөцийг нэмэгдүүлэх;</p>	<p>(a) Засгийн газрын тогтоолоор “Хүн худалдаалахтай тэмцэх тухай үндэсний хөтөлбөр” улсын төсвөөс Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад 2018 онд 709.0 сая төгрөг, 2019 онд 506.0 сая төгрөгийг тус тус баталсан. Уг төсвөөс ТББ-уудын оролцоог хангах зорилгоор зарим ажлыг зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгүүлж, эдгээрт 2017 онд 16.9 сая төгрөг, 2018 онд 95.0 сая төгрөг, 2019 онд 125.3 сая төгрөгийн санхүүжилт тус тус хийсэн.</p>
<p align="center">21</p>	<p>(b) Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нэн даруй эцэслэн боловсруулж, батлах;</p>	<p>(b) МУ-ын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт мөнгө угаах, хүний наймаа, хар тамхи болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж тусгасны дагуу ХЗДХЯ “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” үндэсний хөтөлбөрийг боловсруулан Засгийн газрын 2017 оны 148 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон дээрх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх зорилгоор Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий дэд зөвлөлийг (2017) байгуулж хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна.</p>
	<p>(c) Шүүх, хил хяналтын цагдаа, хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон эрүүл мэндийн ба нийгмийн ажилтнуудыг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг эрт илрүүлэх, жендерийн мэдрэмжтэй аргаар ажиллах чиглэлээр чадавхыг нь дээшлүүлэх;</p>	<p>(c) Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдын хүн худалдаалах гэмт хэргийн талаарх ойлголт, мэдлэг, туршлага, чадавхыг үнэлэх судалгаа, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгаанууд хийгдсэн. Энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, хянан шийдвэрлэх, хохирогчид нөхөн сэргээх, хамгааллын үйлчилгээ үзүүлэгч цагдаа болон прокурор, хил хамгаалах, гадаадын иргэн харьяатын байгууллагын алба хаагч, шүүгч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, эрүүл мэндийн ажилтан нарыг мэргэшүүлэх, мэргэжил, ур чадварыг нь сайжруулах сургалтуудыг олон улсын байгууллагууд тухайлбал, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Азийн сан Олон улсын байгууллага, БНСУ-ын Засгийн газартай хамтран ажиллах гэрээний хүрээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллаж байна.</p>

	<p>(d) Охид, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийн гишүүдийн боловсрол ба эдийн засгийн боломжийг нэмэгдүүлснээр хүн худалдаалах гэмт хэргийн язгуур шалтгааныг шийдвэрлэх, ингэснээр тэдний хүн худалдаалагчдад мөлжлөгдөх эмзэг байдлыг бууруулах;</p> <p>(e) Биеэ үнэлэх үзэгдлийг шийдвэрлэх цогц арга хэмжээ авах, биеэ үнэлэхээс салах хүсэлтэй эмэгтэйчүүдэд зориулсан хамгаалах байр, хямралын үед дэмжлэг үзүүлэх төв, тэднийг нийгэмшүүлэх хөтөлбөр, орлого олох боломжийг бүрдүүлэх, түүнчлэн биеэ үнэлэх үзэгдлийн эрэлтийг бууруулах арга хэмжээ авах;</p>	<p>(d, e) биеэ үнэлэх, түүнээс үүдэх хор хөнөөлийг арилгах, охид, эмэгтэйчүүд, тэдний гэр бүлийнхэнд орон байр, боловсрол, эдийн засгийн боломжууд олгох, мөн биеэ үнэлэх дадлаа орхих хүсэлтэй байгаа эмэгтэйчүүдэд чиглэсэн хөтөлбөрт хамруулахад анхаарч буй байдал.</p> <p>Цахим орчин дах зохистой хэрэглээг бий болгох, хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, түүний дотор хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “UNFRIEND” тусгай арга хэмжээг зохион байгуулсан. Нөлөөллийн ажлын үр дүнд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдэж өөрсдийгөө энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн эсэх үнэлгээ, нөгөө талаас төрийн албан хаагч, үйлчилгээ үзүүлэгч нарыг гадаад болон дотооддоо илрүүлэх ур чадвар нэмэгдсэн.</p> <p>АНУ-ын Засгийн газрын санхүүжилттэй Азийн сан олон улсын байгууллагын хэрэгжүүлсэн “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: албан хаагчдыг чадавхжуулах нь” төслийн хүрээнд “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулж, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан бэлтгэн боловсруулсан.</p>
	<p>(f) Охид, эмэгтэйчүүдийн наймаа, ялангуяа хүний наймаачдыг шүүсэн, ял оногдуулсан хэрэг болон биеэ үнэлж буй эмэгтэйчүүдтэй холбогдсон цогц тоо мэдээ, мэдээллийг дараагийн ээлжит тайландаа оруулах.</p>	<p>(f) эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн талаарх монгол улсын ээлжит аравдугаар илтгэлд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэргийн тоо, шийдвэрлэсэн байдал, Хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлтийн тоон мэдээг тусгасан байна.</p>

